



Consulate of Mongolia
in Busan



International Conference MIYR - 2021

*May 28-29, 2021
Seoul, South Korea*

**Spring
Conference
Proceedings**



<http://youngres.com>

ISBN: 978-9919-24-786-7

Call for the papers

“The First International conference of Misheel Institute 2021”

28~29 May, South Korea

Welcome to the International Conference for Young Researchers

TFICMI- 2021 is being organized by *Misheel Institute for Young Researchers*.

Aim of the conference:

The conference aims to build an international platform for the researchers to share their research findings with global audience, to improve the connection between theoretical and practical knowledge, to offer a networking opportunity for researchers and industrial participants, company representatives, to open opportunities to participate in projects and programs.

International Conference for Young Researchers welcomes submissions on areas including (but not limited to):

- Topic 1.** Information Technology
- Topic 2.** Bio Technology
- Topic 3.** Humanities
- Topic 4.** Physical sciences and Engineering
- Topic 5.** Health sciences
- Topic 6.** Social sciences
- Topic 7.** Environmental sciences/Geology
- Topic 8.** Others

General evaluation criteria for the best work:

- ✓ Theory and methodology used for the research is appropriate and scientific
- ✓ Methodology used for the research is clear and data used for analysis are appropriate
- ✓ Suggested idea/solution is practical
- ✓ Presentation can be prepared by group or individual researcher. Has to have a supervisor.
- ✓ Presentation should be 15minutes, 5 minutes Q&A session in ppt format.
- ✓ Article writing standards of the institute has be strictly followed

Important Dates:

- Abstract submission deadline(1-2p): **12th - 18th April 2021**
- Full paper submission deadline(8-15p, MC-Word): **10th - 17th May 2021**
- Conference dates: **28th - 9th May 2021**

Please send following documents to info@youngres.com,

*Abstract and full paper, *Registration fee receipt, *Application form

Phone number : 010-8431-8408/Korea/, 77-858-388/Mongolia/

Call for the papers of the Conference

“The 1th International conference 2021”

28~29 May, Korea

“Залуу Судлаачдын Мишээл Хүрээлэн”-гээс зохион байгуулж буй олон улсын болон монголын их дээд сургуулиудын магистр, докторант мөн залуу судлаачдын дунд эрдэм шинжилгээний шилдэг илтгэл, бүтээлийг шалгаруулах “АНХДУГААР БАГА ХУРАЛ-2021” нь 2021 оны 05 дугаар сарын 28-29нд зохион байгуулна.

Aim of the conference:

Оюутнуудыг Олон улсын судалгаа шинжилгээний ажилд идэвхитэй оролцуулах, тэдний эрдэм шинжилгээний ажил, бүтээлийг нийтэд таниулах, дэмжих, бүтээлч сэтгэлгээг бий болгохоос гадна багш оюутны хамтын ажиллагааг хөгжүүлэх, онол практикийн мэдлэгийн уялдаа холбоог сайжруулах, оюутнуудын бүтээлийг ажил олгогчдод танилцуулах, төсөл хөтөлбөрт хамруулах боломж бололцоог бий болгоход оршино.

Conference Topics:

- Topic 1. Information Technology
- Topic 2. Bio Technology
- Topic 3. Cultural Technology
- Topic 4. Mechanical Technology
- Topic 5. Medical science
- Topic 6. Social Technology
- Topic 7. Natural, Geographical science
- Topic 8. Other

Шилдэг бүтээлд тавигдах ерөнхий шаардлага:

- ✓ Судалгааны ажил нь шинжлэх ухааны онол, арга зүйд үндэслэгдсэн байна.
- ✓ Судалгаа шинжилгээний тодорхой арга зүй, арга техникийг хэрэглэсэн байхын зэрэгцээ тооцооллыг бодит өгөгдөл дээр тулгуурлан хийсэн байна.
- ✓ Илтгэлд дэвшүүлсэн санаа оновчтой, практикт хэрэгжих боломжтой байх.
- ✓ Илтгэлийг ганцаарчилсан болон багаар бэлтгэж болох бөгөөд заавал удирдагч багштай байна.
- ✓ Илтгэлийг PPT хэлбэрээр бэлтгэх ба илтгэх хугацаа 15 минут, хэлэлцэх хугацаа 5 минут байна.
- ✓ Өгүүллийг хүрэнлэнгийн “Өгүүлэл бичих стандарт”-ын дагуу бичиж ирүүлнэ.

Important Dates:

- Abstract submission deadline(1-2p): **2021-04.12-18**
- Full paper submission deadline (8-15p, MS-Word) : **2021- 05. 10-17**
- Conference day: **2021-05. 28-29**

Судалгааны ажлын хураангуй 1ш, бүртгэлийн хураамжийн баримт 1ш, Анкет 1ш-ын хамт misheelinstitute@gmail.com илгээнэ. Холбоо барих : 010-8431-8408/Солонгос/, 77-858-388/Монгол/

INTERNATIONAL CONFERENCE- MIYR 2021

28~29, May

Schedule/28, May/

10:50~11:00	Participant registration		
11:00~11:05	G. Khongorzul/ President/		
11:05~11:10	G. Gandulam/Vice President/		
Offline presentation in Seoul (5/28)			
Time	Paper ID	Paper Title	Presenter
11:15~11:30	SSPS-02	Voting Behavior and Political Support of Mongolian Voters: The 2020 Mongolian Legislative Election	E. Sarantsetseg
11:40~11:55	SSBA-07	Мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх боломж: Монгол улс	A. Purevdulam
12:05~12:20	BTES-08	Stabilization of Pb, Zn and Cd contaminated soils using calcium carbonate, sodium hydroxide and waste cow bone	S. Saruul
12:30~12:45	NGCH-17	Selective Removal of Radioactive Materials from contaminated Water using Natural zeolites	B. Battsetseg
12:55~13:10	SSES-18	The effect of FDI on the economic performance of Asian developing countries	A. Gandolgor
13:20~13:35	ITOS-19	Golf swing recognition device using IMU Sensors	Ts. Tselmeg
13:45~14:00	WongJon Kim Professor Presentation Video/GNU/		
14:00~14:30	Randy Green Professor Presentation ZOOM/GNU/		
14:30~16:00 Lunch and Coffee Time			
Online Presentation ZOOM(5/28)			
Time	Paper ID	Paper Title	Presenter
11:15~11:30	HSFS-15	Монгол оюутны чөлөөт цагийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа	P. Baasanjargal
11:40~11:55	HSFA-16	Хөгжмийн урлагийн хэрэглэгчийн зан төлөвийн судалгаа	P. Baasanjargal
12:05~12:20	SSLS-11	A comparative study on Legal person insolvency” –Focus on Mongolian and Korean proceedings	B. Gereltuya
12:30~12:45	HST-25	Local Citizen’s Opportunity to Develop “Sand Tourism” in Elsen Tasarkhai Area	S. Munkhnasan
12:55~13:10	SSBA-03	A need for gaining knowledge and skills of change management	P. Anar
13:20~13:35	WongJon Kim Professor Presentation Video/GNU/		
13:35~14:00 Free Time			
14:00~14:30	Randy Green Professor Presentation ZOOM/GNU/		
14:30~14:40 Last Greeting			

Schedule/29, May/

<http://youngres.com>

Video Presentation (5/29)		
Paper ID	Paper Title	Presenter
SSBA-09	Using digital marketing effectively in brand developmen	E. Erdenchimeg
SSBA-10	Ways of effective marketing strategies implemented by the business entities during the COVID-19 pandemic	E. Erdenchimeg
SSBA-13	The Comparison of Educational Service Quality Between Mongolian and Korean Universities	G. Bilegjargal
SSLS-14	Ковид 19 цар тахлын үед гадаад шилжих хөдөлгөөнд тулгарч буй асуудал	Ts. Munkhsatsral
ETSP-20	Current Status of Green Facilities in Ulaanbaatar	B. Batsuren
SSBA-22	The study of Art design in Product	Chen Shengcnen
SSBA-23	The effect of the incentive system on hospital workers entrepreneurship and innovation performance	Muhammad Ayaz
SSLS-6	Цар тахлын үеийн нийгмийн даатгалын шимтгэлийн эрх зүйн зохицуулалт, үр нөлөө	Ts. Munkhdelger
SSES-04	Study of comparison of VAT rate (Mongolia)	B. Bayasgalan
GSES-21	Scientific base for increasing volume and ecological and economic assessment of scots pine plantation (Pinus sylvestris L.) In mongolia	Shurentsetseg

Table of Contents

SSBA-03.....	1
SSES-04.....	6
SSLS-06.....	17
SSBA-07.....	24
HSFS-15.....	32
HSFS-16.....	50
ITOS-19.....	65
ETCP-20.....	77
HST-25.....	85
GSES-21.....	94
BTES-08.....	102
NGCH-17.....	103
SSBA-09.....	104
SSBA-10.....	115
SSBA-23.....	125
SSBA-13.....	136
SSPS-02.....	151
SSLS-11.....	157
SSES-18.....	171
SSLS-14.....	187
SSBA-22.....	191

SSBA-03

Өөрчлөлтийн удирдлагын мэдлэг, ур чадвар эзэмшихийн хэрэгцээ шаардлага

Anar Purvee¹, Sonintamir Nergui²

*Пүрэвээгийн Анар¹, Доктор, ахлах багш, МУИС, p.anar@num.edu.mn (1-р зохиогч)
Нэргүйн Сонинтамир², Доктор, профессор, МУИС, nsonintamir@num.edu.mn (Хамтарсан зохиогч)*

Corresponding author: Anar Purvee

Abstract: In today's evolving society, the ability to adapt to any changes in the external environment is one of the key leadership skills of an organization. In this global pandemic time, real-life examples show that knowledge and skills of organizational change management serve as a guarantee of their survival and become a key factor in their future development and success. Change management is not a short-term process of improving something, but a process of long-term planning, management and leadership for continuous development of an organization. An organization with knowledge of change management is always ready for any risks and opportunities, and continues to provide its members (employees) with the skills to adapt to any changes, innovations and developments. Organizations that implement change management are constantly improving and changing their activities in order to achieve their vision and goals. In this regard, this article discusses some aspects of theoretical issues of change management and leadership and their potential results to organizations. Therefore, this article contributes to the process of raising public awareness of the need for organizations to be prepared for any future change, which is to have knowledge and skills of change management.

Keywords: Change management; Continious change; Leadership; Organizational development

Хураангуй: Хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд гадаад орчны аливаа өөрчлөлт шинэчлэлд дасан зохицох чадвар нь байгууллагын удирдлага, манлайллын гол ур чадваруудын нэгээхэн хэсэг болоод байна. Дэлхий нийтийг хамарсан энэхүү цар тахлын үед байгууллагын өөрчлөлтийн удирдлагын мэдлэг, ур чадвар нь тэдний оршин тогтнох баталгаа, мөн цаашдын хөгжил болоод амжилтад нь нөлөөлөхүйц гол хүчин зүйл болдог талаарх бодит жишээнүүдийг харуулсаар байна. Өөрчлөлтийн удирдлага нь богино хугацаанд хийгдэх ямарваа нэг зүйлийг сайжруулах үйл явц биш, харин байгууллагыг тасралтгүй хөгжүүлэх талаарх урт хугацааны төлөвлөлт, удирдлага, манлайллын үйл явц юм. Өөрчлөлтийн удирдлагын мэдлэг чадвартай байгууллага нь аливаа эрсдэл ба боломжид байнга бэлэн байдаг бөгөөд аливаа өөрчлөлт, шинэчлэл, хөгжилд дасан зохицох ур чадваруудыг гишүүддээ (ажил эрхлэгчдэдээ) олгосоор байдаг. Өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлж буй байгууллага нь алсын хараа, зорилго зорилтууддаа хүрэхийн төлөө, ирээдүйд хүрэхээр төлөвлөж буй төлөв байдлаа бодитоор бий болгохын тулд өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлж, шаардлагатай үйл ажиллагаануудаа сайжруулан шинэчилсээр байдаг. Иймд энэхүү өгүүллийн хүрээнд байгууллагын өөрчлөлт, хөгжлийн удирдлага, манлайллын хэрэгцээ шаардлага, хүрч болохуйц үр дүнгүүдийн талаарх онолын асуудлуудыг хэлэлцүүлээ. Ингэснээр энэхүү өгүүлэл нь цаашдын ямарваа нэг өөрчлөлтөд байгууллагуудын бэлэн байх чадвар буюу өөрчлөлтийн удирдлагын мэдлэг чадварыг эзэмших хэрэгцээ шаардлагыг олон нийтэд таниулах үйл явцад хувь нэмрээ оруулж байна.

Түлхүүр үг: Байгууллагын хөгжил; Манлайлал; Өөрчлөлтийн удирдлага; Тасралтгүй хөгжил

1. Удиртгал

Олон улсын бизнесийн салбарын эрдэмтэн судлаач нар бизнесийн байгууллагуудын гадаад орчин улам бүр тогтворгүй болж, өрсөлдөөний орчин улам бүр эрчимжиж, энэ нь олон улс даяар үйл ажиллагаа явуулж буй бизнесийн ба бизнесийн бус бүх төрлийн байгууллагуудын үйл ажиллагаанд эерэг болон сөрөг, олон төрлийн нөлөөлөл үзүүлсээр байгааг онцолсоор ирсэн [1]. Ийм нөхцөл байдалд байгууллагууд аливаа өөрчлөлтөд дасан зохицох, цаашдын оршин тогтнол, өрсөлдөөн, хөгжлийн төлөөх үйл ажиллагаануудаа амжилттай явуулахын тулд өөрчлөлт, хөгжлийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадвар эзэмших зайлшгүй шаардлагатай нүүр тулсаар байна [1], [2].

Нэн ялангуяа энэ цаг үе байгууллагын өөрчлөлт, хөгжлийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадварын хэрэгцээ шаардлагын өөр нэгэн чухал шалтгааныг олон нийтэд дэлгэн харуулж байна. Байгууллагууд өөрсдийнхөө үйл ажиллагааны болоод стратегийн төлөвлөгөөндөө тусгах боломжгүй байсан гадаад орчны гэнэтийн өөрчлөлт буюу Ковид-19 цар тахлын үр дагаварт байгууллагууд *оршин тогтнохын тулд дасан зохицох уу?*, эсвэл *хаалгаа барих уу?* гэсэн туйлын эрсдэлтэй сонголтуудтай нүүр тулаад байна.

Ямарваа нэг өөрчлөлтөд нээлттэй байсан байгууллагууд нь оршин тогтнохын төлөө үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн үлдэж, нэн шаардлагатай өөрчлөлтүүдийг хийж гүйцэтгэж байна. Харин өөр олон төрлийн байгууллагуудын ашиг орлого нь зогсож, зарим нь хаалгаа барихаас өөр гарцгүй болсоор байгааг бид хаа сайгүй харсаар байна. Иймд энэхүү өгүүлэл нь байгууллагын өөрчлөлт, хөгжлийн удирдлага, манлайллын хэрэгцээ шаардлага, хүрч болохуйц үр дүнгүүдийн талаарх онолын асуудлуудыг хэлэлцүүлээ.

2. Онолын хэлэлцүүлэг

2.1 Байгууллагын өөрчлөлт, хөгжлийн удирдлагын хэрэгцээ шаардлага, үр дүн

Байгууллагууд өөрчлөлт, хөгжлийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадвар эзэмшсэн байх шаардлагатай гэдгийг харуулдаг нэг чухал шалтгаан нь даяаршлын нөлөөлөл байдаг. Даяаршлын хөгжил дэвшил, үр нөлөөлөл дэлхий даяар олон зуун жил үргэлжилж байгаа боловч сүүлийн үеийн чиг хандлага нь дэлхий дэх социалист системийн задрал, мэдээлэл технологийн дэвшилттэй шууд холбоотой байдаг [1], [3], [4].

Даяаршил нь дэлхий даяар улам бүр эрчимжихийн хэрээр ашгийн төлөө ба ашгийн төлөө бус бүх төрлийн байгууллагуудын үйл ажиллагаанд нөлөөлж, байгууллагуудыг өөр хооронд нь улам бүр хамааралтай болгож, өрсөлдөөний орчныг улам бүр тэнцвэргүй болгосоор байна [1]. Үүний үр дүнд дэлхий дээрх зах зээлүүд улам бүр жижгэрч, нэг нэгээсээ эдийн засаг, нийгэм, экологийн хувьд харилцан хамааралтай болж, шинэ зах зээлүүд үүсэж, мөн бизнесийн шинэ эрсдэлүүд бий болсоор байна [2].

Гэвч эрдэмтэн судлаач нарын онцолж буйгаар бол даяаршлын үр өгөөж нь тэгш бус байдлыг бий болгодог бөгөөд илүү хүчирхэг талуудад буюу илүү хөгжингүй улс орнуудад даяаршлын эрх мэдэл, ашиг хонжоо, үр өгөөжийн давуу талуудыг бий болгосоор байна [3], [5]. Үр дагаварт нь олон улсын бизнесийн салбарууд үндэстэн дамнасан, томоохон корпорацуудын эрх мэдэлд орж, тэдний гаргаж буй тоглоомын дүрмүүдээр тус салбарууд зохицуулагдсаар байна [1].

Үүнтэй холбоотойгоор Дэлхийн Худалдааны Байгууллагын 2020 онд гаргасан *Дэлхийн Худалдааны Статистик Тойм* тайланд тусгаснаар 2019 онд хийгдсэн олон улсын худалдааны дийлэнх нь Хойд Америк, Европ, Ази тивд өрнөсөн байна [6]. Нэн ялангуяа олон улсын үйлчилгээний худалдааны хувьд үйлчилгээний худалдаагаар тэргүүлэгч 10 улс орон (1. АНУ, 2. Англи, 3. Герман, 4. Франц, 5. Хятад, 6. Нидерланд, 7. Ирланд, 8. Энэтхэг, 9. Сингапур, 10. Япон) дэлхий нийтийн үйлчилгээний худалдааны 54.2%-ийг бүрдүүлж, бусад улс орнууд 45.8%-ийг бүрдүүлсэн байна [6]. Иймд даяаршлын нөлөөн дор явагдаж буй гадаад орчны тогтворгүй байдал, нэн ялангуяа үр өгөөжийн эрх тэгш бус нөхцөл байдалд (жишээлбэл, Монгол улс шиг хөгжиж буй улс орнуудаас оролцож буй нөхцөл байдал) үйл ажиллагаагаа явуулж буй байгууллагууд оршин тогтнохын тулд ямарваа нэг өөрчлөлтөд тасралтгүй дасан зохицож байх, мөн өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлж байх зайлшгүй шаардлагатай байна гэдгийг энэхүү онолын хэлэлцүүлэг харуулж байна.

Цаашилбал, даяаршлын давлагаатай цуг өрнөсөөр байгаа мэдээллийн технологийн өөрчлөлт нь мөн адил байгууллагуудын өөрчлөлт, хөгжилд нөлөөлсөөр байна. Цахим худалдаа, цахим бизнес, цахим орчин нь байгууллагуудын үйл ажиллагаагаа явуулсаар ирсэн хуучны арга барилуудыг өөрчилж, интернетийн тусламжтайгаар мэдээллийг илүү амар хялбар, хямдхан олох тусам байгууллагын бүтэц, үйл ажиллагаанд өөрчлөлт гарсаар байна [1], [2], [4]. Мэдээллийн технологийн хувьсан өөрчлөгдөж буй энэхүү нөхцөл байдалд байгууллагууд мөн дасан зохицох чадвараа нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай нүүр тулаад байна.

Дээр дурдагдсан даяаршил болон мэдээллийн технологийн нөлөөллийг байгууллагын өөрчлөлт, хөгжлийн онолын үүднээс авч үзвэл байгууллагуудын хувьд тодорхой хэмжээнд урьдчилан таамаглаж болохуйц орчны өөрчлөлтийн нөлөөллийн хүчин зүйлс юм [2]. Өөрөөр хэлбэл байгууллагууд эдгээр хүчин зүйлсэд тохируулан өөрсдийн өөрчлөлт, хөгжлийн талаарх удирдлага, манлайллын үйл ажиллагаануудаа хэрэгжүүлэх боломжтой байдаг.

Байгууллагын өөрчлөлт, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг харуулдаг энэхүү салбар нь сүүлийн 60-аад жилийн туршид идэвхтэй судлагдаж буй онол практикийн нэгэн салбар юм [2], [7]. Энэхүү салбарын мэдлэг нь аливаа байгууллагын төлөвлөгөөт өөрчлөлтийг хэрхэн үр дүнтэй, үр бүтээмжтэй хэрэгжүүлэх талаарх асуудлуудыг авч үздэг. Ингэхдээ ашиг орлого, эдийн засгийн үр өгөөжөөс гадна нийгмийн өмнө, хүрээлэн буй орчны өмнө, дэлхий нийтийн хөгжлийн өмнө хүлээх харууллага гэх мэт олон төрлийн үр дүнгүүдэд хүрэх зорилготой асуудлуудад анхаарлаа хандуулдаг онцлог салбар юм [2], [7].

Дэлхий нийтийг хамарсан энэхүү цар тахлын нөхцөл байдал нь байгууллагын *төлөвлөгөөт өөрчлөлтийн ойлголт*од багтахгүй мэт ойлгогдож болох хэдий ч өөрчлөлт, хөгжлийн удирдлагын мэдлэг чадвартай байгууллага нь аливаа эрсдэл ба боломжид байнга бэлэн байдаг бөгөөд аливаа өөрчлөлт, шинэчлэл, хөгжилд дасан зохицох ур чадваруудыг гишүүддээ (ажил эрхлэгчдэдээ) байнга олгож, *тасралтгүй өөрчлөлт, хөгжлийн үйл явцыг* өөртөө бий болгосоор байдаг.

Иймд урьдчилан таамаглаж болохуйц болон үл таамаглаж болохуйц олон төрлийн өөрчлөлтийн нөлөөн дор байгууллагын оршин тогтнох баталгаа, цаашдын хөгжил болоод амжилт нь тэдний өөрчлөлт, хөгжлийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадвараас шууд хамааралтай байдаг [2], [7]. Өөрчлөлтийн удирдлага нь богино хугацаанд хийгдэх ямарваа нэг зүйлийг сайжруулах үйл явц биш, харин байгууллагыг тасралтгүй хөгжүүлэх талаарх урт хугацааны төлөвлөлт, түүнийг удирдах, хэрэгжүүлэх талаарх манлайллын үйл явц юм. Иймд энэхүү өгүүллийн дараагийн хэсэг өөрчлөлтийн манлайллыг хэрэгжүүлэхийн хэрэгцээ шаардлага, энэ нь өөрчлөлтийн менежмент, удирдлагын асуудлуудаас хэрхэн ялгагддаг, мөн өөрчлөлтийн манлайллыг үр дүнтэй хэрэгжүүлбэл ямар үр дүнгүүдэд хүрэх боломжтой талаар хэлэлцүүлээ.

2.2 Өөрчлөлтийн манлайллын хэрэгцээ шаардлага, үр дүн

Манлайлал гэх ойлголт нь олон улс даяар олон төрлийн чиглэлээр судлагдсаар ирсэн [8-10]. Эрдэмтэн, судлаач Northouse (2015)-ийн нэгтгэсэнээр:

1. Шинж чанарын онолууд: Эртний хаадын манлайлал, нэрт удирдагчдын манлайлал, манлайлагчийн гол шинж чанарууд гэх мэт сэдвүүд 1900 – 1940 он, мөн 1960 оноос хойш судлагдаж байна.
2. Зан төлөвийн онолууд: Манлайлагч хүн ямар зан төлөвтэй байдаг вэ? гэсэн сэдэв 1930 – 1960 оны хооронд судлагдсан.
3. Нөхцөл байдлын онолууд: Ямар нөхцөлд, ямар хүмүүсийг хэрхэн манлайлах вэ? гэсэн сэдэв 1960 – 1990 оны хооронд судлагдсан.
4. Харилцааны онолууд: Манлайлагч болон дагагчид хоорондын харилцааны холбооны талаарх судалгаанууд 1990 оноос хойш судлагдаж байна.
5. Шинэ онолууд (манлайллын хэв маягууд): Манлайлал нь байгууллага болон хувь хүмүүст ямар өөрчлөлт шинэчлэлүүдийг хэрхэн авчирдаг талаарх судалгаанууд 1980 оноос хойш хийгдсээр байна. Жишээлбэл, алсын хараатай манлайлал (visionary), хувьсан өөрчлөлтийн манлайлал (transformational) гэх мэт.

6. Эрчимтэй хөгжиж буй онолууд: Үнэнч манлайлал (authentic), сүсэг бишрэлийн манлайлал (spiritual), жэндэр ба манлайлал, соёлын болон глобал онолууд гэх мэт ойлголтууд нь 2000 оноос хойш судлагдаж байна.

Дээр дурдагдсаны дагуу манлайлал гэх ойлголт нь олон төрлөөр судлагдаж, олон янзын тодорхойлолт гарсан бөгөөд судлаач Blackmore (2013)-ийн онцолсноор, “сайн манлайлал гэдэг нь бидний мэддэг зүйл мөн боловч яг таг тодорхойлоход хэцүү байдаг зүйл юм” гэж үзсэн (х. 139) [11]. Түүний үзэж буйгаар, манлайллын талаарх ойлголт нь хэн нэгэн нь нөгөөгөөсөө илүү эрх мэдэлтэй байх дээр төвлөрөхөөс илүүтэйгээр *хамтын эрх мэдэл* гэх ойлголт дээр төвлөрөх шаардлагатай гэж үзсэн. Өөрөөр хэлбэл хувь хүний манлайллаас илүүтэйгээр хамтын манлайллын асуудалд анхаарлаа хандуулах нь байгууллагын хувьд илүү үр дүнтэй байдаг гэж үзсэн. Иймд манлайлал гэдэг нь "хүндэтгэл ба итгэлцэл дээр суурилсан, хамтын зорилгынхоо төлөө хамтдаа хөдөлмөрлөх харилцаа холбооны талаарх асуудал юм" (х. 151) [11].

Үүнтэй холбоотойгоор өөрчлөлт, хөгжлийг үр дүнтэйгээр удирдахад өөрчлөлтийн манлайллын үйл явц шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл өөрчлөлтийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд сайн удирдлага, менежментийн үйл явц шаардагдах боловч түүнээс илүүтэйгээр үр дүнтэй манлайллын үйл явц шаардагддаг [12]. Өөрөөр хэлбэл өөрчлөлтийн удирдлагыг хэрэгжүүлж буй байгууллага нь алсын хараа, зорилго зорилтууддаа хүрэхийн төлөө, ирээдүйд хүрэхээр төлөвлөж буй төлөв байдлаа бодитоор бий болгохын тулд өөрсдийгөө тасралтгүй хөгжүүлж, шаардлагатай үйл ажиллагаануудаа сайжруулан шинэчилсээр байдаг. Гэхдээ энэхүү үйл явцыг бодитой болгох эсэх нь өөрчлөлтийн манлайллын үйл явцаас шууд хамаардаг [2], [7], [12].

Өөрчлөлтийн манлайллын хүрээнд сэтгэл хөдөлгөм алсын хараа дэвшүүлэх, түүнд хүрэх стратеги боловсруулах, тухайн өөрчлөлтийн үйл явцад ажилчдыг урамшуулах, урам зориг өгөх үйл явц хэрэгждэг бол өөрчлөлтийн менежментийн хүрээнд өөрчлөлттэй холбоотой хүндрэлтэй асуудал, даалгавар, зорилтуудыг биелүүлэх үйл явц хэрэгждэг [7]. Товчоор бол менежмент гэдэг нь аливаа даалгаврыг зөвөөр гүйцэтгэж байгаа үйл явц, харин манлайлал гэдэг нь зөв зүйлийг хийж байгаа үйл явцыг хэлдэг [13]. Менежментийн үр дүн нь тогтвортой байдлыг бий болгодог бол манлайллын үр дүн нь өөрчлөлт бий болгодог; менежмент илүү үүрэг даалгавар дээр тулгуурладаг бол манлайлал илүү хүмүүс дээр тулгуурладаг [13]. Иймд өөрчлөлтийн манлайлал нь хамтын манлайллын үйл явцын талаарх ойлголт юм.

Cummings and Worley нар өөрчлөлтийн манлайллыг хэрэгжүүлэх 5 үе шатыг тодорхойлсон байдаг [2]. Үүнд:

1. Өөрчлөлтийг өдөөх буюу мотивац бий болгох. Байгууллагын гишүүд өөрчлөлтийг хэрэгжүүлэх зайлшгүй шалтгаан бий гэдэгт итгэхгүй бол өөрчлөлтийн үйл явцыг дэмждэггүй.
2. Алсын хараа бий болгох. Хүмүүсийн хүрэхээр зорьж буй ирээдүйн талаарх үзэл баримтлал эсвэл тухайн байгууллагыг ямар харагдуулахыг хүсэж байгаа талаарх хүсэл мөрөөдлийг илэрхийлдэг. Алсын хараа ойлгомжтой байх тохиолдолд хүмүүс өөрчлөлтийн үйл явцад идэвхтэй оролцдог.
3. Улс төрийн дэмжлэг бий болгох. Өөрчлөлтийн үр дүнд ямар бүлэг хүмүүсийн эрх мэдэл, ашиг хонжоо буурах гэж байна, эсвэл өсөх гэж байна гэх байгууллагын доторх улс төрийн асуудлыг таньж мэдэх, эрх мэдэх өсөх талаас дэмжлэг туслалцаа авах замаар өөрчлөлтийн үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлдэг.
4. Шилжилтийг удирдах. Өөрчлөлт нь одоогийн нөхцөлөөс ирээдүйн төлөв байдал руу шилжих шилжилт хөдөлгөөнийг хамардаг тул шилжилтийн цаг хугацаа шаардагддаг бөгөөд энэ нь ихэнх тохиолдолд урт хугацаанд үргэлжилдэг. Иймд урт хугацааны туршиж шилжилтийг хэрхэн удирдах талаарх төлөвлөгөөтэй байх шаардлагатай байдаг.
5. Инерцийг хадгалах. Өөрчлөлтийн үйл явц хугацаа их шаарддаг тул өөрчлөлтийн талаарх анхны сэтгэгдэл, сэтгэл хөдлөл, хөөрөл, үйл ажиллагаанууд алгуур унтардаг. Иймд өөрчлөлтийг хэрэгжүүлэх үед эрч хүч, хүчин чармайлтыг хадгалахад анхаарлаа хандуулж, инерцийг хадгалах арга техникүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байдаг.

Ингээд аливаа байгууллага өөрчлөлтийн менежмент, манлайллын үйл явцыг зөв зохистой, тасралтгүй хэрэгжүүлснээр дараах үр дүнгүүдэд хүрэх боломжтой:

1. Байгууллага өөрийнхөө асуудлуудыг өөрөө шийдэж чаддаг болох, аливаа өөрчлөлтөд бэлэн байх, өөрийгөө байнга хөгжүүлж чадах мэдлэг, ур чадвартай болох. Энэхүү үр дүнд хүрэхийн тулд

байгууллага гишүүддээ шаардлагатай мэдлэг ур чадварыг олж авахад нь тасралтгүй туслах үйл явц хэрэгждэг.

2. Санхүү болон техникийн өндөр гүйцэтгэлтэй байх. Жишээлбэл, бизнесийн байгууллагын гол зорилго болох ашиг орлого өндөртэй байх, борлуулалтын өсөлттэй байх, зах зээлд чанартай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ нийлүүлэх, өндөр бүтээмжтэй ажилладаг байх гэх мэт.
3. Идэвхтэй, сэтгэл хангалуун, суралцах хүсэл тэмүүлэлтэй боловсон хүчинтэй байх. Энэ нь улмаар сэтгэл ханамжтай үнэнч үйлчлүүлэгчид, хөрөнгө оруулагчдыг бий болгож, байгууллагын удирдлага манлайллын асуудлыг үр дүнтэй хэрэгжүүлэх үйл явцыг дэмжиж өгдөг.

Ийнхүү хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд гадаад орчны аливаа өөрчлөлт шинэчлэлд дасан зохицох чадвар нь байгууллагын удирдлага, манлайллын гол ур чадваруудын нэгээхэн хэсэг болдог бөгөөд тус үйл явцыг үр дүнтэй хэрэгжүүлэх нь тухайн байгууллагын өөрчлөлтийн удирдлага, манлайллын мэдлэг ур чадвараас шууд хамааралтай байдаг.

5. Дүгнэлт

Энэхүү өгүүллийн хүрээнд байгууллагын өөрчлөлт, хөгжлийн удирдлага, манлайллын хэрэгцээ шаардлага, хүрч болохуйц үр дүнгүүдийн талаарх онолын асуудлуудыг хэлэлцүүлээ. Байгууллагын урьдчилан таамаглаж болохуйц, төлөвлөж болохуйц өөрчлөлтийн хүчин зүйлсэд даяаршил, мэдээллийн технологийн хөгжлийн нөлөөг авч үзлээ. Харин өнөө цаг үед тулгамдаад буй цар тахлын гэнэтийн өөрчлөлтийн энэ үед байгууллагын оршин тогтнох боломж нь тэдний өөрчлөлтөд бэлэн байсан байдал, өөрчлөлтийн удирдлагын талаарх мэдлэг, ур чадвараас шууд хамааралтай байгаа талаар хэлэлцүүлээ. Мөн өөрчлөлтийн удирдлага нь өөрчлөлтийн манлайллын үйл явцын тусламжтайгаар үр дүнтэйгээр хэрэгждэг талаар авч үзлээ. Ингэснээр энэхүү өгүүлэл нь цаашдын ямарваа нэг өөрчлөлтөд байгууллагуудын бэлэн байх чадвар буюу өөрчлөлтийн удирдлага, манлайллын мэдлэг, ур чадварыг эзэмшихийн хэрэгцээ шаардлагыг олон нийтэд таниулах үйл явцад хувь нэмрээ оруулж байна.

Ашигласан материал

- [1] D. A. Ball, M. Geringer, M. S. Minor, J. M. McNett. (2012), "International business: The challenge of global competition," McGraw-Hill Education.
- [2] T. G. Cummings and C. G. Worley. (2015), "Organization development and change," Cengage learning.
- [3] Baek, I., and Shi, Q. (2016), "Impact of economic globalization on income inequality: Developed economies vs emerging economies," *Global Economy Journal*, 16(1), pp. 49-61.
- [4] M. B. Steger. (2017), "Globalization: A very short introduction." Oxford University Press.
- [5] Lang, V., and Mendes Tavares, M. (2018), "The distribution of gains from globalization," *IMF working paper*.
- [6] World Trade Organisation, (2020), World Trade Statistical Review 2020, https://www.wto.org/english/res_e/statis_e/wts2020_e/wts20_toc_e.htm
- [7] П.Лююки. (2014), "Өөрчлөлт, шилжилтийг удирдах нь", Сүүн Сувд ХХК, Улаанбаатар хот.
- [8] Allio, R. J. (2016), "Learning to be a leader," *Strategy & Leadership*, 44(4), pp. 3-9.
- [9] B. M. Bass and R. R. Bass. (2008), "The Bass handbook of leadership: Theory, research, and managerial applications," New York: Free Press.
- [10] P. G. Northouse. (2015), "Introduction to leadership: Concepts and practice," SAGE Publications, Inc, California.
- [11] Blackmore, J. (2013), "A feminist critical perspective on educational leadership," *International Journal of Leadership in Education*, 16(2), pp. 139-154.
- [12] Gill, R. (2002), "Change management or change leadership?," *Journal of Change Management*, 3(4), pp. 307-318.
- [13] R. Ryan. (2008), "Leadership development: A guide for HR and training professionals," Routledge, London.

SSES-04

МУ-ын НӨАТ-ын хувь хэмжээний өнөөгийн байдлын судалгаа

Б.Баясгалан /МВА/ СЭЗИС, ОУНББСМС-ийн bayasgalan.b@ufe.edu.mn

Г.Сарангэрэл /МВА/ СЭЗИС, ОУНББСМС-ийн sarangerel.g@ufe.edu.mn

НЭГ. ХУРААНГУЙ

Дэлхий дээр НӨАТ-ын тогтолцоо баруун европын орнуудаас улбаалан хөгжин ирсэн түүхтэй юм. Анх 1919 онд Willhelm Von Siemens эрдэмтэн НӨАТ-ыг үе шаттайгаар /зарим улс оронд худалдааны татвар гэсэн нэршилтэй/ шинэчлэн Германы засгийн газарт хэрэгжүүлэх санал дэвшүүлснээр энэхүү хуулийн эхлэл нь тавигдсан байна. Үүний дараа 1954 онд Франц улсаас хэрэгжүүлж эхэлснээр Европ болон Латин Америкийн улсууд нэвтрүүлж, 1968 онд дахин засварлагдан тухайн үеийн нийгэм эдийн засгийн орчинд тохируулан хэрэглэж, хэрэгжүүлж иржээ (Xiao-Bo, 2014).

Улс орнууд НӨАТ-ыг анх төсвийн орлогыг нэмэгдүүлэх нэг арга хэрэгсэл болгож нэвтрүүлж байсан бол эдүгээ төсвийн орлогыг бүрдүүлэхийн зэрэгцээ бусад татварын орлогыг бүрэн тайлагнахад гол түлхэц болохуйц хяналтын үүргийг давамгайлж гүйцэтгэх болсон.

1993 онд Худалдааны татвар нэртэйгээр НӨАТ-ын тухай анхны хуулийг баталж хэрэгжүүлснээс хойш 2001-2020 он хүртэл улсын төсвийн орлогын 14.1-21.2 хувийг тус татварын орлогоор бүрдүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг нэмэгдүүлэх болон далд эдийн засгийг ил болгох зорилгоор 2016 онд НӨАТ-ын тухай хуулийг шинэчлэн баталсан нь өмнөх хэрэгжүүлж байсан хуулиас давуу тал ихтэй болохын сацуу татварын нэгдсэн системээр дэмжин ажиллаж байгаа нь хуулийн хэрэгжилтэнд ихээхэн дэмжлэг үзүүлж байна.

Олон улсын туршлагаас харахад улс орон бүр өөрийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн онцлогт тохируулан НӨАТ-ын нэг эсвэл олон суурьт хувь хэмжээг ашиглахаас гадна татварын буцаалт, хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг тусгаж, хуульчлан хэрэгжүүлдэг байна.

Дэлхийн улс орнуудын НӨАТ-ын дундаж стандарт хувь 1975 онд 15.6% байсан бол 1976-2020 он хүртэл дундаж нь 19.3% болжээ. (OECD, 2020) Манай орны хувьд татварын хувь хэмжээг 1998.07.07-2001.01.01 хүртэл 13 хувь, 2001.01.01-2007.01.01 хүртэл 15 хувь, 2007 оны 01-р сарын 01-ээс 10 хувь байхаар шинэчилж байсан бөгөөд 2016 оны шинэчлэлээр татварын хувь хэмжээг хэвээр үлдээн мөрдөж байна. Бид Монгол улсын НӨАТ-ын өнөөгийн хувь хэмжээг олон улсын хувь хэмжээтэй харьцуулан судлаж, дүгнэлт өгөх нь цаг үеэ олсон зайлшгүй хийх шаардлагатай ажил хэмээн үзэж судаллаа.

Түлхүүр үг: НӨАТ, НӨАТ-ын хувь хэмжээ, стандарт хувь хэмжээ, бууруулсан хувь хэмжээ.

ХОЁР. ҮНДСЭН ХЭСЭГ

- **НӨАТ гэж юу вэ?**

НӨАТ-ын талаар олон янзын тодорхойлолт байдаг боловч эдгээрээс олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн нийтлэг тодорхойлолтыг Эдийн засаг, хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага буюу OECD-ээс гаргасан байна.

OECD буюу ЭЗХАХБ нь “Бараа, үйлчилгээний хэрэглээнд оногдуулах татварыг нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) гэнэ” гэж тодорхойлжээ.

НӨАТ нь бараа, ажил үйлчилгээний үнэд оногдуулсан татварыг тухайн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан эцсийн хэрэглэгч этгээд бараа ажил үйлчилгээнийхээ үнээр дамжуулж төлдөг тул шууд бус татвар гэсэн ангилалд хамааруулах татвар юм. Өөрөөр хэлбэл НӨАТ-ыг бараа ажил үйлчилгээнийхээ үнээр дамжуулж төлсөн татвар төлөгч этгээд биш харин уг бараа ажил үйлчилгээнд НӨАТ-ыг нэмж оногдуулах замаар хураасан этгээд тайлагнаж, тооцоог хийдэг учраас төсөвт төлөгдөх хэлбэрээр нь **шууд бус татварын төрөлд** хамааруулдаг байна.

- **НӨАТ-ын үүсэл хөгжил**

Дэлхийн нэг болон хоёрдугаар дайны дараа олон улс орныг хамарсан эдийн засгийн хямралыг даван туулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, дайны дараах бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх, улс орнууд өөрийн эдийн засгийн байдлыг бататгах, улмаар улс орны тусгаар байдлыг хангах, хөгжлийн шинэ түвшинд очих зэрэг зорилтот шаардлагын улмаас төсвийн орлогыг нэмэгдүүлэх шинэ төрлийн арга эрэлхийлж эхэлсэн байна. Үүнээс улбаалан 1910-аад онд НӨАТ хэмээх шинэ төрлийн татварын санаа анх гарсан гэж үзэх судлаач олон бий.

НӨАТ-ын гарал үүслийн талаар хэзээ ч шийдтэй тодорхойлж чадаагүй байсаар ирсэн хэдий ч ихэнх судлаачид дараах хоёр хувилбарын нэг нь мөн гэж үздэг. Эхнийх нь 1918 онд Германы бизнесмэн Вилхелм Вон Сиймэнс, нөгөө нь 1910, 1921 оны хооронд өөрийн бүтээлдээ бичсэн Америкийн эдийн засагч Томас С.Адамс юм. Вон Сиймэнсийн анх танилцуулсан НӨАТ-ын тогтолцоог Германы Засгийн газрын санхүүгийн асуудлыг шийдэхийн тулд нэвтрүүлсэн гэж үздэг. (Victor, 2010)

20-р зууны эхээр санхүүгийн салбарт гарсан томоохон ололтын нэг нь нэмэгдсэн өртгийн албан татварыг нэвтрүүлсэн явдал бөгөөд татварын эрх зүйн хөгжлийн олон зууны түүхэнд НӨАТ нь шууд бус татвар оногдуулалтын харьцангуй шинэ төрөл болон хөгжиж ирсэн.

НӨАТ-ыг хэрэгжүүлэх ажил нь дэлхий нийтэд үндсэндээ хоёр үе шатыг дамжсан байна. Эхний үе шат нь 1960-1970 онд голчлон баруун Европ болон Латин Америкийн оронд хэрэгжүүлсэн байжээ. Европын Холбоонд элсэхийн өмнө ижилсгэсэн НӨАТ-ыг хүлээн авч хэрэгжүүлэхийг шаардсан Европын Эдийн засгийн Хамтын Нийгэмлэгийн цуврал удирдамж (EEC directive) гарснаар Баруун Европт НӨАТ дэлгэрэх шалтгаан болж түргэсгэсэн байна. НӨАТ-ын хоёрдахь үе шат 1980-аад оны сүүлчээс эхэлсэн гэж үздэг ба Европын Холбооны гаднах хөгжилтэй, аж үйлдвэржсэн зарим орон, тухайлбал, Австрали, Канад, Япон, Швейцарь зэрэг оронд хэрэгжүүлсэн байна. Энэ үе шатанд шилжилтийн эдийн засгийн болон хөгжиж буй улс орон, нэн ялангуяа Африк болон Азийн улсад НӨАТ-ыг нэвтрүүлэх ажил өргөнөөр тархсан. Олон Улсын Валютын Сан болон Дэлхийн банк эдгээр улс оронд НӨАТ-ыг даруй түргэн хүлээн авч хэрэгжүүлэх нь чухал нөлөө үзүүлнэ хэмээн тодорхойлсон байна. Хөгжиж буй болон шилжилтийн эдийн засагтай улсад санхүүжилт болон техникийн туслалцааг үзүүлж НӨАТ-ыг идэвхижүүлэхэд АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID) голлох үүргийг гүйцэтгэж ирсэн байна.

- **НӨАТ-ын хувь хэмжээ**

1980 оноос хойш ЭЗХАХБ бусад хүчин зүйл тогтмол үед өргөн суурь, ганц хувь хэмжээ бүхий НӨАТ-ыг хамгийн тохиромжтой загвар хэмээн үзсээр ирсэн. (Hagemann, R. P., Jones, B. R., & Montador, R. B., 1987) Нөгөө талаас олон оронд хамгийн ядуу өрхүүд үндсэн хэрэглээний бараа, үйлчилгээний орлогынхоо ихээхэн хэсгийг зарцуулдаг гэсэн төсөөллөөр нэг эсвэл хэд хэдэн шатлалтай, багасгасан хувь хэмжээгээр НӨАТ ногдуулан хэрэглэх нь зөв гэж үздэг хэсэг байсан.

Дэлхийн улс орнууд өөрийн орны эдийн засгийн онцлог, хөгжлийн түвшин, газар зүйн байрлал, хүн амын бүтэц, улс төрийн байдал зэрэг олон үзүүлэлтүүдээс хамааруулан НӨАТ-ыг хэд хэдэн төрөл, хувь хэмжээгээр ногдуулж иржээ. НӨАТ-ыг ногдуулж байгаа бараа, ажил үйлчилгээний онцлогоос хамааруулан дараах төрлийн хувь хэмжээг ашиглаж байна. Үүнд:

Стандарт хувь хэмжээ: Улс орнууд стандарт хувь хэмжээг дийлэнх бараа үйлчилгээндээ ногдуулдаг. Уг хувь хэмжээ нь заавал нэг түвшинд байх албагүй ба зарим улс орнууд ногдуулж буй бараа, ажил, үйлчилгээний онцлогоос нь хамааруулан хэд хэдэн ялгаатай түвшнээр тогтоосон байдаг.

Бууруулсан хувь хэмжээ: Онцлог шинж чанартай бараа ажил үйлчилгээнд хэрэглэдэг. Улс орон бүрийн хувьд бууруулсан хувь хэмжээг ашиглах бараа, ажил үйлчилгээний жагсаалт нь харилцан адилгүй байдаг хэдий ч дараах нийтлэг бараа, ажил үйлчилгээ байж болно. Тухайлбал: Аялал жуулчлал, мод бэлтгэл, ресторан нийтийн хоолны үйлдвэрлэл, орон нутгийн зорчигч тээвэр, хүүхдийн машины суудал гэх мэт. Бууруулсан хувь хэмжээг бараа, ажил, үйлчилгээний онцлогоос хамааруулан хэд хэдэн ялгаатай хувь хэмжээгээр тогтоож болдог.

Нэмэгдүүлсэн хувь хэмжээ: Нэмэгдүүлсэн хувь хэмжээг ихэвчлэн тансаг зэрэглэлийн бараа, цахилгаан, үүрэн холбоо, тамхи, архи, хийжүүлсэн ундаа, шоколад зэрэг цөөн төрлийн бараа ажил үйлчилгээнд ногдуулдаг. Уг хувь хэмжээний хэрэглээ ч мөн цөөн хэдэн оронд тохиолддог.

Тэг хувь хэмжээ: Тэг хувь хэмжээ гэдэг нь татвар ногдуулах бараа ажил, үйлчилгээнд тэг хувь хэмжээгээр буюу татвар ногдуулж төлөхгүй гэсэн үг юм. Уг хувь хэмжээг ихэнх орнууд хэрэглэдэг бөгөөд ихэвчлэн экспортонд гаргасан бараа, ажил, үйлчилгээ, гадаадын аялал жуулчлал, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж зэрэгт түлхүү ногдуулдаг.

Тэг хувь хэмжээ /Чөлөөлөгдөх/: Экспортонд гаргасан бараа, ажил үйлчилгээ, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, уул уурхайн бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгсэл, боловсрол, нийтийн тээвэр зэрэг бараа ажил үйлчилгээнд ногдуулдаг бөгөөд энэ нь улс орон бүрт ялгаатай байдлаар хуульчлагдсан байдаг. Чөлөөлөгдөх хувь хэмжээ нь тэг хувь хэмжээнээс ялгагдах онцлог нь эцсийн тооцоогоор төлөх татварын хэмжээг тооцоолохдоо худалдан авалтанд төлсөн НӨАТ-ыг хасдаггүй. Өөрөөр хэлбэл тэг хувь хэмжээгээр бараа, ажил, үйлчилгээнд НӨАТ ногдуулсан тохиолдолд борлуулалтын орлогод ногдох төлбөл зохих НӨАТ нь тэг байх ба худалдан авалтанд ногдох НӨАТ-аа хасуулах эрхтэй байдаг.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Дэлхийн улс орон бүр өөр өөрийн туршлагаар НӨАТ болон худалдааны татварыг хэрэгжүүлж ирсэн бөгөөд тэдгээрийг НӨАТ-ын хөгжлийн төвшнөөр нь хэд хэд ангилах хандлага байдаг. Өндөр хөгжилтэй улсуудын эхний ангиллын улсууд болох Европын холбооны гишүүн улсуудын НӨАТ-ын стандарт хувь хэмжээ нь 15 хувиас багагүй, хоёр хүртэлх төрлийн бууруулсан хувь хэмжээтэй бөгөөд энэ нь таван хувиас багагүй байдаг. Хоёрдох ангиллын Австрали, Канад, Солонгос, Шинэ Зеланд, Сингапур, Өмнөд Африк тэргүүтэй улсууд нь нэгдүгээр ангиллын улсуудыг бодвол татварын стандарт хувь хэмжээ бага байдаг. Жишээ нь Австрали 10 хувь, Канад таван хувь, Шинэ Зеланд 12.5 хувь, Сингапур долоон хувь, Өмнөд Африк 14 хувь. Хөгжиж буй орнууд нь ихэвчлэн ганц татварын хувь хэмжээг ашигладаг байна. Жишээлбэл Африкийн 1990-1999 оны хооронд НӨАТ нэвтрүүлсэн 21 улсаас 14 нь; 2000 оноос хойш нэвтрүүлсэн есөн улсын найм нь нийтлэг хувь хэмжээгээр НӨАТ ногдуулдаг байна. Ялгаатай хувь хэмжээгээр татвар ногдуулдаг Европын системийн гол зорилго нь эмзэг бүлгийн өрхүүдийн хэрэглээний ихэнх хувийг бүрдүүлэгч бүтээгдэхүүн, үйлчилгээнд ногдох татварын дарамтыг бууруулахад оршдог. Нөгөө талаас нийтлэг хувь хэмжээгээр татвар ногдуулах нь татварын байгууллагын зардлыг бууруулдаг тул зарим улсууд уг системрүү шилжээд байгаа. (Michael Keen, 2007)

НӨАТ-ийг хэрэгжүүлдэг орнууд ихэвчлэн өндөр хөгжилтэй мөн ДНБ-д эзлэх олон улсын худалдааны татвар өндөртэй орон байдаг байна. НӨАТ-ийг хэрэгжүүлдэггүй улсын 30% орчим нь нэг с аяаас доош хүн амтай байдаг байна. (The Value Added Tax Experience and Issues, 2005)

1960-аад оноос цөөн хэдэн улс орнууд НӨАТ-ыг нэвтрүүлж байсан бол 2020 оны байдлаар дэлхийн нийт 170 оронд НӨАТ болон хэрэглээний татварыг хэрэгжүүлж байна.


График 1. НӨАТ болон хэрэглээний татварыг ногдуулж буй улс орнуудын тоо



Эх сурвалж: (OECD, 2020)

Дэлхийн улс орнуудын жил бүрийн дундаж стандарт хувь хэмжээг ерөнхий дундажтай нь харьцуулбал дараах байдалтай байна.


График 2. Улс орнуудын стандарт хувь хэмжээний дундаж



Эх сурвалж: (OECD, 2020)

1976-2020 оныг хүртэл улс орнуудын дундаж стандарт хувь хэмжээ нь 19.3 хувьтай байна. 2020 оны байдлаар дэлхийн 136 орны стандарт хувь хэмжээг улс бүрээр харьцуулбал ерөнхий дундаж нь 16 хувь, хамгийн өндөр татварыг Унгар улс ногдуулж байгаа бөгөөд 27%, хамгийн бага татварыг Тайван, Оман, Бахрайн зэрэг улсууд 5%-аар ногдуулж байна. Доорх зургаар эдгээр орнуудын НӨАТ болон хэрэглээний татварын стандарт хувь хэмжээг харьцууллаа.

График 3. Улс орнуудын НӨАТ-ын стандарт хувь хэмжээний харьцуулалт



Эх сурвалж: [Value-added tax \(VAT\) rates \(pwc.com\)](https://www.pwc.com)

- **Зарим улс НӨАТ-ын хувь хэмжээ**

Бид судалгааны ажлынхаа хүрээнд зарим улс орнуудын НӨАТ-ын хувь хэмжээг өөрийн орны хувь хэмжээтэй харьцуулан судаллаа. Улс орнуудыг түүвэрлэхдээ 2020 оны байдлаар нэг хүнд ногдох ДНБ-ийг голлох үзүүлэлт болгосон бөгөөд дэлхийд эхний арван байрт эрэмбэлэгдэж буй орнуудаас гурван улсыг, 60-80-рт эрэмбэлэгдэж байсан хоёр хөрш болон дурын нэг улсыг, мөн манай улсын эрэмбэлэгдсэн 94-р байртай нэг түвшинд буюу 110-130-д жагссан орнуудаас хоёр улсыг сонгон авч судаллаа.

Швейцарь

Швейцарь улсын НӨАТ-ын стандарт хувь нь 7.7% байдаг.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
7.7%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
3.7%	Бууруулсан	Зочид буудал
2.5%	Бууруулсан	Зочид буудалд ашиглаж байгаагаас бусад хоол хүнс болон уух зүйлс, ХАА-н хангамжийн зүйлс, хэвлэмэл материал, эм, соёлын ба спортын үйл ажиллагаа
0%	Тэг	Экспортууд, агаарын тээврийн компаниудад нийлүүлж буй бараа, ажил үйлчилгээ

Ирланд

Ирланд улсын НӨАТ-ын стандарт хувь нь 23% байдаг. Ирланд улс COVID-19-тэй холбоотойгоор стандарт хувь хэмжээг 2020.09.01-2021.02.28-нийг хүртэл 21% болгож бууруулсан. Мөн 2021.12.31-нийг дуустал аялал жуулчлал болон зочлохуйн үйлчилгээний НӨАТ-ын хувь хэмжээг 13.5%-аас 9% болгон бууруулсан.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
23%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
13.5%	Бууруулсан	Зарим төрлийн эм, эмийн бүтээгдэхүүн, тодорхой төрлийн хүнсний бүтээгдэхүүн, хүүхдийн автомашины суудал, хувийн орон сууцны засвар шинэчлэлт, цэвэрлэгээ, зарим төрлийн ХАА-н хангамжийн зүйлс, хог хаягдал, хаягдал усыг цэвэршүүлэлт, байгалийн хийн нийлүүлэлт, цахилгаан ба төвлөрсөн халаалт гэх мэт
9%	Бууруулсан	Тодорхой төрлийн хүнсний бүтээгдэхүүн, сонин, тогтмол хэвлэл, спортын тоног төхөөрөмж ашиглах, үсчин үйлчилгээ, цахим ном
4.8%	Бууруулсан	Хүнсний зориулалтаар ашиглах мал, зарим төрлийн ХАА-н хангамжийн зүйлс
0%	Тэг	Зарим хүнсний бүтээгдэхүүн, тодорхой амьтандын тэжээл, тодорхой төрлийн бордоо, хүнс үйлдвэрлэлд ашиглаж байгаа зарим материал, зарим төрлийн эм (хүний), мал эмнэлгийн зориулалттай зарим төрлийн эм, эмэгтэйчүүдийн зарим төрлийн эрүүл ахуйн бүтээгдэхүүнүүд, олон улсын тээвэр, хүүхдийн живх гэх мэт

Норвеги

Норвеги улсын НӨАТ-ын стандарт хувь нь 25% байдаг. Норвеги улс COVID-19-тэй холбоотойгоор кино театр, зочид буудал, нийтийн тээвэрт ногдуулж байсан 12%-ийн НӨАТ-ыг 2020.04.01-2020.12.31-нийг хүртэл 6% болгож бууруулсан.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
25%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
15%	Бууруулсан	Хүнсний бүтээгдэхүүн ба уух зүйлс
11.1%	Бууруулсан	Түүхий загасны нийлүүлэлт
6%	Бууруулсан	Тодорхой төрлийн соёлын ба спортын үйл ажиллагаа, тээврийн үйлчилгээ
0%	Тэг	Цахим ном

БНХАУ

Хятад улсын НӨАТ-ын стандарт хувь хэмжээ нь 6%, 9%, 13% байдаг, 2012-2016 онд НӨАТ-ын шинэчлэл хийгдсэний дараа тэг хувь хэмжээнээс гадна дөрвөн төрлийн хувь хэмжээтэй болсон.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
13%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
9%		Жижиглэн худалдаа, үйлдвэр үйлчилгээ, зочид буудал, ресторан, нийтийн хоолны үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгө ба барилга байгууламж, үүрэн холбоо, шуудан, тээвэр ба ложистик
6%		Санхүүгийн үйлчилгээ ба даатгал, интернэтийн өгөгдөл, ИТ технологийн зөвлөгөө өгөх
3%	Бууруулсан	Хятадын үндэсний боловсролын татвар

2%		Хятадын бүс нутгийн боловсролын татвар
7%,5%,1%		Хотын засвар үйлчилгээ, барилга
3%		Барилгын үйлчилгээ
3%		Жижиг компаниуд
1-56%	Тусгай /Тансаг хэрэглээ/	Үйлдвэрлэсэн болон импортлосон архи, тансаг зэрэглэлийн гоо сайхны хэрэгсэл, үнэт эдлэл, мотоцикл, спорт тээврийн хэрэгсэл, бинзен, гольфын хэрэгсэл, дарвулт завь, тансаг зэрэглэлийн бугуйн цаг, нэг удаагийн модон савх, тамхи гэх мэт. Экспортын бараа, ажил үйлчилгээ чөлөөлөгдөнө.

Аргентин

Аргентин улсын НӨАТ-ын стандарт хувь хэмжээ нь 21% байдаг.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
27%	Нэмэгдүүлсэн	Орон сууцны бус зориулалтаар ашиглаж буй холбоо, ус, цахилгаан, гааз(хий)
21%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
10.5%	Бууруулсан	Эмнэлэг, барилгын дийлэнх ажлууд, жимс, хүнсний ногоо, мах, нийтийн ба такси тээвэр, эдийн засгийн тусгай бүсэд үйлдвэрлэсэн тодорхой төрлийн электрон бараанууд
2.5%	Бууруулсан	Зарим төрлийн хэвлэмэл ба дижитал сонин сэтгүүл импортлох, нийлүүлэх; Тодорхой төрлийн хэвлэмэл ба дижитал сонин, сэтгүүлд сурталчлах үйлчилгээ
0%	Тэг	Экспортын бараа, ажил үйлчилгээ
0%	Чөлөөлөгдөх	Орон сууц, фермын түрээс, зорчигч тээвэр, эмнэлгийн үйлчилгээ, боловсрол, төрийн байгууллагын үйлчилгээнүүд, ус, талх, сүү

ОХУ

ОХУ-ын НӨАТ-ын стандарт хувь нь 20% байдаг.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
20%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
16.67%	Бууруулсан	Хүнсний бүтээгдэхүүн, тодорхой төрлийн хүүхдийн хангамжийн зүйлс, эм, ус, ном, мал
0%	Тэг	Экспорт болон түүнтэй холбоотой үйлчилгээнүүд, хотын захын төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ

Индонез

Индонезын НӨАТ-ын стандарт хувь нь 10% байдаг.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
10%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
1%-4%	Хялбаршуулсан	Жижиг компаниуд
10%-125%	Нэмэгдүүлсэн /тансаг/	Архи, автомашин, өндөр үнэтэй үл хөдлөх хөрөнгө
0%	Тэг	Экспорт, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж болон барилгын үйлчилгээ
0%	Чөлөөлөгдөх	Хэвлэмэл ном, эмнэлгийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө, дотоодын эрчим хүч, мал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн

Алжир

Алжир улсын НӨАТ-ын стандарт хувь нь 19% байдаг.

Хувь хэмжээ	Төрөл	Татвар ногдох бараа, ажил үйлчилгээ
19%	Стандарт	Татвар ногдох бусад бүх бараа, ажил үйлчилгээ
14%	Бууруулсан	Олон төрлийн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн
9%	Бууруулсан	ХАА-тай холбоотой бараа, үйлчилгээ, элсэн чихэр болон хүнсний тосны үйлдвэрлэл, борлуулалт, далайн тээвэртэй холбоотой бараа, үйлчилгээ, тодорхой төрлийн төмөр болон ган бүтээгдэхүүнүүд, цахим үйлчилгээнүүд, интернэтийн үйлчилгээнүүд, барилга, аялал жуулчлалтай холбоотой үйлчилгээ, катеринг ба рестоуран, автомашины түрээс гэх мэт
0%	Бууруулсан	Экспорт болон түүнтэй холбоотой үйлчилгээнүүд

НӨАТ-


ын зорилго нь эцсийн хэрэглээнд татвар ногдуулах тул эцсийн хэрэглээг бүрдүүлдэг ялгаатай төрлийн бүтээгдэхүүнд ялгаатай хувь хэмжээгээр татвар ногдуулах талаарх асуудал урган гардаг. Нэг талаас татварын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор огт мэдрэмжгүй эсвэл мэдрэмж багатай /жишээ нь талх/ бүтээгдэхүүнд өндөр татвар ногдуулах нь зүйтэй. Дээрээс нь дундаас дээш давхаргын иргэдийн голчлон хэрэглэдэг бүтээгдэхүүнд өндөр татвар ногдуулснаар татварын орлогыг нэмэгдүүлж болдог. Нөгөө талаас орлого багатай өрхийн хэрэглээний ихэнхийг эзэлдэг бүтээгдэхүүнд бага татвар ногдуулсан ч өндөр орлоготой өрхийн ижил төрлийн бүтээгдэхүүнд зарцуулах мөнгөн дүн хамаагүй өндөр байдаг тул эсрэгээр өндөр орлоготой өрхүүдэд ашигтай байдаг. (Gendron, 2005) . Улс орнуудын НӨАТ-ын хувь хэмжээг тогтоосон байдлаас харвал нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээнээс үл хамааран дийлэнх улс орнууд стандарт, бууруулсан болон тэг хувь хэмжээг ашиглаж байна. Сонгон авсан улсуудын нэг хүнд ногдох ДНБ-ээр тэргүүлэх улсуудын хувьд нэг стандарт хувь хэмжээ, 2-3 төрлийн бууруулсан хувь хэмжээг ашиглаж байна. Манай улсын хоёр хөрш улсын хувьд нэг хүнд ногдох ДНБ-ээр 60-аас 80-р байранд эрэмбэлэгдэж байсан бөгөөд тухайн интервалд багтаж байгаа орнууд ч мөн адил стандарт, бууруулсан, тэг хувь хэмжээг ашиглаж байна. Манай улстай ижил түвшинд эрэмбэлэгдсэн Индонез, Алжир зэрэг улсад стандарт, бууруулсан хувь хэмжээг гурван төрлийн шатлалаар ногдуулж байна.

- **Монгол улсын НӨАТ-ын өнөөгийн байдлын судалгаа**

Монгол улсын хувьд улсын төсвийн орлогын бүрдүүлэлт хангалттай биш цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжээ хугацаанд нь тавьж олгох боломж муудсан, хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт үндсэндээ зогсонги байдалд орсон, ААНОАТ ба ХХОАТ –ын хувь хэмжээ хүн амын амьжиргаа, бизнес эрхлэгчдийн чадавхитай харьцуулахад харьцангуй ачаалал ихтэй байсан 1990-ээд онд татварын шинэчлэл хийж төсвийн орлогын шинэ эх үүсвэр хайх зайлшгүй шаардлага гарсан. Ингээд 1993 оноос НӨАТ-ыг худалдааны албан татвар нэртэйгээр анх нэвтрүүлсэн бөгөөд үүнээс хойш 4 удаа хуулийн шинэчлэлийг хийж, 50 гаруй удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр өөрчлөлтөөс гадна НӨАТ-аас чөлөөлөх тухай 28 бие даасан хууль гарч байсан бөгөөд одоогоор 14 нь хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа мэдээлэл байна. (УИХ, 2021)

НӨАТ нэвтрүүлсэн улс орнууд улсын төсвийн орлогынхоо 20 орчим хувь нь уг татвараар бүрдүүлдэг ерөнхий дүр зураг байдаг бол манай улсын хувьд төсвийн орлогын 1993-1997 онд 11.2%-17.1%, 1998-2006 онд 17.7%-24.9%, 2007-2015 онд 14.1%-26.1% , 2016 онд 19.5%, 2017 онд 20.4%, 2018 онд 21.8%, 2019 онд 20.8 хувийг тус тус НӨАТ /худалдааны татвар/-аар бүрдүүлсэн байна. НӨАТ-ыг нэвтрүүлж улмаар шат дараалсан шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлснээр ААНОАТ болон хувиараа бизнес эрхлэгч иргэний орлогын татварын бүрдүүлэлтийг сайжруулах, татварын байгууллагын татварын хуулиудын биелэлтэд хяналт тавих, далд эдийн засгийг бууруулахад илүү ач холбогдолтой юм.


График 4. Төсвийн орлогод НӨАТ-ын эзлэх хувь



Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2020)

Харин НӨАТ-аар татварын орлогын 1993-1997 онд 13.6%-23.3%, 1998-2006 онд 21.4%-33%, 2007-2015 онд 17.6%-30.8%, 2016-2019 онд 23%-26.8 хувийг тус тус бүрдүүлжээ.

График 5. Татварын орлогод НӨАТ-ын эзлэх хувь



Эх сурвалж: (Үндэсний статистикийн хороо, 2020)

1997 оноос НӨАТ-ыг сонгодог загвараар нь шинэчлэхийн тулд олон улсын донор байгууллагуудаас тусламж дэмжлэг авч хуулийг нэвтрүүлэх төслийг Дэлхийн банкнаас санхүүжүүлж, ОУВС-ын мэргэжилтнүүд хуулийн төсөл дээр ажиллан 1998 оны 01 сарын 06-нд НӨАТ-ын тухай хуулийг батлаж, мөн оны 07 сарын 01-ний өдрөөс хуулийг мөрдөж эхэлсэн.

Түүнээс хойш хувь хэмжээг нь 2000 оны 11 сарын 17-ний өдрийн хуулиар 15 хувь, 2006 оны 06 сарын 29-ний өдрийн хуулийн шинэчилсэн найруулгаар 10 хувь болгон өөрчилж, сүүлийн өөрчлөлтөөр хувь хэмжээнд өөрчлөлт оруулалгүй хэвээр нь мөрдөж байна.

2020 оны байдлаар манай улсын стандарт хувь хэмжээ 10% байгаа нь дэлхийн улс орнуудын стандарт хувь хэмжээнээс 6 хувиар доогуур байна.


График 6. НӨАТ-ын хувь хэмжээний өөрчлөлт



Эх сурвалж: Судлаачдын нэгтгэлээр

Татварын хувь хэмжээг 1998.07.07-2001.01.01 хүртэл 13 хувь, 2001.01.01-2007.01.01 хүртэл 15 хувь, 2007 оны 01-р сарын 01-ээс 10 хувь байхаар шинэчилж байсан бөгөөд 2016 оны шинэчлэлээр татварын хувь хэмжээг хэвээр үлдээж мөрдөж байна. НӨАТ сууган төлөгчийн тоо 2001 оны байдлаар 3,349 байсан бол 2019 он гэхэд 12 дахин өссөн буюу 40,169 болжээ. Эдийн засгийн хүрээ нэмэгдэхийн хэрээр уг тоо хэмжээ нь өссөөр байх төлөвтэй байна.

График 7. НӨАТ-ын хувь хэмжээ НӨАТ төлөгчийн тоо



Эх сурвалж: (Монголын татварын алба, 2019)

2019 оны байдлаар Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагуудын 67% нь жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид байна.

График 8. ЖДҮҮ эрхлэгчдийн тоо



Эх сурвалж: (Монгол улсын үндэсний статистикийн хороо, 2019)

Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн дагуу дараах нөхцлийг хангасан ААН-ийг

бичил, жижиг, дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгч гэж ангилсан байдаг.



Зураг 1. ЖДҮҮ эрхлэгчдийн ангилал

Эх сурвалж: (Монгол улсын хууль, 2019)

Манай орны хувьд аж ахуй нэгж байгууллагын хэмжээнээс үл хамааран борлуулалтын орлогын 10 хувиар НӨАТ-ыг суутган төлж байгаа. Олон улсын туршлагаас харахад жижиг аж ахуй нэгж байгууллагуудыг дэмжих зорилгоор стандарт хувь хэмжээнээс доогуур бууруулсан хувийг ашигладаг. Тухайлбал: БНХАУ 6%-13%-ийн стандарт хувийг 3%, Гана улс 12.5%-ийн стандарт хувийг 3%, Тайвань улс 5%-ийн стандарт хувийг 1% болгон бууруулж ногдуулдаг байна.

Аж ахуй нэгж байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлээс нь хамааруулан хэд хэдэн стандарт хувь хэмжээг ашиглаж байгаа улс байдаг. Тухайлбал: БНХАУ гурван, Гондурас улс хоёр, Энэтхэг улс хоёр, Малайз улс хоёр төрлийн стандарт хувь хэмжээг ашиглаж байна. Стандарт хувь хэмжээний олон шатлалаас гадна бууруулсан хувь хэмжээний хэд хэдэн шатлалыг ашигладаг орнууд нэлээд олон байна. Улс орнуудын бууруулсан хувь хэмжээ ашиглаж буй үндсэн шалтгаан нь улс орны тэргүүлэх салбарын үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний үнийг хямд түвшинд барих, хүртээмжтэй байлгах, зарим салбарын үйл ажиллагаанд татварын дэмжлэг үзүүлэх замаар ард иргэдийн амьжиргааны түвшинг нэмэгдүүлж байна.

Татварын орлогыг өндөр хувь хэмжээгээр татвар ногдуулах замаар бүрдүүлэх бус улс орны салбар бүрийн онцлог, тэргүүлэх чиглэл, иргэдийн худалдан авах чадвар, бизнес эдийн засгийн орчин зэрэг өргөн хүрээг хамруулж салбар бүрт тохирсон олон шатлалт хувь хэмжээг авч хэрэгжүүлэх нь тохиромжтой юм.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- Дэлхийн улс орнууд өөрийн орны эдийн засгийн онцлог, хөгжлийн түвшин, газар зүйн байрлал, хүн амын бүтэц, улс төрийн байдал зэрэг олон үзүүлэлтүүдээс хамааруулан стандарт, бууруулсан, нэмэгдүүлсэн, тэг хувь хэмжээ, тэг хувь хэмжээ (чөлөөлөгдөх)-ээр ногдуулж байна.
- 2020 оны байдлаар дэлхийн 136 орны стандарт хувь хэмжээг улс бүрээр харьцуулбал ерөнхий дундаж нь 16 хувь, хамгийн өндөр татварыг Унгар улс ногдуулж байгаа бөгөөд 27%, хамгийн бага татварыг Тайвань, Оман, Бахрайн зэрэг улсууд 5%-аар ногдуулж байна.
- Улс орнуудын НӨАТ-ын хувь хэмжээг тогтоосон байдлаас харвал нэг хүнд ногдох ДНБ-ний хэмжээнээс үл хамааран дийлэнх улс орнууд стандарт, бууруулсан болон тэг хувь хэмжээг ашиглаж байна.
- Манай улсын стандарт хувь хэмжээ 10% байгаа нь дэлхийн улс орнуудын стандарт хувь хэмжээнээс 6 хувиар доогуур байна.
- Татварын орлогыг өндөр хувь хэмжээгээр татвар ногдуулах замаар бүрдүүлэх бус улс орны салбар бүрийн онцлог, тэргүүлэх чиглэл, иргэдийн худалдан авах чадвар, бизнес эдийн засгийн

орчин зэрэг өргөн хүрээг хамруулж салбар бүрт тохирсон олон шатлалт хувь хэмжээг авч хэрэгжүүлэх нь тохиромжтой юм

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Cnossen, S. (2009). *A VAT Primer for Lawyers*. Economist and Accountants. Tax Notes Int'l.
- Gendron, R. M.-P. (2005). *A New Look at the VAT in Developing and Transitional Countries*.
- Hagemann, R. P., Jones, B. R., & Montador, R. B. (1987). *Tax Reform in OECD Countries: Economic Rationale and Consequences*. . OECD Economics Department Working Paper.
- Klelov, Graham Harrison and Russel. (2001он). “НӨАТ-ын буцаалт” сэдэвт бүтээл.
- Michael Keen, B. L. (2007). The VAT: Its Causes and Consequences. *IMF Working*.
- OECD. (2020). *Consumption Tax Trends 2020*.
- P. Studenski, O. (1940). *Theory of business Taxation*. Political Economy.
- (2005). *The Value Added Tax Experience and Issues*. Rome: Background Paper Prepared for the International Tax Dialogue Conference on VAT.
- Victor, A. (2010 оны 12 31). *THEGuardian*. TheGuardian: <http://www.theguardian.com/money/2010/dec/31/vat-brief-history-tax/-ээс> Гаргасан
- Xiao-Bo, Y. (2014). “The Comparative of the Value-Added Tax between China and Korea” . *Soonchunhyang University Korea*,.
- Монгол улсын үндэсний статистикийн хороо. (2019). *Статистикийн бизнес регистр*.
- Монгол улсын хууль. (2019). www.legalinfo.mn.-ээс Гаргасан
- Монголын татварын алба. (2019). www.mta.mn.-ээс Гаргасан
- УИХ. (2021). www.legalinfo.mn.-ээс Гаргасан
- Үндэсний статистикийн хороо. (2019). www.1212.mn.-ээс Гаргасан
- Үндэсний статистикийн хороо. (2020). www.1212.mn.-ээс Гаргасан

SSLS-06

Цар тахлын үеийн нийгмийн даатгалын шимтгэлийн эрх зүйн зохицуулалт, үр нөлөө

Ц. Мөнхдэлгэр

*Graduate school of Mongolian National University.**Research doctorate (PH.D) University of Affairs, Mongolia*Ts.munkhdelger@mnun.edu.mn

Хураангуй: Нийгмийн даатгалын шимтгэл төлөлт нь ажлын байрны хомсдол, хөдөлмөр эрхлэлт болон иргэдийн орлого зэргээс шууд хамаарч байдаг ч цар тахлын үед огцом багасах, төлж чадахгүйд хүрэх эрсдэлтэй юм. 2020 оны 12 дугаар сард дэлхий дахинаа Ковид-19 цар тахал дэгдэж өнөөг хүртэл үргэлжилж улс орнууд иргэдэдээ чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг авч байгаа билээ. Монгол улсад цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан олон арга хэмжээ авч байгаагийн нэг гол хэсэг нь нийгмийн даатгалын шимтгэлийн эрх зүйн зохицуулалтанд өөрчлөлт оруулж үүний дагуу төрөөс хэсэгчлэн болон бүрэн хариуцаж байгаа явдал юм. Монгол Улсын Их Хурлаас “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль”-уудыг 2020 оны 04 сарын 09-ны өдөр батлан гаргасан билээ. Энэхүү судалгаа нь дээрх хуулиудын хэрэгжилт, иргэдийн сэтгэл ханамж болон цаашдын үр дагаврыг тандан судлах зорилготой. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчдаас судалгааны түүврийг цуглуулан статистикийн SPSS програм дээр тооцооллыг гүйцэтгэв.

Түлхүүр үг: Нийгмийн даатгал, нийгмийн даатгалын шимтгэл, цар тахал,

Удиртгал

Цар тахал **pandemic** (Грекийн *πάν, παν*, "олон" ба *δῆμος, demo*, "нутгийн хүмүүс" "олон түмэн" гэсэн үг) нь томоохон бүс нутаг болон тив, дэлхий даяар тархсан олон хүмүүсийг хамарсан халдварт өвчний тархалтыг хэлдэг. Коронавирусын шинэ омог болох SARS-CoV-2 нь 2019 оны 12-р сарын сүүлчээр БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод анх илэрсэн². Энэ нь амьсгалын замын цочмог өвчний бөөгнөрлийг үүсгэсэн бөгөөд үүнийг коронавирусын өвчин 2019 гэж нэрлэжээ. 2021 оны 3-р сарын 22-ны байдлаар дэлхий даяар COVID-19-ийн халдвар авсан хүмүүсийн тоо 123,935,320-д хүрч, үүнээс 99,857,294 нь эдгэрч нас барсан хүмүүсийн тоо 2.729.022 хүрчээ³. Зай барих тусгаарлалт бол тус халдварыг дамжуулах хэлхээг таслах, хүн амын томоохон бүлгүүдийг хамгаалах цорын ганц арга байх болно. Тиймээс бүрэн эсвэл хэсэгчлэн хорио цээрийн арга хэмжээг дэлхий даяар хэрэгжүүлж үүнд одоогоор 5 тэрбум гаруй хүн хамрагдуулсан байна⁴. Монгол Улсад Ковид-19 вирусийн анхны тохиолдол 2020 оны 3 дугаар сард бүртгэгдэх үед Монгол Улсын Засгийн газар нэн даруй өндөржүүлсэн бэлэн байдал зарлан хилээ хааж Ковид-19 вирусийн тархалтыг зогсоох арга хэмжээг авч эхэлсэн. Коронавирусийн дэгдэлт дэлхий дахинд эрчтэй тархаж байгаа бөгөөд Монгол Улс нь халдвар тархах маш өндөр эрсдэлтэй орны тоонд ороод буйг мэргэжилтэнгүүд анхааруулсаар байгаа билээ. Цар тахлын хямралын үед өрх, гэр бүлүүд эрүүл мэндийн болон эдийн засгийн цочролыг даван туулахад нийгмийн хамгаалал нэн чухал дэмжлэг болдог⁵. Энэ чиглэлээр дэлхийн улс орнууд төрөл бүрийн арга хэмжээг авч байгаа билээ. ОХУ-д нийгмийн даатгалын шимтгэлийг 2 дахин бууруулах, бага орлоготой

² ["WHO Statement Regarding Cluster of Pneumonia Cases in Wuhan, China"](#). WHO. 31 December 2019. Retrieved 12 March 2020.

³ ["Covid-19 Coronavirus Pandemic"](#). [Worldometer](#). Retrieved 26 November 2020

⁴ ОУХБ-ын товч баримт бичиг. 2020 оны 5 сар

⁵ Цар тахлын үед хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлэе. <https://www.ilo.org> > 2020 он

иргэдийн шимтгэлийг тэглэх шийдвэр гаргажээ⁶. Австрали улс ядуу, тэтгэврийн насны иргэддээ 7 сая хүн 430 ам.доллар өгөхөөс гадна эдийн засгийн аврах хоёр дахь багц хөтөлбөрөө танилцуулж үүнд 66 тэрбум ам.долларыг төсөвлөсөн. Эхний багц хөтөлбөрт Австрали улс 17.6 сая ам.доллар болон 100 тэрбум ам.долларын зээлийг царцаахад зориулан төлөвлөжээ. Нийтдээ Австрали улс 189 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг эдийн засгаа хямралаас гаргах, ажлын байрыг хадгалахад зарцуулахаар болсон байна. Мөн Исланд улсад татварын хураамжийг хойшлуулах, Италид ипотекийн зээлийн төлөлтийг хойшлуулах, Хорватад зээлийн үндсэн төлбөрийг эргэн төлөлтийг хойшлуулах зэрэг арга хэмжээг авчээ.

Монгол улсад коронавируст халдварын цар тахлын үр нөлөөг бууруулах, үндэсний хариу олон арга хэмжээ авсаны нэг гол хэлбэр нь нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, хөнгөлөх, нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлж буй явдал юм. Нийгмийн даатгалын үндсэн гол зорилго нь даатгуулагчид нийгмийн аливаа эрсдэл тохиолдох үед уг эрсдэлийг хуваалцах, хөнгөрүүлэхэд чиглэгддэг байна. Дэлхий нийтээр тархсан цар тахлын улмаас иргэдийн орлого буурч, эдийн засгийн хүндхэн байдалд орсон. Үүнтэй уялдуулан Монгол Улсын Их Хурлаас “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай” хууль”-уудыг 2020 оны 04 сарын 09-ны өдөр батлан хэрэгжүүлж байгаа билээ. Энэ хүү авч хэрэгжүүлж буй нийгмийн хамгааллын бодлого нь иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт тасрахгүй болж, ирээдүйн баталгаа нь хангагдаж байгаа явдал юм. 2017 онд Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж НДШ-ийг жил бүр шаталсан зарчмаар буюу 5 хувиар нэмэгдүүлж 26 хувьд хүргэх шийдвэр гаргасан. /Хүснэгт 1/ Хүснэгт 1. 2017 оны Нийгмийн даатгалын тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлт

№	Он	Д-н төрөл	Тэг-р	Тэг-ж	Ажилгүйдэл	ЭМД	ҮОМҮӨ	Шимтгэл	Нийт
1	2018	А олгогч	8	1	0.2	2	0.8	12	23
2		Ажилтан	8	0.8	0.2	2		11	
3	2019	А олгогч	8.5	1	0.2	2	0.8	12.5	24
4		Ажилтан	8.5	0.8	0.2	2		11.5	
6	2021	А олгогч	9.5	1	0.2	2	0.8	13.5	26
7		Ажилтан	9.5	0.8	0.2	2		12.5	

2021 оны 1 сарын 1-ээс эхлэн НДШ-ийн хэмжээ 2 хувиар нэмэгдсэн бөгөөд цар тахлын эдийн засагт үзүүлэх нөлөөллөөс үүдэн долдугаар сарын 1-нийг хүртэл 5 хувиар чөлөөлөөд буй. 2020 оны 2 сарын 13-ны өдрөөс гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, үйлчлэх хугацааг 10 удаа, 2020 оны 11 сарын 11-ны өдрөөс гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үйлчлэх хугацааг хэд хэдэн удаа сунгаад байна. 2020 оны 04 сарын 09-ны өдөр батлан гаргасан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай

⁶ Дума одобрила двукратное снижение социальных взносов для малого бизнеса. <https://www.rbc.ru/economics/2020> г.

хууль”-ийн дагуу дараах өөрчлөлт оржээ. /Хүснэгт 2/

Хүснэгт 2. Дээрхи хуулийн дагуу орсон өөрчлөлт

Нийгмийн даатгалын сан	2020 он					
	2020 онд төлөх шимтгэл			2020 оны 10-12 сард чөлөөлсөн хувь		
	Ажил олгогч	Даатгуулагч	Нийт	Ажил олгогч	Даатгуулагч	Нийт
Тэт ДС	8.5	8.5	17	3.5	3.5	7
Тэт-ж ДС	1.0	0.8	1.8	1.0	0.8	1.8
А-гүйдэл ДС	0.2	0.2	0.4	0.2	0.2	0.4
ҮОМШӨ ДС	0.8-2.8	–	0.8-2.8	0.8-2.8	–	0.8-2.8
ЭМДС	2.0	2.0	4	–	–	–
Нийт	12.5%-14.5%	11.5%	24%-26%	5.5-7.5%	4.5%	10-12%

Хүснэгт 3. Дээрхи хуулийн дагуу орсон өөрчлөлт

Нийгмийн даатгалын сан	2021 онд					
	2021 онд төлөх шимтгэл			2021 оны 01-06 сард чөлөөлөх хувь		
	А олгогч	Даат-ч	Нийт	А олгогч	Даат-ч	Нийт
Тэт-р ДС	9.5	9.5	19	1.0	1.0	2.0
Тэт-ж ДС	1,0	0.8	1.8	1.0	0.8	1.8
А-гүйдэл ДС	0.2	0.2	0.4	0.2	0.2	0.4
ҮОМШӨ	0.8-2.8	–	0.8-2.8	0.8-2.8	–	0.8-2.8
ЭМДС	2.0	2.0	4.0	–	–	–
Нийт	13.5%-15.5%	12.5%	26-28%	3-5%	2%	5-7%

Дээрхи хуулийн дагуу иргэдэд 2020 онд үзүүлсэн халамж, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ 2 их наяд 375.0 тэрбум төгрөгт хүрчээ.

1. Судлагдсан байдал

Дэлхий дахинаа Ковид-19 цар тахал дэгдэж үүний улмаас улс орнууд хөл хорио тогтоосоны улмаас эдийн засаг болон бизнес хямралд орох, ажлын байр хомсдох, иргэдийн амжиргааны түвшин буурах зэрэгт дүн шинжилгээ хийсэн олон судлаач эрдэмтдийн бүтээл нийтлэгдсэнээс дурьдвал June Namgoong PhD “The Republic of Korea’s Policy Response to the Covid-19 epidemic in the field of employment and labour relations”⁷, Quan Lu 1, Zehao Cai Bin Chen and Tao Liu “Social Policy Responses to the Covid-19 Crisis in China in 2020”⁸, В.Трубин, Н.Николаева, Т.Санишвили, В.Тарасова, “Социальная политика в зарубежных странах в условиях пандемии”⁹ г.м олон эрдэмтэн судлаачид эрдэм шинжилгээ судалгааны бүтээлүүдээ нийтлүүлсэн байна.

⁷ <http://www.cielolaboral.com>

⁸ <https://www.mdpi.com>

⁹ <https://ac.gov.ru/uploads/2-Publications/social/social.2020.3.pdf>

2. Судалгааны арга зүй

Судалгаа нь Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан “Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”, “Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль”-уудын хэрэгжилт, иргэдийн сэтгэл ханамж болон цаашдын үр дагаврыг тандан судлах зорилгоор индукци, дидукци болон статистикийн арга, мөн нийгмийн даатгалын шимтгэл төлөгч даатгуулагчдаас судалгааны түүврийг урьдчилан бэлтгэсэн асуумжаар цахим хэлбэрийг ашиглан цуглуулж статистикийн SPSS програм дээр тооцооллыг гүйцэтгэсэн болно.

3. Судалгааны ажлын үр дүн

Уг судалгааг асуулгыг 150 иргэнд явуулсан бөгөөд үүнээс 102 иргэн судалгаанд хамрагдлаа. Судалгааны өгөгдөлийг SPSS программ дээр тооцож дескриптив, реалибилити, факторын шугамын регрессийн шинжилгээг хийж үр дүнг хүснэгт 4-д харуулав. /Хүснэгт 4/

Хүснэгт 4. Судалгаанд оролцогчдын мэдээлэл

Case (N=102)				
#	Оролцогчдын мэдээлэл	Категори	Давтамж	Хувь (%)
1	Хүйс	Эрэгтэй	41	40.2%
		Эмэгтэй	61	59.8%
2	Нас	16-25	31	30.4%
		26-35	47	46.1%
		36-45	13	12.7%
		46-55	8	7.8%
		56-65	3	2.9%
		66 дээш	-	-%
3	Оршин суугаа газар	УБ	73	71.6%
		Аймаг	16	15.7%
		Сум	12	11.8%
		хөдөө	1	1.0%

Уг судалгаанд нийт 102 иргэн оролцсоноос оролцогчдын хүйсийн хувьд 40,2% буюу 41 эрэгтэй, 59,8% буюу 61 эмэгтэй даатгуулагч иргэн оролцсон. Насны хувьд 16-25 насны 30,4% буюу 31, 26-35 насны 46,1% буюу 47, 36-45 насны 12,7% буюу 13, 46-55 насны 7,8% буюу 8, 56-65 насны 2,9% буюу 3 иргэн оролцсон бол 66-аас дээш насны нэг ч иргэн хамрагдаагүй байна. Оршин суугаа газрын хувьд авч үзвэл судалгаанд оролцогчдын 71,6% буюу 73 иргэн Улаанбаатар хот, 15,7 % буюу 16 иргэн аймгийн төв болон бусад суурин газар, 11,8% буюу 12 иргэн сумын төв, 1 иргэн баг, хөдөө орон нутгаас оролцсон байна.

Хүснэгт 5. Хуулийн хэрэгжилтийн талаархи сэтгэл ханамжийн түвшин, үр дүн

№		1	2	3	4	5
	Асуулга	Давтамж/Хувь				
1	A-1	14/13.7	12 /11.8	39/8.2	21/20.6	16/15.7
2	A-2	11/10.8	7/6.	39/8.2	27/6.5	18/17.6
3	A-3	5/9,0	8/7.8	33/32.4	29/28.4	27/26.0
4	A-4	7/6.9	8/7.8	38/37.3	29/28.4	20/19.6
5	A-5	6/5.9	12/11.8	33/32.4	29/28.4	22/21.6
6	A-6	2/11.8	5/14.7	46/45.1	20/19.6	9/8.8
7	A-7	4/3.9	10/9.8	49/48.0	26/25.5	13/12.7
8	A-8	12/11.8%	14/13.7%	43/42.2%	21/20.6%	12/11.8%
9	A-9	3/2.9	9/8.8	44/43.1	22/21.6	24/23.5
10	A-10	4/3.9	7/6.9	37/36.3	26/25.5	28/27.5
11	A-11	3/2.9	6/5.9	30/29.4	26/25.5	37/36.3
12	A-12	2/2.0	1/1.0	20/19.6	15/14.7	64/62.7
13	A-13	11/10.8	7/6.9	25/24.5	12/11.8	47/46.1

Түүвэр судалгааг цахимаар дамжуулан авсан бөгөөд судалгаанд оролцогчдын 76,5% нь 16-25 болон 26-35 насны иргэд хамрагдсан, 66-аас дээш насны нэг ч иргэн хамрагдаагүй зэрэг нь иргэдийн цахим хэрэглээнд дээрхи насны иргэд түлхүү оролцон хэрэглэж буй нь харагдаж байгаа юм. Судалгаанд оролцогчдоос “НДШ-ээс чөлөөлөх, АД-ын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль” иргэдэд бодит дэмжлэг болж байна гэсэн асуултанд нийт 102 оролцогч оролцсоноос 26 оролцогч буюу 25,5% нь сэтгэл ханамжгүй, 57 оролцогч буюу 66,3% нь сэтгэл ханамжтай гэж хариулжээ.

“НДШ-ээс чөлөөлөх, АД-ын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-иар иргэдийн НД-ын шимтгэл төлөлт тасрахгүй болж ирээдүйн ӨН-ы тэтгэвэр, тэтгэмжийн баталгаа нь хангагдана гэсэн асуултанд 102 оролцогчдоос 18 буюу 16,8% нь сэтгэл ханамжгүй, 45 буюу 24,1% нь сэтгэл ханамжтай. Дээрх хуулийн дагуу 2020-4-9 сард НДШ-ийн чөлөөлөлтөд нийт 566,8 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдсөн гэсэн асуултанд 13 буюу 16,8% нь сэтгэл ханамжгүй, 56 буюу 54,4% нь сэтгэл ханамжтай. 2021-1-6-р сард ТДШ-ийг 1.0% тэтгэмжийн, ажилгүйдлийн болон ҮОМШӨ-ний ДШ-ийг бүрэн чөлөөлснөөр нийт 198.9 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөнө гэсэн асуултанд 15 буюу 14,9% нь сэтгэл ханамжгүй, 56 буюу 54,4% нь сэтгэл ханамжтай. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр ҮА нь зогссон, орлого нь буурсанч ажлын байрыг хадгалж байгаа төрийн өмчит ХЭ-ээс бусад ААН-ийн даатгуулагч иргэнд 2020-4-1-аас 2020-7-1 хүртэл АД-ын сангаас сар бүр 200.000 төгрөгийн дэмжлэг олгоно. /олгогдсон/ гэсэн асуултанд 18 буюу 17,7% нь сэтгэл ханамжгүй, 51 буюу 50,0% нь сэтгэл ханамжтай. 2020-3-25-аас 2021-1-1 хүртэлх хугацаанд НДБ-д шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн хувийн ААН, байгууллага, СД-аар даатгуулагч хуулийн үйлчлэлд хамаарахгүй гэсэн асуултанд 7 буюу 26,3% нь сэтгэл ханамжгүй, 39 буюу 28,4% нь сэтгэл ханамжтай гэж хариулжээ. Төрийн болон төсвийн байгууллага, гадаад ба ОУ-ын байгууллагын зээл тусламжаар ажил үйлчилгээ гүйцэтгэж буй ХЭ-ийн төсөл хөтөлбөрөөс цалинжиж буй даатгуулагч, гадаадын иргэн харьяалалгүй хүн хамаарахгүй гэсэн асуултанд 14 буюу 13,7% нь сэтгэл ханамжгүй, 39 буюу 38,3% нь сэтгэл ханамжтай

-2020-3-25-аас өмнө НД-ын байгууллагатай гэрээ байгуулж байгаагүй СД-ын даатгуулагч, НД-д бүртгэлгүй ажил олгогч нар хамрагдахгүй гэсэн асуултанд 26 буюу 25,3% нь сэтгэл ханамжгүй, 33 буюу 32,4% нь сэтгэл ханамжтай

- Хуульд заасан хугацаанд НД-ын шимтгэлээ төлөөгүй төрийн болон ОНӨ-т, түүний оролцоотой ХЭ-ээс бусад ААН, байгууллагыг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөнө гэсэн асуултанд 9 буюу 11,7% нь сэтгэл ханамжгүй, 46 буюу 55,1% нь сэтгэл ханамжтай

- 2020-3-24-аас өмнө гэрээ байгуулж, шимтгэл төлж байсан СД-ын даатгуулагчид НДШ-ийн чөлөөлөлтөд хамрагдана гэсэн асуултанд 11 буюу 10,8% нь сэтгэл ханамжгүй, 54 буюу 53,0% нь сэтгэл ханамжтай

- Цаашид өндөр насны тэтгэврийн доод хэмжээг 500 000 болгох нь зөв гэсэн асуултанд 3 буюу 3,0% нь сэтгэл ханамжгүй, 79 буюу 77,4% нь сэтгэл ханамжтай

- Цар тахлын үед Ерөнхийлөгчийн санаачилсан өрх бүрт 1 сая төгрөгийг өгөх нь зөв гэсэн асуултанд 17 буюу 17,7% нь сэтгэл ханамжгүй, 59 буюу 59,0% нь сэтгэл ханамжтай гэж тус тус хариулсан байна.

Хувьсагчийн найдвартай байдлын тест

Факторын шинжилгээ нь судлаачдын хувьд чухал хэрэгсэл юм. Энэ нь факторын бүтцийн хүчин төгөлдөр байдлыг үнэлэх, зарим таамаглалыг шалгахад ач холбогдолтой. Хүснэгт 6-аас харахад бүх хүчин зүйлийн ачаалал 0.5-аас их байна.

Хүснэгт 6. Хувьсагчийн найдвартай байдлын тест

	Хувьсагчууд	Хувьсагчийн зүйл	Кронба альфа (α)
1	Нийт	13	0.848

Хүснэгт 7. Фактор анализын үр дүн

		Component			
		1	2	3	4
A-1		.812			
A-2		.772			
A-3	1, 2.1	.696			
A-4	2.2	.655			
A-5	2.2	.530			
A-6	5		.841		
A-7			.822		
A-8	1		.692		
A-9			.539		
A-10	5			.809	
A-11	5			.756	
A-12	1.3			.686	
A-13					.912

Extraction Method: Principal Component Analysis.

Rotation Method: Varimax with Kaiser Normalization.

Хүснэгт 8. Шугаман регрессийн шинжилгээ (түүврийн хэмжээ=102)

Хамааралт хувьсагч “НДШ-ээс чөлөөлөх, Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль” -ийн хэрэгжилт				
1		Модель	Модель	Модель
2	A-1	.746***		
3	A-3		.211***	
4	A-3			122***

P<0.05 **P<0.01 ***P<0.001

НДШ-ээс чөлөөлөх, Ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль” -ийн хэрэгжилтийн сэтгэл ханамжийн үр дүнг тооцоходоо судалгааны 1, 3, 5 дугаар асуултыг сонгон авч шугаман регрессийн шинжилгээг гүйцэтгэлээ. Хуулийн дээрхи 3 заалт нь “НДШ-ээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль”-ийн гол заалтуудаар иргэдээс судалгаа авснаар хуулийн хэрэгжилт, сэтгэл ханамжийн түвшинг тооцсон.

ДҮГНЭЛТ

Дэлхий нийтээр тархсан цар тахлын үед УИХ, ЗГ иргэдэдээ чиглэсэн тэдний ажлын байрыг хадгалах, амьжиргааны түвшинг буурахаас сэргийлэх, орлогыг алдагдуулахгүй байхад ихээхэн анхаарч төрөл бүрийн арга хэмжээ авч байгаагийн хамгийн бодит тусламж нь нийгмийн даатгалын шимтгэлийг тэглэх, хөнгөлөх арга юм. Уг аргыг хэрэглэснээр иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт тасрахгүй ирээдүйн өндөр насны тэтгэвэр болон тэтгэмжийн баталгаа нь хангагдаж байгаа явдал юм. Дэлхийн Банкны Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн доорх санхүүжилтийг Засгийн газраас цар тахлын үед авч хэрэгжүүлж буй эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээг дэмжихэд зориулан 15 сая ам.долларыг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, бичил бизнес эрхлэгчид болон албан бус салбарт ажиллагсад зэрэг 120,000 орчим иргэдийг нийгмийн даатгалын шимтгэлээс 5 сарын хугацаанд чөлөөлөхөд зарцуулахаар шийдвэрлэсэн¹⁰. Зөвхөн 2020 оны 4-9 сард нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтөд 38,4 мянган ажил олгогч, тэдгээрт ажиллаж байгаа 410,6 мянган даатгуулагч, сайн дурын 156,5 мянган даатгуулагч хамрагдаж, нийт дүнгээр 566,8 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдсөн байна. Үүнээс нийт шимтгэл чөлөөлөлтийн 74,8 хувийг 31,8 хувийн хэвшлийн аж ахун нэгж, тэдгээрт ажиллаж буй 388,4 мянган даатгуулагч, 13,2 хувийг

¹⁰ <https://www.worldbank.org/mn>

1,9 мянган гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, тэдгээрт ажиллаж буй 42,3 мянган даатгуулагч тус тус эдэлсэн байна¹¹. Харин 2021 оны 1-6 дугаар сард тэтгэврийн даатгалын шимтгэлийг 1.0 хувиар, тэтгэмжийн, ажилгүйдлийн болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бүрэн чөлөөлснөөр 39 мянган ажил олгогч, 493.3 мянган албан журмын, 162.9 мянган сайн дураар даатгуулагч хамрагдах бөгөөд нийт дүнгээр 198.9 тэрбум төгрөгийн шимтгэлээс чөлөөлөгдөхөөр байна¹². Түүвэр судалгааг санамсаргүй түүврийн аргаар цахимаар дамжуулан авсан бөгөөд судалгаанд оролцогчдын 76,5% нь 16-25 болон 26-35 насны иргэд хамрагдсан, 66-аас дээш насны нэг ч иргэн хамрагдаагүй зэрэг нь иргэдийн цахим хэрэглээг дээрхи насны иргэд түлхүү оролцон хэрэглэж буй нь харагдаж байгаа юм. Судалгаанд оролцогчдын 71,6% буюу 73 иргэн Улаанбаатар хот, 15,7 % буюу 16 иргэн аймгийн төв болон бусад суурин газар, 11,8% буюу 12 иргэн сумын төв, 1 иргэн баг, хөдөө орон нутгаас оролцсон нь дээрхи хуулийн хэрэгжилтэнд Улаанбаатар хот болон хот суурин газрын даатгуулагч иргэд илүүтэй хамрагдсаныг харуулж байна.

Ном зүй:

Монгол хэл дээр: Хуулиуд

[1] Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хууль. 2020 оны 04 сарын 09

[2] Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийг торгох шийтгэл, алдангиас чөлөөлөх тухай хууль. 2020 оны 04 сарын 09

[3] Нийгмийн даатгалын тухай хууль. 1994 он

Монгол хэл дээр: Web

[1] Цар тахлын үед хүүхдийн хөдөлмөрөөс сэргийлэе. <https://www.ilo.org> > 2020 он

[2] News.mn 2020 он

[3] Parliament.mn

Гадаад хэл дээр: Web

[1] "[WHO Statement Regarding Cluster of Pneumonia Cases in Wuhan, China](#)". WHO. 31 December 2019. Retrieved 12 March 2020.

[2] Coakes, S. J., Steed, L., and Ong, C. (2009). *SPSS 16.0 for windows: Analysis without anguish*. Australia: John Wiley and Sons.

[3] June Namgoong PhD "The Republic of Korea's Policy Response to the Covid-19 epidemic in the field of employment and labour relations" <http://www.cielolaboral.com/>

[4] Quan Lu 1 , Zehao Cai Bin Chen and Tao Liu "Social Policy Responses to the Covid-19 Crisis in China in 2020" <https://www.ncbi.nlm.nih.gov/>

[5] "[Covid-19 Coronavirus Pandemic](#)". Worldometer. Retrieved 26 November 2020 <https://www.worldbank.org/mn>

[6] [Дума одобрила двукратное снижение социальных взносов для малого бизнеса.](https://www.rbc.ru/economics/2020/) <https://www.rbc.ru/economics/2020/>

[8] <https://www.worldbank.org/m>

¹¹ Parliament.mn

¹² News.mn 2020 он

SSBA-07

Мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх боломж:

Монгол улс

А. Пүрэвдулам

багш, судлаач (PhD) pvrevdulam@gmail.com

Хураангуй

Дэлхийн улс орнууд мэдлэг, ур чадвараар эдийн засгаа хөгжүүлэхийг улам бүр зорьж байна. Тэгвэл мэдлэг, ур чадварыг хэрхэн бий болгох вэ гэдэг нь амаргүй асуудал мөн. Нөгөөтэйгүүр улс орнууд өндөр ур чадвартай хүний нөөцийн хомсдолд ороод байна. Энэхүү хомсдлоос болоод макро түвшинд эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт алдагдаж байгаа нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал юм. Эдийн засгийн хөгжил цар тахлын энэ үед доройтож сэхэл авахад багагүй хугацаа шаардлагатай нь тодорхой боллоо. Ковид-19 халдвар тархаж байгаа хугацаанд мэдлэг үйлдвэрлэгч-их, дээд сургуулиудын үйл ажиллагаа зогсож сургалт цахим хэлбэрээр явагдаж байна. Мөн өндөр ур чадвартай мэргэжилтнүүдийг тасралтгүйгээр бэлтгэн гаргаж чадахгүйд хүрлээ. Эдгээр нь эдийн засгийн хөгжилд сөргөөр нөлөөлөх нь гарцаагүй. Харин цар тахлын үед хүн бүр цахим орчинд ажиллаж мэдээллийн технологийн талаархи мэдлэг, ур чадвараа дээшлүүлж инноваци шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох нь чухал гэдгийг ухамсарлаж байж болох юм.

Энэхүү судалгаа нь улс орны эдийн засгийн хөгжил, мэдлэгтэй, ур чадвартай хүний нөөц, боловсрол хоорондын хамаарал болон мэдлэгт суурилсан эдийн засгийг хөгжүүлэх боломжийг судлах зорилготой. Судалгааны арга зүй: Түүврийн аргаар урьдчилсан бэлтгэсэн асуумжаар өгөгдлийг цуглуулсан бөгөөд судалгаанд 140 хүн хамрагдсан. Судалгааны өгөгдлийг статистикийн SPSS v24, Amos v26 програм дээр дескриптив, релябилити, факторын болон баталгаажуулах анализ, бүтцийн тэгшитгэлийн загварын шинжилгээг гүйцэтгэлээ. Хүний нөөц болон боловсрол, мэдлэгт суурилсан эдийн засаг нь “эдийн засгийн хөгжил”-тэй эерэг, хүчтэй хамааралтай гэдгийг судалгааны үр дүн харуулсан.

Энэхүү судалгаа нь онолын болон практикийн ач холбогдолтой төдийгүй цаашид судлагдах бүрэн боломжтой.

Түлхүүр үгс: мэдлэгт суурилсан эдийн засаг, эдийн засгийн дэглэм, боловсрол болон хүний нөөц, Үндэсний инновацийн систем, Үндэсний мэдээллийн дэд бүтэц.

УДИРТГАЛ

Монголын эдийн засаг Корона вирусийн (КОВИД-19) цар тахлын өмнөх гурван жилд тогтвортой өссөн боловч цар тахлын сөрөг нөлөөгөөр 2020 онд аж үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт буурч дотоодын нийт бүтээгдэхүүн сүүлийн 11 жилд анх удаа агшсан таагүй мэдээтэй. Монгол улсын хувьд дээд боловсрол эзэмшигчдийн тоо жилээс жилд өсч байна. Мөн мэдлэг үйлдвэрлэгч их, дээд сургуулийн тоо ч 3 сая хүн амтай манай улсад хангалттай юм. Мөн гадаадад суралцаж боловсрол эзэмшиж байгаа үзүүлэлт чамлахааргүй байна. Тодруулбал гадаадад дээд боловсрол эзэмшсэн хүмүүс тухайн улсдаа төдийгүй эх орныхоо эдийн засагт хувь нэмэр оруулж байгаа бөгөөд энэ нь цаашид өсөх магадлал өндөр юм. Харин мэдлэгийн салбарт зөв бодлого, дэмжлэг дутагдсаар байгаа. Монгол улсын хувьд зөвхөн уул уурхайгаас ашиг орлого хараад зогсохгүй мэдлэгийн салбарыг эрчимтэй хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тулгараад байна. Энэ нь мэдлэг үйлдвэрлэх, үнэ цэнэтэй болгох улмаар эдийн засгийн эргэлтэд оруулна гэсэн үг. Мэдлэг нь боловсролоор дамжин үйлдвэрлэгдэх процесс бөгөөд энэхүү процесст оролцогчид нь төр, боловсролын байгууллага, хувь хүн, иргэний нийгмийн байгууллагууд. Энэхүү судалгаа мэдлэгийн эдийн засаг, хүний нөөц

боловсрол, эдийн засгийн дэглэм, үндэсний инновацийн систем болон үндэсний мэдээллийн дэд бүтэц нь эдийн засгийн хөгжилд хэрхэн нөлөөлөхийг судлах зорлогтой.

Цар тахлаас шалтгаалан эдийн засгийн салбар уналтад орсон. Харин энэ үед мэдлэгийн салбарт ахиц дэвшил гарсан хэмээн судлаачид үзэж байна. Тодруулбал мэдлэг, ур чадвараа ашиглан ашиг орлого олох тухайлбал цахим хэлбэрээр хичээл, сургалт явуулах, мэргэжлийн хэлэлцүүлэг, мэтгэлцээн зохион байгуулан мэдлэг олгох, түгээх ажлууд эрчимтэй явагдсаар байна. Олон улсын эрдэм шинжилгээний хурлууд семинар хэлбэрт шилжээд багагүй хугацаа өнгөрлөө. Эрдэм судлаач, багш нар оюуны бүтээлээ зөвхөн номын дэлгүүрт худалдахаар санал болгодог байсан бол цахим хэлбэрт шилжүүлэн олон тооны хүмүүст электрон худалдаа хийх боломжийг мөн олголоо. Мэдээллийн технологи болон интернетийн ашигт болон хялбар бадлыг мэдэрч үүний тусламжтайгаар ашиг орлогоо нэмэгдүүлж шинэ шинэ бизнесүүд дэлгэрч байна. Оюутан, суралцагчид цахимаар суралцаж бие даан хөгжих боломж бүрдлээ. Энэ нь боловсрол глобальлагдаж дотооддоо төдийгүй олон улсад мэдлэг, ур чадвараа үнэлүүлэх боломжтой гэдгийг батлан харуулж байна.

Өнөөдөр дэлхий дахинаа нүүрлээд буй Ковид-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор сүүлийн хоёр жил эдийн засгийн хямралтай нүүр тулаад байна. Дэлхий даяараа хөдөлмөрийн зах зээлд түүхэнд байгаагүй хямрал нүүрлэж, эдийн засгийн огцом, бууралт ажиглагдаад байгааг мэргэжилтнүүд онцоллоо. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын тайланд 2020 оны 4-р сарын эцсийн байдлаар дэлхийн хэмжээнд КОВИД-19 цар тахлаар халдварласан хүний тоо 2.8 саяас давж, нас барсан хүний тоо бараг 195,000 хүрээд байжээ. Тэгвэл 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 160 сая халдвар бүртгэгдэж 3.4 сая хүн нас барсан байна. Бүх улс орнуудад боловсрол олгох үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжиж улмаар оюутан, сурагчид бие даан суралцах болсон билээ. Энэ нь оюутан суралцагчдад мэдээллийн технологи ашиглах, бие даан суралцах чадвар дадлыг эзэмшүүлснээрээ давуу талтай байж болох юм. Нөгөө талаараа зарим мэргэжлийн үйлдвэрлэлийн дадлагын ажил хийгдээгүй, мөн мэргэшүүлэх хичээлийг бүрэн дүүрэн судлаагүй нь төгсөгчдөд хохиролтой. Боловсрол олголтын хувьд Монгол улс харьцангуй өндөр үзүүлэлттэй (ҮСХ-ны тайлан 2017 он) хэдий ч нарийн мэргэжлийн тусгай ур чадвартай боловсон хүчин бэлтгэн гаргаж буй байдалд сайн үзүүлэлт харагдахгүй л байна. Монгол улсад Хүмүүнлэг 8.6%-аас 7.1% болж 1.5%-аар, Нийгэм, бизнес, удирдлага, эрх зүй 37.0%-аас 33.0% болж 4.0%-аар Үйлчилгээ 5.8%-аас 4.0% болж 1.8%-аар тус тус буурсан бол Байгалийн шинжлэх ухаан, математик, статистик, мэдээлэл, харилцаа холбооны технологи, инженерчлэл 23.6%-аас 25.8% болж 2.2%-аар, Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал 9.3%-аас 11.8% болж 2.5%-аар, Боловсрол 12.7%-аас 13.6% болж 0.9%-аар тус тус өсчээ. Эдгээр салбарт ажлын байр харьцангуй эрэлт ихтэй байгааг харуулж байна.

Эдийн засгийн хөгжлийг эдийн засгийн дэглэм, инновацийн систем, мэдээллийн дэд бүтэц, боловсрол болон хүний нөөцийн тусламжтайгаар мэдлэгт суурилсан эдийн засаг бий болох бөгөөд эндээс эдийн засгийн хөгжил харагдана гэж үздэг.

Эдийн засгийг хөгжүүлэхэд мэдлэг чухал үүрэг гүйцэтгэнэ гэдгийг дэлхийн олон судлаачид онцолж байна. **Мэдлэгийг хэрхэн бий болгох** вэ гэсэн асуулттай тулгарч байна. Сүүлийн жилүүдэд мэдлэгийг бий болгох үйл явц улам бүр нарийсч бас төвөгтэй болж байна. Тодруулбал байгууллага, аж ахуйн нэгжид ашиглах мэдлэгийн олон төрлийн эх үүсвэр, орцууд нэмэгдэж, жүжигчид (хувь хүмүүс, компаниуд болон бусад байгууллагуудын харилцан хамаарал, хөдөлмөрийн хуваарилалт илүү их байна). The knowledge creation and innovation processes in recent years has become increasingly complex: there is a larger variety of knowledge sources and inputs to be used by organisations and firms and there is more interdependence and division of labour among actors (individuals, companies, and other organisations).

2. ОНОЛЫН ТОЙМ

Энэ хэсэгт эдийн засгийн хөгжилд нөлөөлөх хүчин зүйл болох эдийн засгийн дэглэм, инновацийн систем, мэдээллийн дэд бүтэц, боловсрол болон хүний нөөц, мэдлэгт суурилсан эдийн засгийн харилцан хамаарлын талаар авч үзсэн.

2.1 Боловсрол болон хүний нөөц эдийн засгийн хөгжлийн хамаарал

Одоогоос 100 жилийн өмнө Adam Smith, John Stuart Mill, and Alfred Marshall нар Боловсрол бол

аливаа өсөлтөд заавал сайнаар нөлөөлдөг хэмээн тодорхойлжээ. Тэгвэл боловсрол нь эдийн засгийн өсөлтийг өдөөж, хүмүүсийн амьдралыг олон сувгаар дээшлүүлдэг, тухайлбал ажиллах хүчний үр ашгийг дээшлүүлдгийг Барро, 1997 оны “The Determinants of Economic Growth, MIT Press, Cambridge, Massachusetts” Эрдэм шинжилгээний бүтээлээрээ гаргаж тавьжээ. Илүү их, илүү чанартай боловсрол нь дэлхийн эдийн засгийн хурдацтай хөгжлийн урьдчилсан нөхцөл хэмээн Thorvaldur Gylfason, (2000) судалгаандаа онцлон тэмдэглэсэн байдаг. Боловсрол бол нийгэм болоод эдийн засагт үр ашгаа байнгаа өгч байх ёстой байдаг. Засгийн газар олон нийтийн боловсролын системээс гадна корпорацууд болон бусад хувийн байгууллагуудад ажилчдаа хөгжүүлэхэд хөрөнгө оруулалт, татварын урамшуулал олгож болно (Suhail S. Zidan). Тусгай мэргэжлийн боловсон хүчний тоо их байх тусам эдийн засгийн хөгжилд багагүй хувь нэмэр оруулна.

2.2 Эдийн Засгийн дэглэм (economic regime)

Эдийн засгийн дэглэм бол дүрэм журам болон институциар тодорхойлогддог бүхэл бүтэн систем юм. Энэ нь тодорхой нэг загвар. Үүнийг өөрчилж болох ба динамик шинжтэй гэж ойгож болно. Эдийн засгийн аль ч тогтолцоонд нэгээс илүү боломжтой байх, ингэснээр чанарын хувьд ялгаатай динамик зан үйлийн бүхэл бүтэн цэсийг багтаах дэглэмийн тухай ойлголт (JG Brida, LF Punzo, M Puchet Anyul, 2008). Эндээс эдийн засгийн дэглэм гэдэг бол эдийн засгийн тогтсон үзэл хандлага, арга шийдэл гэж ойлгож болох нь харагдаж байна. Төрийн зүгээс эдийн засагт хүчтэй оролцоогоо багасгаж чөлөөт зах зээлийг дэмжих шаардлагатай. Эдийн засагт төр ямар үүрэгтэйгээр оролцох вэ гэдэг хамгийн чухал байдаг. Тухайлбал цар тахлын үед Засгийн газрууд эдийн засгийг хяналтад авах томоохон алхам хийх, эдийн засгийн хяналтынхаа хүрээг тэлж, төрийн хүчтэй эрх мэдлээ үргэлжлүүлэхийн тулд эдийн засгийн дэглэмээ тогтвортойгоор барьж байх нь тодорхой.

1.1. Үндэсний инновацийн систем

Инновацийн систем нь инновацийн бодлогыг зах зээлийн уналтаар хязгаарлахгүйгээр инновацийн үйл явцад дүн шинжилгээ хийх, түүнд нөлөөлөх хэрэгслийг бодлого боловсруулагчдад санал болгодог (Инновацийн эдийн засгийн гарын авлага, 2010).

Үндэсний инновацийн системийн нийтлэг шинж бол үйлдвэрлэл, худалдаа, мэдлэгийн чиглэлээр мэргэшсэн байдгаараа ялгаатай гэсэн таамаглал байсан байна (Archibugi and Pianta 1992). Улс орнууд үндэсний инновацийн системийн хүрээнд юу хийдэг, хувиараа бизнес эрхлэгчид болон пүүсүүд юуг илүү сайн хийхээ мэддэг зүйлсийн хоорондын хамтын хувьсал дээр анхаарлаа төвлөрүүлэх нь оновчтой гэж үздэг байна. Энэ нь үйлдвэрлэлийн бүтэц, мэдлэгийн бүтэц хоёулаа аажмаар өөрчлөгдөх бөгөөд ийм өөрчлөлтөд суралцахаас гадна бүтцийн өөрчлөлтийг давхар хийх шаардлагатай юм. Мөн инновацийн систем бол эдийн засгийн гүйцэтгэлд чухал ач холбогдолтой мэдлэгийн элементүүдийг нутагшуулж, нэг газраас нөгөөд шилжихэд хялбар байдаггүй (Björn Johnson, Charles Edquist Bengt-Åke Lundvall нар). Фрийман ба үндэсний инновацийн тогтолцооны хандлагын ‘Aalborg хувилбар’ (Freeman 1987; Freeman and Lundvall 1988) нь ‘инновацийн системийг өргөн утгаар нь ойлгох’ зорилготой. ‘Инноваци’ гэсэн тодорхойлолт илүү өргөн байдаг. Инновацийг зөвхөн радикал ба өсөн нэмэгдэж буй инновацаас гадна инновацийн тархалт, шингээлт, хэрэглээг хамарсан тасралтгүй хуримтлагдах процесс гэж үздэг. Түүнчлэн инновацийн эх үүсвэрийг харгалзан үздэг. Шинэлэг зүйл нь худалдан авалт, үйлдвэрлэл, борлуулалтын чиглэлээр хийгдэж буй үйл ажиллагаатай холбоотойгоор шинжлэх ухаан, судалгаа, шинжилгээний үйл ажиллагаанаас гадна интерактив сургалтыг тусгасан гэж үздэг. Хөгжиж буй орнуудын хувьд эдийн засагт инновацийг бий болгоход хамгийн чухал ач холбогдолтой чадварын суурь нь шинжлэх ухааны мэдлэг биш хэмээн тэмдэглэжээ. Үндэсний инновацийн систем нь хэд хэдэн үүрэгтэй. Үүнд:

- Үндэсний инновацийн бодлогыг томъёолж цааш хөгжүүлэх
- инновацийг үйлдвэрлэх зорилгоор хууль тогтоомж, зохицуулалт, зохион байгуулалт, эдийн засгийн орон зайг бүрдүүлэх, зохицуулах
- үндэсний нийгэм, эдийн засгийн хөгжлийн шинжлэх ухааны инновацийн тэргүүлэх чиглэлийг сонгох, зохион байгуулах;
- инновацийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах үндсэн төрлийн нөөцийг хуваарилах,
- микро, макро эдийн засгийн түвшинд инновацийн үйл ажиллагааг идэвхжүүлэх;

- материаллаг бус хөрөнгө бий болгох замаар хүний чадавхийг хөгжүүлэх үндэсний бааз бүрдүүлэх улмаар оюуны капиталыг хуримтлуулах;
- шинэ үйлдвэрлэлийг дэмжих,
- үйлчилгээ, болон үндэсний эдийн засгийн бусад салбарууд хамаардаг байна.

1.2. Үндэсний Мэдээллийн дэд бүтэц

Үндэсний мэдээллийн дэд бүтэц бол хүн амд мэдээллийн дэвшилтэт үйлчилгээг санал болгодог дэд бүтцийг бий болгохыг чиглэсэн байдаг. Википедиад тодорхойлсноор үндэсний мэдээллийн дэд бүтэц нь айл өрхүүдийн Суурин утасны холболт (Telephone density), Интернет холболт (Internet density), Хувийн компьютертэй эсэх (Personal computer density), Радиогийн шугамд холбогдсон эсэх (Radio density), Сонин хэвлэл захиалах боломжтой эсэх (Newspaper circulation density) гэсэн бүрдэлтэй. Энэхүү дэд бүтцийг ий болгосноор бүс нутаг цаашлаад үндэсний хэмжээнд эдийн засгийн өсөлт хангагдана гэж үздэг.

1.3. Мэдлэгийн эдийн засаг (мэдлэгт суурилсан эдийн засаг)

Мэдлэгийн эдийн засаг (эсвэл мэдлэгт суурилсан эдийн засаг) гэдэг нь техник, шинжлэх ухааны инновацийн хурдацтай дэвшилд хувь нэмэр оруулах, мэдлэг, үйлчилгээ шаардсан үйл ажиллагаанууд дээр суурилдаг эдийн засгийн тогтолцоо юм. Энэ нь уламжлалт эдийн засгаас дараах шинжээр ялгагдана (Википедиа). Үүнд:

Нөөц нь мэдлэг бөгөөд нөөцийн хомсдол үүсдэггүй. Тодруулбал мэдлэгийн эдийн засаг нь хомсдол биш, харин элбэг дэлбэг байдал юм. Хэрэглэж дуусахад дахин ашиглагддаг ихэнх нөөцөөс ялгаатай нь мэдээлэл, мэдлэгийг хуваалцаж, програмаар дамжуулан өсдөг. Мэдлэг гэх энэхүү нөөцийн хувьд байршлын нөлөөллийг бууруулдаг.Тохиромжтой технологи, аргыг ашиглан виртуал зах зээл, виртуал байгууллагуудыг бий болгож, хурд, авхаалж самбаа, цаг наргүй ажиллах, дэлхийн хэмжээнд хүрэх давуу талыг бий болгож чадна.

Үнэ, үнэ цэнэтэй байдлаараа давуу.

Дэлхийн банк, OECD нь мэдлэгт суурилсан эдийн засаг бий болгох чиглэлээр үйл ажиллагаандаа хамтран ажиллаж ажиллаж байсан бөгөөд шилжилтийн үеийн улс орнууд тэдэнд хүчин чармайлт гаргахад нь тусалсан. Дэлхийн Банкны Хүрээлэнгээс хөгжүүлэх хөтөлбөрийн мэдлэгийн менежер Карл Далманы бодлоор: "Мэдлэгийн хувьсгалаас хүртэхийн тулд мэдлэгийн эдийн засгийн 4 тулгуурыг хангаж чадахуйц тодорхой стратегиуд шаардлагатай байна" гэжээ. Үүнд:

1. Мэдлэгийн ашигт болон үр дүнтэй байдлыг дэмжих Институцийн болон эдийн засгийн бүтэц тогтолцоотой байх
2. Мэдээллийн динамик дэд бүтэцтэй байх
3. Хүмүүсийн шинэ хүслийг хангаж чадахуйц байгууллага доторх үр дүнтэй инновацийн систем ба судалгааны төвтэй байх

Эдийн засгийн хөгжил (Economic development)

Дэлхийн эдийн засгийн хөгжил хэмээн ярьдаг хэдий ч гол төлөв Үндэсний буюу аль нэг улсын эдийн засгийн хөгжилд анхаарлаа төвлөрүүлдэг.

4. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ /METHODOLOGY/

Энэ хэсэгт судалгааны түүвэр цуглуулалт, дата анализ болон судалгааны загвар, таамаглалыг танилцуулсан.

3.1 Онолын загвар ба таамаглал

Энэхүү судалгааны онолыг загвараар хамааралт хувьсагч нь “Эдийн засгийн хөгжил” (ЭЗХ), хамааралт бус буюу бие даасан хувьсагчдад “Боловсрол, хүний нөөц” (БХН); “эдийн засгийн дэглэм (ЭЗД)”; “Үндэсний инновацийн систем (ҮИС)” Үндэсний “Мэдээллийн дэд бүтэц “ (ҮМДБ) багтах бөгөөд мэдлэгийн эдийн засаг (МЭЗ) нь зуучлагч хувьсагч багаад тэдгээрийн хамаарлыг Зураг 1-т үзүүлсэн.

Зураг 1. Судалгааны загвар

Судалгааны таамаглал

Өмнөх судлаачдын дэвшүүлсэн таамаглал, судалгааны үр дүнг судалсны үндсэн дээр дараах таамаглалыг дэвшүүллээ /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Судалгааны таамаглал

Таамаглал	Таамаглалын томъёолол
Таамаглал 1	Боловсрол, хүнийн нөөц (БХН) нь эдийн засгийн хөгжилтэй (ЭЗХ) эерэг хамааралтай.
Таамаглал 2	Эдийн засгийн дэглэм (ЭЗД) нь эдийн засгийн хөгжилтэй (ЭЗХ) эерэг хамааралтай.
Таамаглал 3	Үндэсний инновацийн систем (ҮИС) нь эдийн засгийн хөгжилтэй (ЭЗХ) эерэг хамааралтай.
Таамаглал 4	Үндэсний мэдээллийн дэд бүтэц (ҮМДБ) нь эдийн засгийн хөгжилтэй (ЭЗХ) эерэг хамааралтай.
Таамаглал 5	Мэдлэгийн эдийн засаг (МЭЗ) нь эдийн засгийн хөгжилтэй (ЭЗХ) эерэг хүчтэй хамааралтай.
Таамаглал 6	

5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын хүн ам зүйтэй холбоотой 3 төрөл мэдээллийг SPSS програм дээр тооцсон. Оролцогчдын 32.9% нь эрэгтэй, 67.1% нь эмэгтэй байсан. Насны хувьд 5 ангилалд хуваасан ба нийт оролцогчдын 35% нь 30-39 насны ангилалд, 27.1% нь 20-29 насны ангилалд, 23.6% нь 40-49 насны ангилалд, 10% нь 50-59 насны ангилалд, 4.3% нь 60 ба түүнээс дээш насны ангилалд тус тус багтсан байна. Судалгаанд оролцогчдоос 29.3% (41) эрх зүйч, бусад ажил мэргэжлийн 24.3% (34), инженер мэргэжилтэй 13.6% (19), багш 10% (14), санхүү нягтлан бодох бүртгэл 8.6% (12), эмч сувилагч 6.4% (9), эдийн засагч 4.3% (6), статистикч 3.6% (5) тус тус эзэлж байв /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогчдын профайл

#	Оролцогчдын мэдээлэл	Түүвэр (n=140)		
		Категори	Давтамж	Хувь (%)
1	Хүйс	Эрэгтэй	46	32.9%
		Эмэгтэй	94	67.1%
2	Нас	20-29	38	27.1%
		30-39	49	35%
		40-49	33	23.6%
		50-59	14	10.0%
		60 түүнээс дээш	6	4.3%
3	Мэргэжил	Эдийн засагч	6	4.3%
		Санхүү, нягтлан бодох	12	8.6%
		Эрх зүйч	41	29.3%
		Инженер	19	13.6%
		Статистикч	5	3.6%
		Багш	14	10.0%
		Эмч сувилагч	9	6.4%
		Бусад	34	24.3%

Дата анализ

Анализ хэсэгт цуглуулсан өгөгдлийг SPSS тооцооллын програм дээр дескриптив, хувьсагчийн найдвартай байдлын болон фактор анализ хийсэн. Хүснэгт 2-д хувьсагчийн найдвартай байдлын тестийн үр дүнг харууллаа. Кронба альфа (α) 0.7-оосд ээш гарсан тул дараагийн факторын шинжилгээг гүйцэтгэх боломж бүрдсэн.

Хүснэгт 2. Хувьсагчийн найдвартай байдлын тест (reliability test)

#	Хувьсагчууд	Хувьсагчийн код	Хувьсагчийн зүйл	Кронба альфа (α)
1	Эдийн засгийн хөгжил	ЭЗХ	5	0.833
2	Боловсрол, хүний нөөц	БХН	6	0.636
3	Эдийн засгийн дэглэм	ЭЗД	2	0.766
4	Үндэсний инновацийн систем	ҮИС	5	0.818
5	Үндэсний мэдээллийн дэд бүтэц	ҮМДБ	5	0.869
6	Мэдлэгийн эдийн засаг	МЭЗ	5	0.814

Хувьсагчийн найдвартай байдал ба үнэн зөвийг шалгах шинжилгээ

Хүчин зүйлийн шинжилгээ нь судлаачдын хувьд чухал хэрэгсэл юм. Энэ нь факторын бүтцийн хүчин төгөлдөр байдлыг үнэлэх, зарим таамаглалыг шалгахад ач холбогдолтой. [20] нарын судалгааны үр дүнгээр КМО коэффициент нь 0.6-аас их байхыг шаарддаг. [21] дагуу хүчин зүйлийн ачаалал 0.7-оос дээш байвал тухайн факторыг хүчинтэйд тооцно. Хүснэгт 1-ээс харахад бүх хүчин зүйлийн ачаалал 0.5-аас их байна. Bartlett's Sphericity Test-ээр КМО 0.6-аас их байгаа тул энэхүү судалгааны хувьсагчуудын хүчинтэй, найдвартай байдал батлагдсан. Хувьсагчуудын найдвартай байдлын коэффициент 0.921 нь $\alpha \geq .7$ түвшингээс нэлээд өндөр байв. Харин Кай квадрат нь утга $p < .001$ үед $\chi^2 = 1547.291$ буюу ач холбогдолтой байсан. Эндээс шалгагдсан хувьсагчууд, түүний асуултууд тохиромжтойг илтгэж байна. Энэхүү судалгааны хувьсагчууд хүчин төгөлдөр байгаа тул статистикийн дараагийн шинжилгээг хийх боломжтой.

Хүснэгт 1: Факторын ба хүчин төгөлдөр байдлын шинжилгээ

Хувьсагч	Хувьсагчийн Зүйл	Утга	Стандарт хэлбэлзэл	Дисперсийн хувь %	Ачаалсан		Кронба ал ьфа
					EFA	CFA	
БХН	БХН 4	4.23	.977	33.68	0.438	0.659	0.636
	БХН 6	4.24	.830		0.737	0.642	
ЭЗД	ЭЗД 1	3.48	.956	45.14	0.796	0.780	0.766
	ЭЗД 5	3.73	1.018		0.613	0.635	
ҮИС	ҮИС 1	4.24	.864	51.18	0.756	0.709	0.818
	ҮИС 3	4.33	.852		0.698	0.712	
ҮМДБ	ҮМДБ4	2.72	1.230	56.03		0.873	0.869
	ҮМДБ5	2.89	1.110		0.860	0.889	
МЭЗ	МЭЗ 3	4.34	.934	60.03	0.733	0.695	0.814
	МЭЗ 4	4.23	.884		0.762	0.913	
	МЭЗ 5	4.18	.900		0.718	0.840	
ЭЗХ	ЭЗХ 1	4.20	.850	63.18	0.653	0.544	0.833
	ЭЗХ 4	3.84	.979		0.501	0.679	
	ЭЗХ 5	4.01	.865		0.523	0.778	
Бүгд	КМО			.870			.923
	P-үзүүлэлт			.000			

Хүчин зүйлийг баталгаажуулах шинжилгээ Мэдлэгт суурилсан эдийг засагт шилжихдээ төрөөс мэдлэгийн салбарт анхаарал хандуулж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна. Хүчин зүйлийн шинжилгээний дараа хувьсагчийн хүчинтэй, хоорондын хамаарлыг шалгах шинжилгээг AMOS v24 тооцооллын програм дээр шинжилсэн Хүчин зүйлийг баталгаажуулах шинжилгээ нь судалгааны модель дахь хувьсагчийн хамаарлыг шалгаж улмаар сайжруулдаг давуу талтай. Шинжилгээгээр холбогдох бүх үзүүлэлтүүд онолын дагуу нийцтэй гарсан ($\chi^2 = 1.725$, $(df = 155)$; $p\text{-value} = .000$ ач холбогдолтой; $RMSEA = 0.72$; $NFI = 0.82$; $CFI = 0.91$; $GFI = 0.94$). Улмаар энэхүү судалгааны онолын загвар зөвшөөрөгдсөн. Хүчин зүйлийн нийцэл, хамаарал, баталгаатай байдлыг шалгасан үр дүнг хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Хүчин зүйлийн нийцэл, хамаарлын шинжилгээний үр дүн

	CR	AVE	MSV	Max r	EHR	KBE	NIS	IInstruc	ER	ED
EHR	0.794	0.673	0.469	0.501	0.723					
KBE	0.852	0.661	0.569	0.415	0.784	0.813				
NIS	0.844	0.731	0.669	0.413	0.877	0.703	0.855			
IInstruc	0.876	0.641	0.217	0.073	0.251	0.135	0.056	0.800		
ER	0.749	0.528	0.404	0.347	0.565	0.527	0.464	0.466	0.754	
ED	0.764	0.519	0.440	0.552	0.860	0.818	0.763	0.256	0.839	0.721

Note: CR > 0.7; AVE > 0.5; MSV < AVE; $\sqrt{AVE} > \text{Max } r$, \sqrt{AVE} is **bold face diagonal**

Хүчин зүйлийн нийцэл, хамаарлыг шалгах энэхүү шинжилгээ нь хувьсагчуудын хоорондоо хир нийцтэй болон нэг нь нөгөөгөөсөө хир зэрэг хамааралтай эсэхийг шалгадаг. Хүчин зүйлийн итгэлцүүр нь “нийлмэл байдал буюу найдвартай эсэх” болон “дундаж өөрчлөлт” гэсэн хэсгээс бүрдэнэ. Хувьсагчийн асуултууд хоорондоо уялдаа холбоотой байснаар тухайн хувьсагчийг илэрхийлж чадахуйц байх ёстой (Андерсон ба Гербинг, 1988). Үүнийг нийлмэл, найдвартай байдал буюу “CR” гэж тэмдэглэсэн. “AVE” нь тухайн хувьсагчийг төлөөлөх ба түүний нэгдмэл байдлыг харуулдаг (Fornell and Larcker, 1981). Энэ нь тухайн хувьсагчийн “зүйлүүд”-ийн дундаж өөрчлөлтийн хувь хэмжээ юм (Андерсон ба Гербинг, 1988). Андерсон ба Гербинг (1988) нарын саналаар CR нь 0.7-аас дээш байх ёстой гэж үзсэн бол Fornell болон Larcker (1981) нар AVE нь багадаа 0.5 байхыг санал болгодог ба энэхүү судалгааны хувьд шалгуурын хангасан ба CR болон AVE судалгааны үр дүнг 2-р хүснэгтэд үзүүлэв. Энэхүү шинжилгээний үр дүн санал болгож буй судалгааны онолын загварыг онолын үндэслэлтэй, хувьсагчуудын хүчинтэй, нийцтэй байгааг баталж байна.

Таамаглал шалгасан үр дүн

Судалгаагаар дэвшүүлсэн 6 таамаглалыг шалгаж үр дүнг хүснэгт 3-т харуулсан.

Хүснэгт 3: Таамаглалын үр дүн

Таамаглал	Зам	Үр дүн	Таамаглал дэмжигдсэн эс эх
T1	БХН → ЭЗХ	.657***	Дэмжигдсэн
T2	ЭЗД → ЭЗХ	.084(NS)	Няцаагдсан
T3	ҮИС → ЭЗХ	.129(NS)	Няцаагдсан
T4	ҮМДБ → ЭЗХ	.725***	Дэмжигдсэн
T5	МЭЗ → ЭЗХ	.171(NS)	Няцаагдсан

*p < .05, **p < .01, ***p < .001. NS- (ач холбогдолгүй)

Standardized Total Effects (Group number 1 - Default model)

	NIS	IInstruc	ER	EHR	ED	KBE
IInstruc	.167					
ER	.083	.496				
EHR	.981	.201				
ED	.840	.248	.403			
KBE	.814	.247	.532		.782	

Хүснэгт 4: Зуучлагч хувьсагчаар таамаглал шалгасан үр дүн

Зам	Шууд бус хамаарал	Шууд хамаарал	Бүгд	Зуучлагч
T7 УХМ→(БУА, АХМ)→АСХ (Model)	0.448***	0.084 (NS)	0.528**	Дэмжигдсэн

*p < .05, **p < .01, ***p < .001. NS-(ач холбогдолгүй)

Таамаглал 9 давхар зуучлагч хувьсагчийн нөлөөг харуулсан ба энэхүү таамаглал дэмжигдсэн. Удирдлагын хэв маяг ажлын хэв маягтай хосолсноор ажлын сэтгэл ханамжид нөлөөлж болохыг таамагласан 10-р таамаглал дэмжигдсэн. Таамаглал 9-тэй харьцуулахад $\beta=0.449$ болж өссөн. Мөн удирдлагын хэв маяг байгууллагын уур амьсгалын нэгдэл ажлын хэм маягт нөлөөлнө гэсэн “таамаглал 11” дэмжигдсэн ба хамаарлын нөлөө эрс өссөн ($\beta=0.605$). Эцэст нь “байгууллагын уур амьсгал ажлын хэм маягийн тусламжтайгаар ажлын сэтгэл ханамжид нөлөөлнө” гэсэн 3Таамаглал 12” мөн дэмжигдсэн.

ДҮГНЭЛТ БА ШҮҮМЖЛЭХҮЙ

Энэхүү судалгаа нь Ковид-19 цар тахлын үед хийгдсэнээрээ онцлог юм. Үндэсний эдийн үасгийн хөгжил Боловсрол, хүний нөөц, үндэсний инновацийн систем, эдийн засгийн дэглэм, үндэсний мэдээллийн дэд бүтэц, мэдлэгт суурилсан эдийн засгаас хамаарна хэмээн таамаглан эдгээр хүчин зүйлийн нөлөөллийг судлах зорилго тавьсан. Сэдвийг судлах болсон үндэслэл нь хангалттай тооны их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж дээд боловсролтой хүмүүсийг бэлтгэн гаргаж байгаа хэдий ч тусгай ур чадвартай, нарийн мэргэжлийн ажиллах хүчний дутагдалтай, хөгжлийн хувьд удаашралтай, инновацийн систем болон үндэсний мэдээллийн дэд бүтэц тааруу хөгжсөн,

Дээрх хүчин зүйлийг цогцоор нь хөгжүүлж байж эдийн засгийн хөгжил хурдасгах боломжтой юм. Иймд энэхүү судалгаа дээрх хүчин зүйлийн хамаарлыг шинжлэн судалсан.

Мэдлэгт суурилсан эдийн засагт шилжихдээ төрөөс мэдлэгийн салбарт анхаарал хандуулж дэмжлэг үзүүлэх шаардлагатай байна.

Ашигласан материал

Coakes, S. J., Steed, L., and Ong, C. (2009). *SPSS 16.0 for windows: Analysis without anguish*. Australia: John Wiley and Sons.

Hair, J. F., Black, W. C., Babin, B. J., and Anderson, R. E. (2009). *Multivariate data analysis*. Upper Saddle River, New Jersey, NJ: Pearson Prentice Hall.

Thorvaldur Gylfason (2000). Natural resources, education and economic development University of Iceland, SNS, Stockholm, and CEPR Discussion Paper No. 2594 October 2000

Barro, Robert J. (1997), *The Determinants of Economic Growth*, MIT Press, Cambridge, Massachusetts.

JG Brida, LF Punzo, M Puchet Anyul. A Review on the Notion of Economic Regime. *International Journal of Economic Research*, Vol. 5, No. 1, pp. 55-76, 2008

Zidan. The Role of HRD in Economic Development.

https://en.wikipedia.org/wiki/Knowledge_economy

ОУХБ-ын товч баримт бичиг. КОВИД-19 цар тахлаас үүдсэн хямрал ба албан бус эдийн засаг: Шуурхай арга хэмжээ ба бодлогын сорилтууд. 2020 оны 5 дугаар сарын 7.

Hoyle, R. (1995). *Structural equation modeling : concepts, issues and applications*. Thousand Oaks, CA: Sage Publications.

HSFS-15

МОНГОЛ ОЮУТНЫ ЧӨЛӨӨТ ЦАГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА

П.Баасанжаргал¹, Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль, Email: suisbaaska@gmail.com

Б.Нацагдорж², Мандах Их Сургууль, Email: natsagdorj9599@gmail.com

Хураангуй: Аж үйлдвэрийн IV хувьсгал, дижитал шилжилтийн нөлөөгөөр дэлхийн иргэдийн амьдралын хэмнэл түргэсч, бид хоногийн 24 цагийг урьд урьдаас илүү завгүй өнгөрөөж, цаг хугацаатай уралдан амьдарч байна. Энэхүү завгүй амьдралын хэмнэл хувь хүний амьдрал төдийгүй улс үндэстэн, бүс нутгийн нийгэм, эдийн засагт эерэг болон сөрөг нөлөөллийг бий болгох болжээ. Амьдралын тэнцвэрээ хадгалах, амьдралын сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэхэд чөлөөт цагийн үйл ажиллагаа эерэгээр нөлөөлдөг болохыг сэтгэл зүйчид, чөлөөт цагийн судлаачид баталсан. Оюутны чөлөөт цагийн үйл ажиллагаа нь тухайн оюутны суралцах үйл ажиллагааны үр дүн, идэвхи болон оюутны сэтгэл ханамжид нөлөөлөөд зогсохгүй дээд боловсролын байгууллагын менежментийн чухал асуудлын нэг юм.

Бид энэхүү судалгааны ажлаар Монгол улсын их дээд сургуулиудад суралцаж буй оюутны чөлөөт цагаа өнгөрүүлж буй хэлбэр, оюутны чөлөөт цагийн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорисон. Оюутны чөлөөт цагийн үйл ажиллагааг идэвхитэй, идэвхигүй, нийгмийн, соёл-уралгийн, хичээлтэй хамаарал бүхий, сөрөг нөлөөлөл бүхий чөлөөт цагийн үйл ажиллагаа гэсэн 6 бүлэг зүйлсээр тодорхойлсон. Судалгаанд нийт 4 хэсгээс бүрдсэн 23 асуулт, 12 бүлэг 108 хүчин зүйл бүхий анкет асуулгыг ашиглан, Монгол улсын их дээд сургуулиудад суралцаж буй нийт 1080 (28 их дээд сургууль, 4 коллежийн Багш, боловсрол судлал, Сурган хүмүүжүүлэх ухаан, Хүмүүнлэгийн ухаан, Урлагийн төрөл, урлаг судлал, Хууль, эрх зүй, Нийгмийн шинжлэл, Худалдаа, бизнесийн удирдлага, Нийтийн мэдээлэл, бичиг хэрэг, Математик, компьютер, Үйлчилгээ, Байгалийн шинжлэл, Анагаах ухаан, Инженер, Архитектур, хот төлөвлөлт, Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, бусад мэргэжилээр сурч буй) оюутнаас судалгаа авч, судалгааны өгөгдлийг SPSS24 программыг ашиглан боловсруулсан.

Түлхүүр үг: оюутан, оюутны чөлөөт цаг, оюутны чөлөөт цагийн үйл ажиллагаа, чөлөөт цагийн ойлголт, чөлөөт цагийн өгөөж

I. УДИРТГАЛ

Хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад чөлөөт цагийн талаарх ойлголт-хандлага, чөлөөт цагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилго, үүрэг нь тухайн цагийн үеийн нөхцөл байдал, соёл, улс төр, нийгэм, эдийн засгийн бодлоготой нягт уялдаатайгаар харилцан адилгүйгээр хөгжиж ирсэн. Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэн үеэс эхлэн хүмүүсийн амьдралын хэв маяг, чөлөөт цагийн хандлагад томоохон өөрчлөлт гарч, чөлөөт цагийн үйл ажиллагаа зах зээлийн чиг хандлагаар хөгжиж эхэлсэн байна. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаа аж үйлдвэрийн 4-р хувьсгал, дижитал шилжилтийн нөлөөлөл мөн “Ковид-19” цар тахлын нөлөөгөөр хүмүүсийн амьдралын хэв маяг болон чөлөөт цагийн үйл ажиллагаанд томоохон өөрчлөлтүүд гарч байна.

Манай улсын нийт хүн амын 43.3%-ыг 15-44 насны залуучууд эзэлдэг ба 2020-2021 оны хичээлийн жил нийт 88 их, дээд сургууль, коллежид 147293 оюутан суралцаж байна[1]. Тэгвэл оюутан үр дүнтэй суралцах, ирээдүйн чадварлаг мэргэжилтэн болж төлөвшихөд чөлөөт цагийн үйл ажиллагаа маш их ач холбогдолтой болохыг чөлөөт цаг, анагаах ухаан, сэтгэл, соёл судлалын эрдэмтэн судлаачдийн хийсэн судалгааны үр дүнгээс харж болно. Олон улсын нэр хүндтэй их дээд сургууль, коллежууд стратегийн төлөвлөгөөндөө оюутны болон багш ажиллагчдын чөлөөт цагийн үйл ажиллагааг тусгайлан оруулж, тогтмол үйл ажиллагаа явуулдаг ба оюутны чөлөөт цагийн судалгааг улирал, жилээр хийж, чөлөөт цагийн үйл ажиллагаагаа байнга сайжруулж ажилладаг байна. Одоогоор манай улсад их дээд сургуулиудын чөлөөт цагийн бодлого-үйл ажиллагаа болон оюутны чөлөөт цагийн талаар хийсэн тоймтой судалгаа ховор, бараг

байхгүй гэж хэлж болохоор байна. Их дээд сургууль бүр оюутны чөлөөт цагийн бодлого, үйл ажиллагааны хөтөлбөртэй байж түүнийгээ үр дүнтэй хэрэгжүүлснээр оюутны сэтгэл ханамж, сурлагын түвшин, оюутны төлөвшилд эерэгээр нөлөөлдөг бөгөөд чөлөөт цагийн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлснээр тухайн сургуулийг сонгох суралцах оюутны тоог(элсэгч) нэмэгдүүлэх, сургуулиас гаргах шилжих хөдөлгөөнийг бууруулах боломжтой юм. Иймээс бид энэхүү судалгааны ажлын хүрээнд Монголын их дээд сургуулиудын оюутны чөлөөт цагийн өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорисон болно.

2. ОНОЛЫН СУДЛАГДСАН БАЙДАЛ

2.1 Монгол улсын дээд боловсролын салбарын тойм

Манай улсад үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2020-2021 оны хичээлийн жилд 88 байгаагийн 37 (42.1%) нь их сургууль, 45 (51.1%) нь дээд сургууль, 3 (3.4%) нь коллеж, 3 (3.4%) нь гадаадын их сургуулийн салбар байна. Үүний 65 (73.9 %) нь төрийн бус өмчийн, 20 (22.7 %) нь төрийн өмчийн, 3 (3.4%) нь олон нийтийн/шашны өмчийн сургууль байна. Нийт сургуулийн 79 (89.8%) нь Улаанбаатар хотод, 9 (10.2%) хөдөө, орон нутагт байна. Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг хүйсээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 89.5 (60.7 %) мянга нь эмэгтэй, 57.8 (39.3 %) мянга нь эрэгтэй байна. Эрэгтэй, эмэгтэй оюутнуудын хүйсийн харьцаа 2020-2021 оны хичээлийн жилд 100 эмэгтэй тутамд 65 эрэгтэй ногдож байна. Нийт суралцагчдын 130.1 (88.4 %) мянга нь их сургуульд, 16.8 (11.4 %) мянга нь дээд сургуульд, 0.1 (0.1 %) мянга нь коллежид суралцаж байгаа бол 0.2 (0.2 %) мянга нь гадаадын их сургуулийн салбар сургуульд суралцагчид байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 76.8 (52.2%) мянга нь төрийн өмчийн, 63.5 (43.1%) мянга нь хувийн өмчийн, 6.9 (4.7%) мянга нь олон нийтийн/шашны өмчийн сургуульд суралцаж байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 138.2 мянга (93.9%) нь Улаанбаатар хотод, 9.1 мянга (6.1%) нь хөдөө, орон нутагт суралцаж байна. Нийт суралцагчдын 134.6 (91.4%) мянга нь өдрөөр, 3.0 (2.0%) мянга нь орой, 9.7 (6.6 %) мянга нь эчнээ ангид суралцаж байна. Их, дээд сургууль, коллежид суралцагчдыг өмчийн хэлбэрээр авч үзвэл, 2019-2020 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 55.8 хувь нь төрийн өмчийн сургуульд суралцаж байсан бол 2020-2021 оны хичээлийн жилд 52.2 хувь болж, 3.6 пунктээр буурсан байна. Их, дээд сургууль, коллежийн суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2020-2021 оны хичээлийн жилд нийт суралцагчдын 119.2 мянга (80.9 %) нь бакалавр, 24.8 мянга (16.9 %) нь магистр, 3.2 мянга (2.2 %) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна[1], [2].

2.2 Чөлөөт цаг, чөлөөт цагийн үзэл баримтлал:

Чөлөөт цаг хэмээх нэр томъёо нь “leisure” буюу чөлөөтэй, завтай байх гэсэн Латин үгнээс гаралтай гэж үздэг[2]. Эрт цагт чөлөөт цагийг биеийн хөдөлмөр хийхээс бусад үйл ажиллагаа гэж үзэж байсан бол орчин цагт амьдралын тэнцвэрийг хадгалах арга зам хэмээн үзэж байна. Чөлөөт цагийг тодорхойлсон маш олон тодорхойлолт, онолын үзэл баримтлалууд байгаа хэдий ч олон улсад нийтээр хүлээн зөвшөөрсөн нэгдсэн тодорхойлолт одоогоор байхгүй байна[2]. Хүн төрөлхтний түүхийн хөгжлийн үе шат бүрд чөлөөт цагийн талаарх ойлголт, хандлага, түүний үнэ цэн, үүргийг ялгаатай байдлаар тодорхойлж иржээ[3]. Тухайлбал Франц улсын чөлөөт цагийн судлаач Joffre Dumazedier “Чөлөөт цаг гэдэг нь албан ажил, гэр бүл болон нийгмээс үл хамааран өөрийн хүсэл, сонирхлын дагуу амрах-алжаалаа тайлах, зугаалах, мэдлэг болон нийгмийн оролцоогоо сайжруулах, бүтээлч чадвараа хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа юм, АНУ-ын судлаач [Harold Diedrich Meyer and Charles K. Brightbill](#) нар чөлөөт цаг нь ажлын бус цагт хамаарах хувь хүн болон нийгмийн статусыг илэрхийлэх чухал арга хэрэгсэл, Цалин хөлсөөр ажиллаж буй албан ажлаас бусад ажлууд болох гэр бүлийн гишүүдэд цаг гаргах, гэрийн ажил болон хувь хүн өөртөө зориулж буй цагийг чөлөөт цаг гэнэ гэх мэт олон тодорхойлолтууд байна.

Бид онолын судалгаанд тулгуурлан чөлөөт цагийн мөн чанар, үзэл баримтлалыг дараах байдлаар тодорхойлж болно гэж дүгнэж байна[4], [5], [6], [7], [8], [9], [10]. Үүнд:

[Хүснэгт 1] Чөлөөт цагийн үзэл баримтлал, ойлголт

	Чөлөөт цаг	Судлаач	Чөлөөт цагийн мөн чанар, үзэл баримтлал
1	Цаг хугацаа	Robinson,1977	Гэр бүл болон өөртөө гаргаж буй цаг хугацаа
		Soule, 1957	Цалин хөлсгүйгээр ажиллаж буй цаг хугацаа
		Butler, 1965	Амралтаа өнгөрөөх хэлбэр, ажлын бус цаг
		Parker, 1971	Албан ажлаа амжуулсны дараа гарах хугацаа
		Brightbill, 1964	Хувь хүний сонголт, үнэлэмжээр өөртөө гаргах цаг хугацаа
2	Үйл ажиллагаа	Nash, 1960	Идэвхигүй, сэтгэл хөдлөлийн, идэвхитэй, бүтээлч оролцоо гэсэн 4 шатлал бүхий үйл ажиллагаа
		Max Kaplan, 1975	Хувь хүний сонголтоос шалтгаалсан харьцангуй бие даасан үйл ажиллагаа
		De Grazia,1962	Онцгой үйл явдал, зугаа цэнгэл, тусгай үйл ажиллагаа
		Dumazedier, 1967,1974	Амрах-алжаалаа тайлах, мэдлэг олох, нийгмийн оролцоогоо сайжруулахад чиглэсэн үйл ажиллагаа
		Torkildsen,2005	Албан ажлын, гэр бүлийн, нийгмийн, хувь хүний гэсэн 4 ялгаатай үйл ажиллагаа
		Kelly,1996	Туршлага, хувь хүний хөгжил, нийгэмд чиглэсэн чөлөөт цагийн үйл ажиллагаа
3	Сэтгэл санааны байдал	Neumeyer, 1958	Идэвхитэй болон идэхигүй үйл ажиллагаа
		Max Kaplan, 1975	Өөрийгөө хөгжүүлэх, амрах, сэтгэл зүйн таатай байдал, эрч хүч,урам зоригийг төрүүлдэг
		Kelly,1996	Хүний ухамсартай холбогдсон сэтгэл санааны байдал
4	Амралт, зугаа цэнгэл	Murphy, 1981	Сэтгэл санаагаа бусдад илэрхийлэх боломж
		De Grazia,1963	Цагийг зугаатай өнгөрүүлэх үйл ажиллагааны цогц
		Аристотель, МЭӨ	Зугаа цэнгэл, амралт, бясалгах-эрэгцүүлэх
5	Соёл, соёлын агуулга	Richard Kraus, 1990	Идэвхитэй болон идэвхигүй хэлбэрээр амрах, алжаалаа тайлах
		Johan Huizinga, 1964	Чөлөөт цагийн үйл ажиллагааны сонголт соёлын ялгаатай байдалаас хамаарна
6	Цогц үзэл баримтлал	Josef Pieper, 1948	Чөлөөт цаг нь соёлын оршин тогтнохуйн үндэс
		Gunter, Nancy, 1980	Дээрх 5 агуулгаас гадна, аль алиныг нь хослуулсан цогц агуулгыг илэрхийлж болно
		Dumazedier, 1967	Өөрийгөө хөгжүүлэх, зугаацах, амрах олон төрлийн хэлбэр
7	Амьдрах арга,оршихуй	Torkildsen, 2005	1)цаг хугацаа, 2)үйл ажиллагаа, 3)сэтгэл санааны байдал, 4)цогц-нийлмэл ойлголт, 5)амьдрах арга-оршихуй
		Goodale& Godbey, 1988	Эрх чөлөөтэй, үр бүтээлтэй-үнэ цэнэтэй амьдрах

Эх сурвалж: Судлаачийн боловсруулснаар

Чөлөөт цагийн үүсэл-хөгжлийн үечлэлийн талаар хийсэн олон судалгааны ажлуудыг харьцуулж, чөлөөт цагийн хөгжлийн үе шатыг Susana Juniu-ийн гаргасан үечилэлээр авч үзсэн. Чөлөөт цагийн үзэл баримтлалын түүхэн хөгжил *i)*Эртний Грекийн үе, *ii)*Ромын үе, *iii)*Дундад зууны үе, *iv)*Сэргэн мандалтын үе, *v)*Аж үйлдвэрийн хувьсгалын үе, *vi)*Аж үйлдвэрийн хувьсгалын дараах үе, *vii)*Дижитал хувьсгалын үе гэсэн долоон үечлэлийг дамжин, өнөөг хүртэл хөгжиж ирсэн байна[3], [15]. Дижитал хувьсгалын нөлөөгөөр ажлын орчин, өдөр тутмын амьдрал, чөлөөт цагийн шинэ хэв маяг(*кибер орон зай, виртуал орчин, мэдээллийн болон зугаа цэнгэлийн шинэ хэв маяг*) бий болж, чөлөөт цагийн нийгмийн болон эдийн засагт оруулах хувь нэмэр өргөжиж байна.

Манай улсад чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүд үүсч хөгжсөн түүх нь нийгэм-улс төрийн бодлоготой шууд холбогдоно. Тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөөх тэмцлийн үр дүнд Монголчууд Манж Чин улсын дарлалаас салж, 1911 онд тусгаар тогтнолоо тунхагласан цагаас эхлэн чөлөөт цагийн үйл ажиллагаа хүн амыг соён гэгээрүүлэх үйл ажиллагаанаас гадна нам засгийн суртал ухуулга хийх, улс төрийн шинж чанар бүхий үйл ажиллагаа давамгайлж байсан байна. Харин 1989 онд өрнөсөн Ардчилсан хувьсгалын үр дүнд ардчилсан [Монгол Улсыг](#) байгуулж зах зээлийн тогтолцоонд шилжсэн үеэс чөлөөт цагийн үйл ажиллагаа зах зээлийн үзэл баримтлалаар хөгжиж эхэлсэн. Манай улсын судлаачдийн чөлөөт цагийн талаарх хийсэн судалгааны бүтээлүүдээс харахад соёл гэгээрлийн ажил, соёл-олон түмний ажил, соёлын ажил, соёлын үйл ажиллагаа, соёл-чөлөөт цагийн үйл ажиллагаа, нийгэм-соёлын үйл ажиллагаа, алжаал тайлах

соёл, алжаал тайлах үйл ажиллагаа, цэнгүүний үйлдвэрлэл, соёлын үйл ажиллагааны технологи, соёл чөлөөт цагийн инноваци зэрэг нэр томъёог өргөн ашиглаж, хэд хэдэн бүтээлүүд хэвлэгдэж олны хүртээл болжээ[11], [12], [13], [14].

2.3 Чөлөөт цагийн өгөөж, ач холбогдол:

Орчин цагт чөлөөт цагийн үүрэг, өгөөжийн талаар чөлөөт цагийн судлаачид төдийгүй сэтгэл судлал, философи, түүх, соёл, анагаах ухаан зэрэг олон салбаруудын судлаачид макро, микро, мезо түвшинд авч үзсэн байна[2]. Чөлөөт цагийн үйл ажиллагаа нь хүний амьдралын чанар, аз жаргалын индекс, сайн сайхан байдлыг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг бөгөөд ерөнхийдөө чөлөөт цагийн ач холбогдол-өгөөжийг чөлөөт цагийн үйл ажиллагааны хэрэгцээ-шаардлага(Мотивацийн онол), цаг хугацааг үр дүнтэй өнгөрүүлэх буй байдал-өгөөж(Benefits-Driven Model, Nash’s Paradigm of free time), чөлөөт цагийн зан төлөвд тулгуурлан тайлбарласан байна. Бид энэхүү судалгааны ажилд чөлөөт цагийн өгөөж ач холбогдлыг эдийн засгийн, нийгмийн, бие махбодийн, сэтгэл зүйн, орчны гэсэн 5 хүчин зүйлсийн дагуу авч судалсан[15], [16], [17].

2.4 Чөлөөт цагийн үйл ажиллагаа(чөлөөт цагийн хэлбэр)

Чөлөөт цагийн үйл ажиллагааны ангилал, төрлийг Канадын чөлөөт цагийн судлаач, профессор Robert A. Stebbins[18] 1)өдөр тутмын чөлөөт цаг, 2)онцгой чөлөөт цаг, 3)төсөлд суурилсан чөлөөт цаг гэсэн гурван үндсэн төрлөөр, Малайзын судлаач Mawarni Binti Mohamed[15] насанд хүрэгчид болон залуу үеийн чөлөөт цагийн төрлийг 1)идэвхитэй, 2)идэвхигүй, 3)нийгмийн, 4)ажилтай хамаарал бүхий, 5)мансууруулах бодисын хэрэглээ, 6)гэмт хэрэгтэй холбоотой чөлөөт цагийн үйл ажиллагаа гэсэн зургаан төрлөөр(нийт 38 хүчин зүйл, Солонгосын судлаач Kyulee Shin, Sukkyung You[19] нар насанд хүрэгчдийн чөлөөт цагийн төрлийг 1)идэвхитэй, 2)идэвхигүй, 3)нийгмийн чөлөөт цаг гэсэн гурван төрлөөр, Туркийн судлаач Kerem Yıldırım Şimşek & Hüseyin Çevik[20] нар чөлөөт цагийн төрлийг 1)амралтын үйл ажиллагаа, 2)хувь хүний хөгжүүлэх үйл ажиллагаа, 3) нийгмийн үйл ажиллагаа, 4) сэтгэл татах орчны үйл ажиллагаа, 5)гоо зүйн мэдрэмжтэй холбоотой үйл ажиллагаа, 6)зугаа цэнгэлийн үйл ажиллагаа гэсэн зургаан төрлөө, Оросын судлаач Корсунова В. И[6] оюутан сурагчдын чөлөөт цагийн төрлийг 1)идэвхитэй, 2)идэвхигүй, 3)нийгмийн, 4)зугаа цэнгэлийн, 5)соёл урлагийн чөлөөт цаг гэсэн 5 төрлөөр, Япон улсын судлаач Akito Takeuchi, Noriko Sakano[21] нар чөлөөт цагийн төрлийг 1)идэвхигүй, 2)өөрийгөө хөгжүүлэх, 3)нийгмийн, 4)спортын, 5)хобби, сохирхолын чөлөөт цагийн үйл ажиллагаа гэсэн 5 төрлөөр тус тус авч судалсан байна. Бид энэхүү судалгааны ажлын хүрээнд 1)идэвхитэй, 2)идэвхигүй, 3)нийгмийн, 4)соёлын(урлагын төрөл), 5)ажилтай хамаарал бүхий үйл ажиллагаа, 6)гэмт хэрэг-сөрөг нөлөөлөл бүхий үйл ажиллагаа гэсэн зургаан бүлэг 6 бүлэг 41 хүчин зүйлсийн дагуу хүн амын чөлөөт цагаа өнгөрүүлэх хэлбэрийг тодорхойлсон. [22], [23], [24],

3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧИЛАЛ

Дээрх онолын судалгаа болон бусад хамаарах нийтлэлүүдийг үндэслэн судалгааны арга зүй, аргачиллаа дараах байдлаар боловсруулсан.

3.1 Судалгааны асуулга боловсруулалт: Энэхүү судалгааны асуулга нь хүн ам зүйн үзүүлэлт, чөлөөт цагийн ойлголт, чөлөөт цагийн үйл ажиллагаа, чөлөөт цагийн хандлага гэсэн 4 үндсэн хэсэг бүхий 23 асуултаас бүрдсэн болно.

[Хүснэгт 2] Судалгааны асуулгын бүтэц

Хэсэг А	Судалгаанд оролцогч оюутнуудын талаарх ерөнхий мэдээлэл	Суралцаж буй мэргэжлийн ерөнхий чиглэл, суралцаж буй нарийн мэргэжил, суралцаж буй курс, суралцаж буй сургууль, хүйс.
Хэсэг Б	Чөлөөт цагийн ойлголт	Чөлөөт цагийн зорилго, чөлөөт цагийн өгөөж-ач холбогдол, чөлөөт цагийн орчинд өгөх үнэлгээ
Хэсэг В	Чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал, чөлөөт цагийн үйл ажиллагааны сонголт	Цаг ашиглалт, чөлөөт цагийн үйл ажиллагааны төрөл, сонголт. (идэвхитэй, идэвхигүй, соёл-урлагийн, нийгмийн, хичээл-сургуультай холботой, гэмт хэрэг-сөрөг нөлөөлөл бүхий үйл ажиллагаа)

Хэсэг Г	Чөлөөт цагийн үйл ажиллааны сэтгэл ханамжийн түвшин, цаашид хүсч буй чөлөөт цагийн үйл үйлчилгээ	Чөлөөт цагийн сэтгэл ханамжийн үнэлгээ, цаашид хүсч буй чөлөөт цагийн үйлчилгээний талаарх санал, хүсэлт
---------	--------------------------------------------------------------------------------------------------	----------------------------------------------------------------------------------------------------------

3.2 Судалгааны өгөгдөл цуглуулалт: Энэхүү судалгаагаар Монгол улсын их дээд сургуульд суралцаж буй оюутнуудын чөлөөт цагийн өнөөгийн байдлыг тодорхойлохыг зорисон учир судалгаанд дээд боловсролын статистикт тусгасан мэргэжлийн ерөнхий чиглэлүүдийн дагуу сонгож, нийт 1-6-р курсын 1080 оюутнаас судалгаа авч, судалгааны үр дүнг дор харуулав. Судалгааны өгөгдлийг 2021 оны 4-р сарын 15-аас 2021 оны 5-р сарын 10-ыг хүртлэх хугацаанд цуглуулсан. Бид асуулгын судалгаанд оролцох оюутнуудын түүврийг тооцоходоо дээд боловсролын статистик мэдээнд тулгуурлан багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухаан, хүмүүнлэгийн ухаан, урлагийн төрөл, урлаг судлал, хууль, эрх зүй, нийгмийн шинжлэл, худалдаа, бизнесийн удирдлага, нийтийн мэдээлэл, бичиг хэрэг, математик, компьютер, үйлчилгээ, байгалийн шинжлэл, анагаах ухаан, инженер, архитектур, хот төлөвлөлт, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур, бусад мэргэжил гээн чиглэлүүдээр тооцож түүвэр судалгаа хийсэн.

3.3 Судалгааны өгөгдөл боловсруулалт, шинжилгээ:

Судалгааны өгөгдлийг SPSS24 программыг ашиглан боловсруулж, тодорхойлох статистик, фактор шинжилгээ(чөлөөт цагийн хандлагад нөлөөлж буй хүчин зүйлс) болон корреляцийн шинжилгээ хийсэн.

4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол оюутны чөлөөт цагийн өнөөгийн байдлыг тодорхойлох судалгааг судалгааны найдвартай байдлын шинжилгээ, судалгаанд оролцогч оюутнуудын талаарх ерөнхий талаарх мэдээлэл, оюутны чөлөөт цагийн талаарх ерөнхий ойлголт-хандлага, чөлөөт үйл ажиллагаа буюу чөлөөт цагаа өнгөрүүлэх хэлбэрүүд болон оюутны чөлөөт цагийн сэтгэл ханамж, цаашид хүсч буй чөлөөт цагийн үйлчилгээ гэсэн хэсгүүдийн дагуу хийж, судалгааны үр дүнг дор харуулав.

4.1 Судалгааны ажлын найдвартай байдлын шинжилгээ:

Бид боловсруулсан судалгааны асуулгынхаа найдвартай байдлыг шалгах зорилгоор туршилт судалгаа явуулахад(2021 оны 3-р сар) ач холбогдол нь өндөр гарсан тул уг асуулгын дагуу судалгааны өгөгдлийг цуглуулсан. Энэхүү судалгааны өгөгдөлдөө найдвартай байдлын шинжилгээ хийхэд Кронбах альфа(Cronbach's Alpha) коэффициент 0.964, судалгааны түүвэр нь эх олонлогоо төлөөлөх чадварыг шалгах KMO and Bartlett's тест хийхэд KMO коэффициент 0.952 буюу ач холбогдолтой гарсан нь энэхүү судалгааны асуулга ойлгомжтой, түүврийн хэмжээ хүрэлцээтэй, түүвэр нь эх олонлогоо төлөөлж чадаж байгааг харуулж байна.

[Хүснэгт 3] Найдвартай байдлын шинжилгээ

Reliability Statistics			KMO and Bartlett's Test		
Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items	Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.	.952	
.906	.964	108	Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	20792.175
				df	630
				Sig.	.000

4.2 Судалгаанд оролцогчидын талаарх мэдээлэл:

Судалгаанд оролцогчдын талаарх мэдээллийг нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдал, өрхийн ам бүлийн тоо болон нэг сарын дундаж орлого, оршин сууж буй газрын харъяалал гэсэн найман үзүүлэлтүүдээр авч судалсан.


[Хүснэгт 4] Судалгаанд оролцсон оюутнуудын талаарх үндсэн мэдээлэл

Хувьсагч	Давтамж	Хувь	Хувьсагч	Давтамж	Хувь
1. Хүйс			5.Суралцах хугацаандаа амьдарч буй газар		
эрэгтэй	342	31.7	Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	47	4.4
эмэгтэй	738	68.3	Хүмүүнлэгийн ухаан	13	1.2
2. Үндсэн харьяалал			Урлагийн төрөл, урлаг судлал	125	11.7
Улаанбаатар хот	650	60.2	Хууль, эрх зүй	21	2.0
Эрдэнэт, Дархан хот	42	3.9	Нийгмийн шинжлэл	12	1.1
Аймгийн төв	177	16.4	Худалдаа, бизнесийн удирдлага	332	31.0
Сумын төв, баг	201	18.6	Нийтийн мэдээлэл, бичиг хэрэг	27	2.5
3. Суралцаж буй курс			Математик, компьютер	98	9.2
1-р курс	339	34.6	Үйлчилгээ	85	7.9
2-р курс	288	27.0	Байгалийн шинжлэл	8	.7
3-р курс	219	20.5	Анагаах ухаан	49	4.6
4-р курс	177	16.6	Инженер	91	8.5
5-р курс	11	1.0	Архитектур, хот төлөвлөлт	38	3.5
6-р курс	3	0.3	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	6	.6
4.Ажил эрхэлдэг эсэх			Бусад	119	11.1
Тийм	375	34.9	6. Суралцах хугацаандаа амьдарч буй газар		
Үгүй	699	64.7	Өөрийн гэртээ	688	64.3
			Төрөл садан, танил, найзындаа	168	15.7
			Түрээсийн орон сууцанд	103	9.6
			Түрээсийн нийтийн байранд	37	3.5
			Оюутны дотуур байранд	64	6.0
			Бусад	10	0.9

Судалгаанд оролцогчдын талаарх дээрх мэдээллийг дээд боловсролын статистик мэдээлэл болон түүврийн тооцоололтой харьцуулан дүгнэхэд эдгээр респондентууд түүврийн зохистой хэмжээг хангаж байна

4.3 Чөлөөт цагийн ойлголт, чөлөөт цагийн ерөнхий хандлага:


Судалгаанд оролцогч оюутнуудын дийлэнх нь чөлөөт цагийг амралт(76.3%), зугаа цэнгэл(54.0%), цаг хугацаа(54.0%), сэтгэл санааны байдал(33.6%) хэмээн ойлгодог гэж хариулсан.



Зураг 1.Чөлөөт цагийн талаарх ойлголт, чөлөөт цагийн зорилго

Харин чөлөөт цагийн зорилгын хувьд ихэвчлэн хобби-сонирхол(79.5%), амрах-алжаалаа тайлах(64.4%), стресс бухимдалаа тайлах(58.8%), суралцах, өөрийгөө хөгжүүлэх(57.4%), эрүүл мэндээ хамгаалах-сайжруулах(48.8%), харилцаагаа сайжруулах(43.8%) зорилгоор чөлөөт цагийн үйл ажиллагааг сонгодог гэж хариулсан байна.

Эндээс чөлөөт цагийн үйл ажиллагааны үндсэн зорилго болох амрах, алжаалаа тайлах(бие болон сэтгэлийн) зорилго давуу байхын зэрэгцээ судалгаанд оролцогчдын мэргэжил, курсээс хамааран суралцах-өөрийгөө хөгжүүлэх зорилго мөн олон талын харилцаагаа сайжруулах зорилгоор чөлөөт цагаа өнгөрүүлэх хандлага давамгайлж байгаа нь харагдаж байна.



Зураг 2.Чөлөөт цагийн өгөөж ба чөлөөт цагаа өнгөрүүлэх хэлбэр, хувиар

Зураг 2-оос харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь чөлөөт цагийн үйл ажиллагааг сонгохдоо бие махбодийн(28.7%) болон сэтгэл зүйн(36.4%) өгөөж-ач холбогдлыг чухалчилж үзсэн байна(Зураг 2).

Оюутнууд ерөнхийдөө чөлөөт цагийн үйл ажиллагааны хувь хүний амьдралд болон суралцах үйл ажиллагаанд гүйцэтгэх үүрэг, байр суурийг маш чухал хэмээн үзэж байна.

[Хүснэгт 5] Чөлөөт цагийн үүрэг ач холбогдлыг үнэлэх байдал

Чөлөөт цагийн ач холбогдлыг үнэлэх байдал	Чөлөөт цагийн гүйцэтгэх үүрэг, ач холбогдлыг үнэлэх байдал	
	Хувь хүний амьдралд	Сургууль, Суралцах үйл ажиллагаанд
Ямар ч хэрэггүй зүйл	0.19	0.75
Чухал биш	1.21	2.25
Зарим талаар ач холбогдолтой	17.89	23.03
Чухал	35.69	41.67
Маш чухал	45.01	32.30

Монгол улсын цаг ашиглалтын судалгааны тайланд нийт хүн амын цаг ашиглалтын байдлыг авч үздэг тул оюутнуудын цаг ашиглалтыг авч үзэх шаардлагатй гэж оюутнуудын цаг ашиглалтын байдал буюу хоногийн 24 цагийг хэрхэн өнгөрүүлж буйг тодруулахад судалгаанд оролцсон оюутнууд дараах байдлаар хариулсан байна.

[Хүснэгт 6] Оюутнуудын цаг ашиглалтын байдал

Хоногийн 24 цагийг өнгөрүүлэх байдал	1-30 минут	31-59 минут	1-2 цаг	3-4 цаг	5-6 цаг	7-8 цаг	9-12 цаг	13 ба түүнээс дээш цаг
Хичээлдээ суух	2.6	8.0	28.4	31.5	16.6	6.3	4.3	2.3
Унтаж амрах	0.0	1.5	4.5	11.8	11.5	53.2	16.8	.8
Хичээлтэй холбоотой даалгавар, бие даалт хийх	2.6	8.0	28.4	31.5	16.6	6.3	4.3	2.3
Хичээлээс гадна өөрийгөө хөгжүүлэх үйл ажиллагаа (гадаад хэл сурах, мэргэжил)	14.8	18.0	41.3	15.4	6.0	2.7	1.0	.9
Гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах	9.2	16.6	35.0	22.2	7.7	3.6	2.6	3.0
Олон нийтийн арга хэмжээ болон соёлын зан үйлд оролцох	41.1	23.6	24.5	7.2	2.6	1.0	0.0	0
Чөлөөт цаг (урлаг, спорт гэх мэт чөлөөт цагийн бүх хэлбэрүүд)	21.8	20.9	31.3	15.9	5.4	2.7	1.2	.9
Ажил хийх	9.8	.1	14.6	25.9	30.4	9.0	6.6	3.7

Хүснэгт 5-аас харахад Монгол оюутнууд хичээлийн улирлуудын нэг ерөнхийдөө нийт судалгаанд оролцсон оюутнуудын дийлэнх нь өдөрт дундажаар 7-8 цагийг унтаж амрах, 3-4 цагийг танхимын болон онлайн хичээлд сууж, 1-4 цагийг хичээлтэй холбоотой бие даалтын ажил даалгавараа хийж, 1-2 цагийг хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх ажилд зориулж, 1-2 цагийг гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслах, 1-30 минутыг олон нийтийн арга хэмжээнд, чөлөөт цагийн үйл ажиллагаанд 1-2 цагийг, ажил хийдэг оюутнуудын хувьд 5-8 цагийг цалин хөлстэй ажил эрхлэхэд зориулж байна. Эндээс унтаж амрахаас бусад цаг ашиглалтын байдлыг харьцуулан авч үзвэл цалин хөлстэй ажил эрхэлдэггүй оюутнуудын хувьд хичээлдээ суух, бие даалт, хичээлээ хийх, гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүйгээр туслахад хамгийн их цагийг зарцуулж байна гэж дүгнэж болох юм.

Оюутнуудын хоногийн 24 цагийн хугацаанд чөлөөт цагт зарцуулж буй хугацааг байдлыг сурч буй мэргэжлийн ерөнхий чиглэлүүдээр нь харьцуулан авч үзэхэд:

[Хүснэгт 7] Чөлөөт цагт зарцуулах хугацаа ба сурч буй мэргэжлийн чиглэл

Мэргэлийн ерөхий чиглэл	Чөлөөт цаг (урлаг, спорт гэх мэт чөлөөт цагийн бүх хэлбэрүүд)							
	1-30 минут	31-59 минут	1-2 цаг	3-4 цаг	5-6 цаг	7-8 цаг	9-12 цаг	13 ба түүнээс дээш цаг
Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	20.0%	22.2%	31.1%	15.6%	4.4%	0.0%	2.2%	4.4%
Хүмүүнлэгийн ухаан	27.3%	36.4%	18.2%	9.1%	0.0%	0.0%	9.1%	0.0%
Урлагийн төрөл, урлаг судлал	16.1%	22.0%	31.4%	18.6%	4.2%	4.2%	1.7%	1.7%
Хууль, эрх зүй	19.0%	14.3%	33.3%	19.0%	14.3%	0.0%	0.0%	0.0%
Нийгмийн шинжлэл	9.1%	9.1%	27.3%	36.4%	9.1%	0.0%	9.1%	0.0%

Худалдаа, бизнесийн удирдлага	25.2%	23.3%	31.1%	12.4%	5.0%	2.2%	.3%	.6%
Нийтийн мэдээлэл, бичиг хэрэг	17.4%	17.4%	43.5%	13.0%	4.3%	4.3%	0.0%	0.0%
Математик, компьютер	25.3%	16.5%	30.8%	16.5%	3.3%	6.6%	0.0%	1.1%
Үйлчилгээ	12.0%	21.7%	33.7%	19.3%	7.2%	0.0%	4.8%	1.2%
Байгалийн шинжлэл	14.3%	14.3%	14.3%	57.1%	0.0%	0.0%	0.0%	0.0%
Анагаах ухаан	27.3%	15.9%	36.4%	9.1%	11.4%	0.0%	0.0%	0.0%
Инженер	18.7%	19.8%	30.8%	19.8%	4.4%	5.5%	1.1%	0.0%
Архитектур, хот төлөвлөлт	38.2%	17.6%	32.4%	8.8%	0.0%	2.9%	0.0%	0.0%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	0.0%	50.0%	0.0%	33.3%	16.7%	0.0%	0.0%	0.0%
Бусад мэргэжил	23.4%	18.9%	29.7%	17.1%	6.3%	2.7%	.9%	.9%

Хүснэгт 6-аас харахад архитектур, хот төлөвлөлт, математик компьютер, худалдаа бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр сурч буй оюутнууд дундажаас бага, хүмүүнлэг, нийгмийн шинжлэл, үйлчилгээний мэргэжлийн чиглэлээр сурч буй оюутнуудын чөлөөт цаг дундажаас өндөр байна.

[Хүснэгт 8] Чөлөөт цагт зарцуулах хугацаа ба сурч буй курс

	Чөлөөт цаг (урлаг, спорт гэх мэт чөлөөт цагийн бүх хэлбэрүүд)							
	1-30 минут	31-59 минут	1-2 цаг	3-4 цаг	5-6 цаг	7-8 цаг	9-12 цаг	13 ба түүнээс дээш цаг
1-р курс	19.0%	20.5%	33.2%	15.9%	5.7%	2.3%	2.3%	1.1%
2-р курс	19.9%	20.7%	32.5%	14.4%	7.4%	3.3%	.7%	1.1%
3-р курс	29.9%	19.4%	28.9%	16.6%	3.3%	.5%	.5%	.9%
4-р курс	21.6%	24.0%	28.7%	16.8%	3.6%	5.4%	0.0%	0.0%
5-р курс	20.0%	20.0%	20.0%	20.0%	10.0%	10.0%	0.0%	0.0%
6-р курс	0.0%	0.0%	33.3%	33.3%	0.0%	0.0%	33.3%	0.0%

Харин сурч буй курсийн хувьд 3-4- р курсын оюутнууд хамгийн чөлөөт цаг багатай байдаг бол 1-р курс болон мэргэжлийн чиглэлээс хамаарч 6-р курсын оюутнууд чөлөөт цаг ихтэй байдаг нь судалгааны үр дүнгээс харагдаж байгаа бөгөөд их дээд, сургууль коллежуудын зүгээс мэргэжил, курсын онцлогт нь тохируулан оюутанд чиглэсэн чөлөөт цагийн үйл ажиллагааг ялгаатай байдлаар төлөвлөж, хэрэгжүүлэх хэрэгтэй нь харагдаж байгаа юм.

4.4 Чөлөөт цагийн үйл ажиллагаа(чөлөөт цагаа өнгөрүүлэх хэлбэр):

Оюутнуудын чөлөөт цагаа өнгөрүүлдэг гол хэлбэр нь идэвхигүй(71.5%) хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаа болон хичээл сургуультай холбоотой чөлөөт цагийн үйл ажиллагаа байна. (Зураг 2).

Судалгаанд оролцогчдын 56.4% нь идэвхитэй хэлбэрээр, 47% нь нийгмийн үйл ажиллагаанд, 42.6% нь соёл урлагийн 26.2% нь мансуурах, гэмт хэргийн шинжтэй-сөрөг чөлөөт цагийн хэлбэрүүдийг сонгон чөлөөт цагаа өнгөрөөдөг гэж хариулсан байна.

Идэвхигүй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаа: Оюутануудын чөлөөт цагаа өнгөрөөх хамгийн түгээмэл хэлбэр болох идэвхигүй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзэхэд:



Зураг 3.Идэвхигүй чөлөөт цагийн үйл ажиллааны хэлбэрүүд

Идэвхигүй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаануудаас интернетээр мэдээлэл хайх, мэдлэг олж авах, сошиал медиа ашиглаж чөлөөт цагаа өнгөрөөх, гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдийг асрах, интернетээр кино, видео үзэх, интернетээр дуу хөгжим сонгох гэсэн хэлбэрүүд зохилж байна. Уламжлалт мэдээллийн суваг болох телевиз, FM радиогийн үйлчилгээ оюутнуудын чөлөөт цагийн сонголтод бараг байхгүй байгаа нь харагдаж байна.

Идэвхтэй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаа: Оюутнуудын хувьд идэвхтэй хэлбэрийн чөлөөт цагийн төрлүүд чөлөөт цагийн сонголтын 3-рт буюу төдийлөн өндөр үзүүлэлт биш хэдий ч нийт Монгол улсын хүн амын чөлөөт цагийн үйл ажиллагааны сонголттой харьцуулахад өндөр байгаа юм. Энэ нь чөлөөт цагийн өгөөж талаас нь авч үзвэл эерэг үзүүлэлт юм. Ерөнхийдөө гадаадын улс орнуудад хийсэн чөлөөт цагийн судалгааны үр дүнтэй харьцуулахад ойролцоо үзүүлэлтэй байна.



Зураг 4.Идэвхитэй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүд

Идэвхитэй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаануудаас өөрийгөө хөгжүүлэх, суралцах, худалдаа үйлчилгээний газраар үйлчлүүлэх, хобби-сонирхлынхоо хөгжүүлэх, дунуй унах-алхах, спортоор хичээллэх гэсэн үйл ажиллагаанууд зонхилж байна.


Соёл урлагийн болон нийгмийн чөлөөт цагийн үйл ажиллагаа: Монгол оюутнуудын хувьд нийгмийн чөлөөт цагийн үйл ажиллагаа 4-рт, соёл урлагийн чөлөөт цагийн үйл ажиллагаа 5-рт эрэмблэгдэж буй чөлөөт цагаа өнгөрөөх хэлбэр болж байна. Тэгвэл соёл урлагийн болон нийгмийн чөлөөт цагийн үйл ажиллагааны төрөл тус бүрээр дэлгэрүүлэн авч үзье:



Зураг 5.Соёл-урлагийн болон нийгмийн чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүд

Зураг 5-аас харахад соёл урлагийн чөлөөт цагийн хэлбэрүүдээс кино театрт кино үзэх, номын сан-номын дэлгүүрээр үйлчлүүлэх, урлагийн тоглолт-үзвэр үйлчилгээ үзэх гэсэн төрлүүд зонхилж байгаа бол нийгмийн чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүдээс найз нөхөдтэйгээ уулзах, болзох, айлд зочилох, нийгмийн арга хэмжээ-сайн үйлсийн аянд оролцох хэлбэрүүд зонхилж байна. Бусад улсуудад хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад манай улсын соёл-ёс заншил, үндэсний уламжлалаас хамааран чөлөөт цагаараа төрөл садан, найд нөхдийндөө зочилох байдлаар чөлөөт цагаа өнгөрөөх хэлбэр өндөр гарсан байна.

Хичээл сургуультай холбоотой үйл ажиллагаа болон гэмт хэрэг-сөрөг нөлөөл бүхий чөлөөт цагийн үйл ажиллагаа: Монгол оюутнуудын хувьд гэмт хэрэг-сөрөг нөлөөл бүхий чөлөөт цагийн төрлүүдийг сонгох байдал бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй бага гарсан.



Зураг 6. Хичээл сургуультай холбоотой болон гэмт хэрэг-сөрөг нөлөөлөл бүхий чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүд

Зураг 6-аас харахад оюутнууд хичээл сургуультай холбоотой чөлөөт цагийн үйл ажиллагааны хэлбэрүүдээс чөлөөт цагаараа хичээл, бие дээлтээ хийж, мэргэжлийн ур чадвар олж авах чиглэлээр суралцах, хичээл сургуультай холбоотой уулзалт хурал, семинарт оролцох байдал зонхилж байна. Харин гэмт хэрэг-сөрөг нөлөөлөл бүхий чөлөөт цагийн үйл ажиллагаанаас маргаан үүсгэх, тамхи, согтууруулах ундаа хэрэглэх хэлбэрүүд арай өндөр байна. Ерөнхийдөө Монгол оюутнууд чөлөөт цагаараа мансуурах бодис-эм бэлдмэл хэрэглэх байдал болон гэмт хэрэгт өртөх байдал бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй бага байгаа нь

сайшаалтай.

[Хүснэгт 9] Гэмт хэрэг-сөрөг нөлөөлөл бүхий чөлөөт цагийг үйл ажиллагаа ба курс

	Суралцаж буй курс /дамжаа					
	1-р курс	2-р курс	3-р курс	4-р курс	5-р курс	6-р курс
Огт үгүй	86.7%	84.3%	83.2%	79.5%	90.0%	72.2%
Хааяа	6.5%	8.8%	10.1%	9.5%	6.7%	16.7%
Заримдаа	2.1%	2.3%	2.4%	4.6%	1.7%	0.0%
Ихэнхдээ	2.6%	2.8%	3.0%	3.6%	1.7%	5.6%
Байнга(өдөр бүр)	2.1%	1.9%	1.2%	2.8%	0.0%	5.6%

Хүснэгт 8-аас харахад 3-4-р курсын оюутнуудын гэмт хэрэг-сөрөг нөлөөлөл бүхий чөлөөт цагийн үйл ажиллагааны төрлийг сонгон чөлөөт цагаа өнгөрүүлэх байдал бусад курсийнхнээс бага зэрэг өндөр байна.

4.5 Их дээд сургууль, коллежуудын оюутанд зориулсан чөлөөт цагийн үйлчилгээ, түүний сэтгэл ханамжийн түвшин, цаашид оюутнуудын хүсч буй чөлөөт цагийн үйлчилгээний талаарх судалгааны үр дүн

Монголын их дээд сургууль, коллежуудын зүгээс оюутанд зориулан дараах төрлийн чөлөөт цагийн үйлчилгээг үзүүлдэг байна. Үүнд:



Зураг 7. Их дээд сургууль, коллежуудын оюутанд зориулсан чөлөөт цагийн үйлчилгээ

Зураг 7-оос харахад Их дээд сургууль, коллежууд оюутны чөлөөт цагт зориулан ихэвчлэн спортын тэмцээн, уралдаан(22.8%), урлагийн үзлэг, урлагийн наадам(18.9%), сайн дурын клубын үйл ажиллагаа(22.8%), мэргэжлийн чиглэлээр уулзалт, семинар, уралдаан(12.8%) зохион байгуулдаг хэмээн судалгаанд оролцсон оюутнууд хариулсан байна. Харин ирээдүйн ажлын байртай тайнилцах үйл ажиллагаа, энтертайнмент арга хэмжээ, соёл урлагийн үзвэр үйлчилгээ, аялал зугаалга зохион байгуулах байдал цөөн хэж хариулжээ.

Монголын их дээд сургууль, коллежид сурч буй оюутнууд сургуулийн зүгээс үзүүлж буй оюутанд зориулсан чөлөөт цагийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн түвшинг Лайкертийн 5 баллын үнэлгээгээр үнэлүүлэхэд ерөнхий үнэлгээний дундаж 3.33 буюу “дунд” түвшинд байна. Судалдаанд оролцсон оюутнуудын 37,1% нь сэтгэл ханамжтай, 35,5% нь сэтгэл ханамж дунд зэрэг, 11,1% нь сэтгэл ханамж тааруу, 9,9% нь маш их сэтгэл ханамжтай, 6,4% нь огт сэтгэл ханамжгүй гэж хариулсан байна.

Оюутанд зориулсан чөлөөт цагийн үйл ажиллагааны сэтгэл ханамжийн түвшинг сурч мэргэжлийн ерөнхий ангиллаар харьцуулан авч үзэхэд ялгаатай байдал ажиглагдаж байна.

[Хүснэгт 10] Оюутны чөлөөт цагийн үйлчилгээний сэтгэл ханамж, мэргэжлийн чиглэлээр

	Огт сэтгэл сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамж тааруу	Дунд зэрэг	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай
Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	4.3%	8.5%	38.3%	36.2%	12.8%
Хүмүүнлэгийн ухаан	7.7%	7.7%	23.1%	46.2%	15.4%
Урлагийн төрөл, урлаг судлал	16.4%	10.7%	39.3%	27.0%	6.6%
Хууль, эрх зүй	0.0%	14.3%	33.3%	47.6%	4.8%
Нийгмийн шинжлэл	8.3%	8.3%	50.0%	25.0%	8.3%
Худалдаа, бизнесийн удирдлага	4.2%	9.6%	35.2%	40.4%	10.5%
Нийтийн мэдээлэл, бичиг хэрэг	0.0%	14.8%	18.5%	55.6%	11.1%
Математик, компьютер	4.2%	10.4%	39.6%	32.3%	13.5%
Үйлчилгээ	4.7%	5.9%	30.6%	48.2%	10.6%
Байгалийн шинжлэл	12.5%	0.0%	75.0%	12.5%	0.0%
Анагаах ухаан	6.1%	12.2%	44.9%	26.5%	10.2%
Инженер	4.4%	17.6%	30.8%	39.6%	7.7%
Архитектур, хот төлөвлөлт	14.3%	11.4%	54.3%	20.0%	0.0%
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	16.7%	0.0%	50.0%	33.3%	0.0%
Бусад мэргэжил	6.8%	17.1%	25.6%	37.6%	12.8%

Хүснэгт 9-өөс харахад байгалийн шинжлэл, урлагийн төрөл, урлаг судлал, архитектур-хот төлөвлөлт, хөдөө аж ахуй, загас ан агнуурын чиглэлээр сурч буй оюутнуудын чөлөөт цагийн сэтгэл ханамж хамгийн доогуур байгаа бол нийтийн мэдээлэл, бичиг хэрэг, үйлчилгээ, хууль эрх зүй, хүмүүнлэгийн ухаан, инженер, худалдаа бизнесийн удирдлага, багш боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухааны чиглэлээр сурч буй оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин харьцангуй өндөр гарсан байна.

Тэгвэл оюутны чөлөөт цагийн сэтгэл ханамжийн түвшинг суралцаж буй мэргэжлийн ерөнхий чиглэлээр дэлгэрүүлэн авч үзэхэд суралгаанд оролцсон оюутнууд дараах байдлаар хариулсан байна.

Хүснэгт 10. Оюутны чөлөөт цагийн үйлчилгээний сэтгэл ханамж, оюутанд чиглэсэн чөлөөт цагийн үйл ажиллагааны чиглэлээр

	Огт сэтгэл сэтгэл ханамжгүй	Сэтгэл ханамж тааруу	Дунд зэрэг	Сэтгэл ханамжтай	Маш их сэтгэл ханамжтай
Спортын гэмцээн, уралдаан	3.0%	9.9%	34.9%	41.0%	11.2%
Урлагийн үзлэг, урлагийн наадам	3.6%	9.9%	33.8%	41.0%	11.6%
Аялал, зугаалга	3.6%	6.5%	31.2%	46.6%	12.2%
Үдэшлэг, баяр ёслолын үйл ажиллагаа	3.0%	8.5%	28.4%	47.8%	12.4%
Соёл урлагийн үзвэр үйлчилгээ	3.8%	8.6%	22.4%	49.0%	16.2%
Мэргэжлийн чиглэлээр уулзалт, семинар, тэмцээн зохион байгуулах	2.1%	6.7%	31.4%	47.5%	12.4%

Байгууллагуудаар зочилох, танилцах	3.7%	8.4%	23.4%	45.8%	18.7%
Шоу, энтертайнмент арга хэмжээ зохион байгуулах	3.5%	11.5%	25.7%	48.7%	10.6%
Сайн дурын клубын үйл ажиллагаа	1.5%	10.3%	34.9%	43.5%	9.7%
Бусад	12.6%	10.2%	31.1%	38.9%	7.2%

Хүснэгт 10-аас харахад оюутнууд сургуулийн зүгээс зохион байгуулдаг члөөт цагийн үйлчилгээнээс байгууллагуудаар зочилох, ирээдүйн ажлын байртайгаа танилцах үйл ажиллагаа, соёл урлагийн үзвэр үйлчилгээ, аялал зугаалга, үзэшлэг-баяр ёслолын үйл ажиллагаан сэтгэл сэтгэл ханамжийн түвшин өндөр байгаа бол сайн дурын клубийн үйл ажиллагаа, энтертайнмент арга хэмжээнд сэтгэл ханамж тааруу байна гэж хариулжээ.

Цаашид оюутнууд ямар төрлийн чөлөөт цагийн үйлчилгээ сургуулиудаас хүсч байгааг тодруулахад дараах байдлаар хариулсан байна.

[Хүснэгт 11] Цаашид оюутны хүсч буй чөлөөт цагийн үйл ажиллагааны төрлүүд

	Цаашид сургуулиас хүсч буй оюутанд чиглэсэн чөлөөт цагийн үйлчилгээ	Хувь
1	Аялал зугаалга, салхинд гарах	12.4
2	Спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулах, дэмжих	11.1
3	Оюутны сайн дурын клубийн үйл ажиллагаа, хобби сонирхлыг дэмжих үйл ажиллагаа	9.1
4	Соёл, урлагийн үйл ажиллагаа зохион байгуулах	8.2
5	Мэргэжлийн ур чадвар олгоход чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, байгууллагуудтай танилцах	7.7
6	Хүсэх зүйл байхгүй, одоогийн чөлөөт цагийн үйл ажиллагаа хангалтай сайн байна	7.2
7	Хувь хүний хөгжлийн чиглэсэн үйл ажиллагаа	6.1
8	Мэргэжлийн дагуу арга хэмжээ уулзалт, хурал семинар зохион байгуулах	5.7
9	Мэдэхгүй	4.7
10	Олон нийтийн арга хэмжээ үйл ажиллагаанд оролцуулах, зохион байгуулах, дэмжих	4.4
11	Танилцах, танилцуулах үйл ажиллагаа(оюутан хооронд болон багш оюутны хооронд)	4.2
12	Орчин бүрдүүлэх, орчинг сайжруулах(хичээл хийх болон чөлөөт цагаа өнгөрөөх, багаар ажиллах орчин)	4.1
13	Сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулах	3.3
14	Гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр хийгдэх ажлууд	2.5
15	Бассейн, бялдаржуулах, бүжгийн заал танхимтай болох	2.0
16	Ямар ч үйл ажиллагаа байж болно	1.9
17	Номын санг өргөжүүлэх, онлайн номын сантай болох	1.7
18	Бусад	1.4
19	Урлагийн үзвэр үйлчилгээ үзүүлэх, үзэх ажлыг зохион байгуулах	0.6
20	Дугуйлан, секц	0.6
21	Чөлөөт цагийн бодлого, төлөвлөгөөтэй байж, тогтмол хэрэгжүүлэх	0.5

22	Чөлөөт цаг гардаггүй тул, сургалтын төлөвлөгөөнд чөлөөт цагийг тусгах	0.3
23	Эвентүүд зохион байгуулах	0.2

Хүснэгт 11-ээс харахад оюутнуудын хамгийн ихээр хүсч буй чөлөөт цагийн үйл ажиллагаа нь аялал зугаалга, спорт болон урлагийн арга хэмжээ, оюутны сайн дурын клубууд, мэргэжлийн ур чадвар олоход чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, ирээдүйн ажлын байр-байгууллагуудтай танилцах үйл ажиллагаа, хувь хүний хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа мөн бусад мэргэжилийн курсын оюутантайгаа танилцах, бусад сургууль, факултет, мэргэжлийн багш нартайгаа танилцах үйл ажиллагааг зохион байгуулахыг хүсч байна гэж хариулсан байна.

Монгол улсын нийт хүн амын чөлөөт цагийн үйл ажиллагаанд хийсэн судалгааны үр дүнтэй (*нийт хүн амын 83,15% нь чөлөөт цагаа идэвхигүй хэлбэрээр өнгөрүүлдэг*) харьцуулан дүгнэхэд ерөнхийдөө оюутнууд аялал-зугаалга, спорт гэх мэт идэвхтэй хэлбэрийн чөлөөт цагийн төрлүүдийг хүсч байгаа нь эерэг үзүүлэлт юм. Онол арга зүйн болон бусад судалгааны ажлуудын үр дүнгээс харахад идэвхтэй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаа нь идэвхигүй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаатай харьцуулахд хувь хүний биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, амьдралын чанар, аз жаргалд эерэг нөлөө үзүүлдэг болох нь харагддаг.

Судалгаанд оролцогчдын цөөнхийн хариулт байсан хэдий ч оюутнууд хичээлээ давтах, мэргэжлийн онцлогоос хамааран багаар ажиллах орчин мөн чөлөөт цагаа ая өнгөрүүлэх орон зай, тохилог өрөө, бассейн бялдаржуулах танхим, бүжгийн заалыг оюутнууддаа зориулан тусгайлан бэлтгэх шаардлагтай нь судалгааны үр дүнгээс харагдсан. Хэдийгээр сургуулиудын санхүүгийн боломж харилцан адилгүй, төсөв хязгаарлагдмал байгаа ч урт хугацааны стретгийн төлөвлөгөөндөө дээрх асуудлуудыг тусгаж, оюутны хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээтэй уялдуулан чөлөөт цагийн бодлого-төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Оюутнуудын хүсч буй чөлөөт цагийн үйл ажиллагааны төрөл нь суралцаж буй курс/дамжаанаас хамааран ялгаатай байгаа эсэхийг тодруулахад суралцаанд оролцсон оюутнууд дараах байдлаар хариулсан байна.

[Хүснэгт 12] Цаашид оюутны хүсч буй чөлөөт цагийн үйл ажиллагааны төрлүүд ба суралцаж буй курс/дамжаа

Хүсч буй чөлөөт цагийн үйл ажиллагааны төрлүүд	Суралцаж буй курс/дамжаа					
	I	II	III	IV	V	VI
аялал зугаалга, салхинд гарах	38.0	30.4	22.8	7.6	1.3	0.0
эвентүүд зохион байгуулах	20.0	80.0	0.0	0.0	0.0	0.0
оюутны сайн дурын клубийн үйл ажиллагаа, хоббисонирхлыг дэмжих үйл ажиллагаа	29.8	31.6	22.8	15.8	0.0	0.0
мэргэжлийн дагуу арга хэмжээ уулзалт, хурал семинар зохион байгуулах	36.1	19.4	25.0	13.9	5.6	0.0
гадаад хэлний мэдлэгээ дээшлүүлэх чиглэлээр хийгдэх ажлууд	43.8	43.8	0.0	12.5	0.0	0.0
соёл, урлагийн үйл ажиллагаа зохион байгуулах	42.3	23.1	26.9	7.7	0.0	0.0
сэтгэл зүйн болон эрүүл мэндийн үйлчилгээ, арга хэмжээг зохион байгуулах	30.0	30.0	15.0	20.0	5.0	0.0
урлагийн үзвэр үйлчилгээ үзүүлэх, үзэх ажлыг зохион байгуулах	25.0	75.0	0.0	0.0	0.0	0.0
спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулах, дэмжих	40.8	35.2	11.3	12.7	0.0	0.0
хувь хүний хөгжлийн чиглэсэн үйл ажиллагаа	35.9	17.9	28.2	15.4	2.6	0.0

танилцах, танилцуулах үйл ажиллагаа(оюутан хооронд болон багш оюутны хооронд)	51.9	11.1	14.8	22.2	0.0	0.0
мэргэжлийн ур чадвар олгоход чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, байгууллагуудтай танилцах	44.9	26.5	18.4	10.2	0.0	0.0
олон нийтийн арга хэмжээ үйл ажиллагаанд оролцуулах, зохион байгуулах, дэмжих	28.6	21.4	32.1	17.9	0.0	0.0
чөлөөт цагийн бодлого, төлөвлөгөөтэй байж, тогтмол хэрэгжүүлэх	66.7	33.3	0.0	0.0	0.0	0.0
орчин бүрдүүлэх, орчинг сайжруулах(хичээл хийх болон чөлөөт цагаа өнгөрөөх, багаар ажиллах орчин)	34.6	19.2	7.7	38.5	0.0	0.0
хүсэх зүйл байхгүй, одоогийн чөлөөт цагийн үйл ажиллагаа хангалтай сайн байна	33.3	11.1	26.7	26.7	0.0	2.2
чөлөөт цаг гардаггүй тул, сургалтын төлөвлөгөөнд чөлөөт цагийг тусгах	20.0	14.0	31.0	35.0	0.0	0.0
мэдэхгүй	30.0	33.3	13.3	20.0	0.0	3.3
ямар ч үйл ажиллагаа байж болно	27.3	45.5	0.0	18.2	9.1	0.0
бассейн, бялдаржуулах, бүжгийн заал танхимтай болох	8.3	41.7	25.0	16.7	8.3	0.0
номын санг өргөжүүлэх, онлайн номын сантай болох	36.4	27.3	9.1	27.3	0.0	0.0
дугуйлан, секц	50.0	0.0	25.0	25.0	0.0	0.0
бусад	33.3	0.0	22.2	33.3	0.0	11.1

Хүснэгт 12-оос харахад оюутны сайн дурын клубууд, олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулах-зохион байгуулах, хувь хүний хөгжилд чиглэсэн чөлөөт цагийн арга хэмжээ, номын сан, дугуйлан секц, бассейн бялдаржуулах танхимийн үйлчилгээ нь 1-4р курсын оюутнуудын хувьд ижил эрэлт өндөр байна. Харин аялал зугаалга, оюутан хооронд болон оюутан багштай танилцах, энтертайнмент, спорт, соёл урлагийн чөлөөт цагийн үйл ажиллагааны төрлүүдийг 1-2-р курсын оюутнуудын хувьд илүү эрэлт хэрэгцээтэй байна гэж дүгнэж болохоор байна.

5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол улсын их дээд сургууль, коллежид суралцаж буй оюутнууд ерөнхийдөө чөлөөт цагийн амралт(76.3%), зугаа цэнгэл(54%), цаг хугацаа(54%), хэмээн ойлгож, чөлөөт цагийн сэтгэл зүйн болон бие махбодийн өгөөжийг чухалчилж, хобби сонирхолоо хөгжүүлэх, амрах-алжаалаа тайлах, суралцах-өөрийгөө хөгжүүлэх зорилгоор чөлөөт цагаа өнгөрүүлдэг. Чөлөөт цагаа өнгөрөөх гол хэлбэрүүд нь идэвхигүй(71.5%), хичээл сургуультай холбоотой үйл ажиллагаа(56.4%), идэвхитэй хэлбэрүүд(48%) байна. Монгол улсын нийт хүн амын чөлөөт цагийн үйл ажиллагаанд хийсэн судалгааны үр дүнтэй (*нийт хүн амын 83,15% нь чөлөөт цагаа идэвхигүй хэлбэрээр өнгөрүүлдэг*) харьцуулан дүгнэхэд ерөнхийдөө оюутнууд аялал-зугаалга, спорт гэх мэт идэвхтэй хэлбэрийн чөлөөт цагийн төрлүүдийг хүсч байгаа нь эерэг үзүүлэлт юм. Онол арга зүйн болон бусад судалгааны ажлуудын үр дүнгээс харахад идэвхтэй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаа нь идэвхигүй хэлбэрийн чөлөөт цагийн үйл ажиллагаатай харьцуулахд хувь хүний биеийн болон сэтгэл зүйн эрүүл мэнд, бүтээмж, амьдралын чанар, аз жаргалд эерэгээр нөлөөлдөг болох нь батлагдсан.

Судалгаанд оролцсон оюутнуудын дийлэнх нь хоногийн 24 цагийг өдөрт дундажаар 7-8 цагийг унтаж амрах, 3-4 цагийг танхимын болон онлайн хичээлд сууж, 1-4 цагийг хичээлтэй холбоотой бие даалтын ажил даалгавараа хийж, 1-2 цагийг хичээлээс гадуур өөрийгөө хөгжүүлэх ажилд зориулж, 1-2 цагийг гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүй туслаж, 1-30 минутыг олон нийтийн арга хэмжээнд оролцож, чөлөөт цагийн үйл ажиллагаанд 1-2 цагийг, ажил хийдэг оюутнуудын хувьд 5-8 цагийг

цалин хөлстэй ажил эрхлэхэд зориулж байна. Эндээс унтаж амрахаас бусад цаг ашиглалтын байдлыг харьцуулан авч үзвэл цалин хөлстэйгээр ажил эрхэлдэггүй оюутнуудын хувьд хичээлдээ суух, бие даалт, хичээлээ хийх, гэрийн ажил хийх, гэр бүлийн гишүүдэд цалин хөлсгүйгээр туслахад хамгийн их цагийг зарцуулж байна гэж дүгнэж болох юм. Харин сурч буй курсийн хувьд 3-4-р курсын оюутнууд хамгийн чөлөөт цаг багатай байдаг бол 1, 2, 5, 6-р курсын оюутнууд чөлөөт цаг ихтэй байдаг нь судалгааны үр дүнгээс харагдсан. Оюутнуудын хоногийн 24 цагийн хугацаанд чөлөөт цагт зарцуулж буй хугацааг байдлыг сурч буй мэргэжлийн ерөнхий чиглэлүүдээр нь харьцуулан авч үзэхэд архитектур, хот төлөвлөлт, математик компьютер, худалдаа бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн ухааны чиглэлээр сурч буй оюутнууд дундажаас бага, хүмүүнлэг, нийгмийн шинжлэл, үйлчилгээний мэргэжлийн чиглэлээр сурч буй оюутнуудын чөлөөт цаг дундажаас өндөр байна.

Оюутнуудын хамгийн ихээр хүсч буй оюутанд зориулсан чөлөөт цагийн үйл ажиллагаа нь аялал зугаалга, спорт болон соёл урлагийн арга хэмжээ, оюутны сайн дурын клубууд, мэргэжлийн ур чадвар олоход чиглэсэн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, ирээдүйн ажлын байр-байгууллагуудтай танилцах үйл ажиллагаа, хувь хүний хөгжилд чиглэсэн үйл ажиллагаа мөн бусад мэргэжилийн курсын оюутантайгаа танилцах, бусад сургууль, факултет, мэргэжлийн багш нартайгаа танилцах үйл ажиллагааг зохион байгуулахыг хүсч байна. Судалгаанд оролцогчдын цөөнхийн хариулт байсан хэдий ч оюутнууд хичээлээ давтах, мэргэжлийн онцлогоос хамааран багаар ажиллах орчин мөн чөлөөт цагаа ая өнгөрүүлэх орон зай, тохилог өрөө, бассейн бялдаржуулах танхим, бүжгийн заалыг оюутнууддаа зориулан тусгайлан бэлтгэх шаардлагатай нь судалгааны үр дүнгээс харагдсан. Хэдийгээр сургуулиудын санхүүгийн боломж харилцан адилгүй, төсөв хязгаарлагдмал байгаа ч урт хугацааны стратегийн төлөвлөгөөндөө дээрх асуудлуудыг тусгаж, оюутны хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээтэй уялдуулан(мэргэжлийн чиглэл, курс) чөлөөт цагийн бодлого-төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. БСШУЯ, Дээд боловсролын статистик-2019
2. Adesoye A. A and Ajibua M. A., Exploring the Concept of Leisure and Its Impact on Quality of Life, American Journal of Social Science Research, Published online: May 15, 2015
3. Susana Juniu, The Transformation of Leisure, 2010
4. Hung, H.J. A study on leisure benefits breaking through leisure activities. Journal of National Taiwan Normal University, 2012; 3(4): 77-92.
5. Mawarni Binti Mohamed. "Leisure activities, attitudes and satisfaction of youth in the context of malaysian young partners policy". 2013
6. В. И. Корсунова, Публичные досуговые практики в россии: статусные различия и структурные особенности., *Economic and Social Changes*. 2017. № 5. P. 194-213
7. Caldwell, L. L., & Baldwin, C. K. (2003). A serious look at leisure. In F. A. Villarruel, D. F. Perkins, L. M. Borden, & J. G. Keith (Eds.), *Community youth development: Programs, policies, and practices* (pp. 181–200).
8. Marie Louise Caltabiano (1995) Main and Stress-Moderating Health Benefits of Leisure, *Loisir et Société / Society and Leisure*, 18:1, 33-51
9. William B. Gudykunst, John A. Morra, Wynne I. Kantor & Howard A. Parker(1981) Dimensions of Leisure Activities: A Factor Analytic Study in New England, *Journal of Leisure Research*, 28-42
10. Torkildsen, G. (2005), *Leisure and Recreation Management*, 5th ed. New York, Taylor and Francis group
11. Даваасамбуу П. БНМАУ-ын соёл гэгээрлийн ажлын түүхэн замнал.-УБ.:1990.-15-21х.
12. Баатар Г. Соёл урлагийн ажилтны гарын авлага/Ред. Л.Тунгалаг.-УБ.: 2017. -8-18х.
13. Баатар Г. Соёл-чөлөөт цагийн үйл ажиллагааны онол,технологи.-УБ.:2010
14. Баатар Г. Алжаал тайлах соёл/Ред. Ж.Долгорсүрэн.-УБ.: 2007
15. Michael Silk, Jayne Caudwell & Heather Gibson (2017) Views on leisure studies: pasts, presents & future possibilities?, *Leisure Studies*, 36:2, 153-162
16. Driver, B.L. The North American experience in measuring the benefits of leisure. In *Proceedings National Workshop on Measurement of Recreation Benefits*. Bandoora, Australia: Phillip Institute of Technology, 1990; 1-57.
17. Kao, C.H. A three-factor model of leisure benefits. *Journal of Outdoor Recreation Study*, 1995; 8(1): 67-78.
18. Robert A. Stebbins . *Leisure's Legacy Challenging the Common Sense View of Free Time*, 20176 pp.52-58

19. Kyulee Shin, Sukkyung You, Leisure Type, Leisure Satisfaction and Adolescents' Psychological Wellbeing 2013, [Journal of Pacific Rim Psychology](#) 7(02):53-626., DOI: [10.1017/prp.2013.6](#)
20. Kerem Yıldırım Şimşek & Hüseyin Çevik (2020): Development of the Leisure Activity Participation Scale (LAPS), *Loisir et Société / Society and Leisure*, DOI: 10.1080/07053436.2020.1727661
21. Akito Takeuchi, Noriko Sakano, ombined Effects of Working Hours, Income, and Leisure Time on Suicide in All 47 Prefectures of Japan, 2014,
22. Weaver, Diana E., "Leisure Time Activities and Interests of Utah State University Students" (1968). All Graduate Theses and Dissertations. 2911.
23. Alice f. Chang, Ted I. Rosenthal, Elaine s. Bryant,' Renate h. Rosenthal, Comparing high school and college students', Leisure interests and stress ratings, *Be/m. Res. Ther.* Vol. 31, No. 2, pp. 179-184, 1993
24. Teixeira, Ana, and Teresa Freire (2013), The Leisure Attitude Scale: psychometrics properties of a short version for adolescents and young adults. *Leisure/Loisir*, Vol. 37, No. 1, pp.57-67.

HSFS-16

МОНГОЛЫН ХӨГЖМИЙН УРЛАГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

П.Баасанжаргал¹, Монгол Улсын Соёл Урлагийн Их Сургууль, Email: suisbaaska@gmail.com

Б.Нацагдорж², Мандах Их Сургууль, Email: natsagdorj9599@gmail.com

Хураангуй: Аливаа улс үндэстний нийгмийн хөгжил дэвшлийг тодорхойлогч гол хүчин зүйл нь соёл урлагийн салбар байдаг. Соёл урлагийн салбарын нийгэм, эдийн засагт оруулах хувь нэмэр жилээс жилд өсч, зарим улс орнуудын хувьд эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон хөгжиж байна. Монгол улсын соёл урлагийн салбарын зах зээлийн өнөөгийн байдлыг дэлхийн хөгжингүй улс орнуудтай харьцуулахад харьцангуй доогуур байгаа бөгөөд энэхүү салбарыг хөгжүүлэхэд тулгарч буй асуудлуудын нэг бол салбарын маркетингийн хоцрогдол, менежмент маркетингийн систем муу байгаатай холбоотой юм. Хөгжмийн зах зээл нь хэрэглэгчдийн тоо, зах зээлд эзлэх хувь хэмжээгээр соёл урлагийн салбарын зээлд тэргүүлдэг дэд салбар юм. Хөгжмийн урлагийг хөгжүүлэх, дотоод гадаадын зах зээлийн багтаамжийг өсгөхөд салбарын судлаачид, соёлын маркетерүүд юун түрүүнд хэрэглэгчээ судлах, хэрэглэгчдийн зан төлөвийн өвөрмөц байдал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойлох хэрэгтэй. Иймээс бид энэхүү судалгааны ажлын хүрээнд маркетингийн иж бүрдлийн хүчин зүйлс болох бүтээгдэхүүний, үнийн, сувгийн, идэвхижүүлэлтийн, уран бүтээлчийн(хүмүүс), үйл явцын, орчины гэсэн нийт 7 бүлэг 58 хүчин зүйлсээр Монголын хөгжмийн урлагийн хэрэглэгчийн зан төлөвийн онцлог, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорисон. Судалгаанд нийт 3 үндсэн хэсгээс бүрдсэн 23 асуулт бүхий анкет асуулгыг ашиглан, Монгол улсын 21 аймаг, Улаанбаатар хотод амьдарч буй 716 хөгжмийн урлагийн хэрэглэгчээс судалгаа авч, судалгааны өгөгдлийг SPSS24 программыг ашиглан боловсруулсан.

Түлхүүр үг: хөгжим, хөгжмийн хэрэглэгч, хэрэглэгчийн зан төлөв, хөгжмийн хэрэглэгчийн зан төлөв, соёл урлагийн зах зээл, соёл урлагийн маркетинг

1. УДИРТГАЛ

Соёл урлаг нь улс, үндэстний нийгмийн хөгжил дэвшлийг тодорхойлогч хүчин зүйлсийн нэг мөн. Соёл урлагийн салбарын эдийн засагт оруулах хувь нэмэр жилээс жилд өсч, зарим улс орнуудын хувьд эдийн засгийн тэргүүлэх чиглэл болон хөгжиж байгааг АНУ, Ази болон Европын орнуудын жишээнээс харж болно. Хөгжмийн урлаг нь зах зээлийн хэмжээ, хэрэглэгчдийн тоогоороо соёлын хоёр дахь дэд салбар бөгөөд аливаа улсын иргэдийг соёл гэгээрүүлэх, баясгах төдийгүй тухайн улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. 2019 онд дэлхийн хөгжмийн зах зээл 5 жил дараалан 8.2% хүрэл өсөлттэй байсан ба бүс нутгаар нь авч үзвэл Ази 3.4%, Австрали 7.1%, Европ 7.2%, Латин Америк 18.9%, АНУ, Канад 10.4%-иар тус тус өсч, дэлхийн хэмжээнд бүртгэгдсэн хөгжмийн орлого 20.2 тэрбум ам.долларт хүрсэн нь төлбөрт захиалгын урсгал (*paid subscription streaming*) өсөлтөөс үүдэлтэй. Сегментээр нь авч үзвэл: шууд цацалт (*streaming*) 56,1, биет орлого (*physical*) 21,6, тайзны амьд тоглолт (*performance rights revenue*) 12,6, бусад дижитал таталт (*downloads and other digital*) 7,2, хөгжим ашигласны орлого (*synchronisation revenues*) 2,4 байна. Мөн *IFPI*-ийн 2019 оны тайланд тусгасанаар дэлхийн зах зээлийг “поп” хөгжмийн төрөл тэргүүлж байгаа бөгөөд орон нутгийн жанрууд мөн олон оронд амжилттай тоглож байна[1], [2],[3].

Монгол улсын соёл урлагийн салбар 2019 оны байдлаар ДНБ-ий 0.4 хувийг бүрдүүлж байгаа бөгөөд 903 байгууллага(*аж ахуй нэгжийн 1.05*) үйл ажиллагаа явуулж, 7041 ажиллагчид(*улсын нийт ажиллах хүчний 0.56*) 12,351,000 хэрэглэгчдэд соёл урлагийн үзвэр,үйлчилгээг хүргэсэн байна.[4] Өдөгөө Монголын хөгжмийн урлагийн зах зээл дэлхийн бусад орнуудтай харьцуулахад маш жижиг байгаа бөгөөд бизнес утгаараа хөгжихөд маркетинг, менежмент болон дижитал хөгжмийн урсгал, зохиогчийн эрхийн асуудлууд дээр ихээхэн анхаарах хэрэгтэй байгаа юм. Монгол улсад хөгжмийн зах зах зээлийг хөгжүүлэх, цаашлаад

олон улсын зах зээлд хөгжмийн бүтээлүүдийг гаргах гол хөшүүрэг нь хөгжмийн маркетинг юм. Үр ашигтай маркетингийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, оновчтой маркетингийн шийдвэр гаргахад хэрэглэгчээ ойлгох, хэрэглэгчийн зан төлөвийн онцлог, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг нарийвчлан судлах нь нэн чухал. Манай улсын соёл урлагийн байгууллагуудын хувьд хэрэглэгчийн зан төлөвийн судалгааг ховор хийдэг, судалгааны үр дүнд тулгуурлан маркетингийн шийдвэр гаргах байдал дутмаг байна[5]. Иймд соёлын салбарын судлаачид, маркетерууд үйлчлүүлэгчийн зан төлөвийн судалгаанд онцгой анхаарч, үйлчлүүлэгчийн зан төлөвд нөлөөлөгч хүчин зүйлсийг нарийвчлан судлаж, судалгааны үр дүнг маркетингийн шийдвэр гаргалтад ашиглах нь нэн чухал юм. Иймээс бид энэхүү судалгааны хүрээнд хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвийн онцлог, түүн нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорисон.

2. ХЭРЭГЛЭГЧИЙН АВАХ ЗАН ТӨЛӨВИЙН ОНОЛЫН ТОЙМ СУДАЛГАА

Хэрэглэгч бүтээгдхүүнийг худалдаж авах ба хэрэглэх явцдаа хийж байгаа үйлдлийг *Хэрэглэгчийн зан төлөв (Consumer behavior)* гэж ойлгож болно. Хэрэглэгчийн зан төлөвийн онолын үндсийг анх эдийн засагчид болох Nicholas Bernoulli, John Von Neumann, Oskar Morgenstern нар хэрэглэгчийн шийдвэр гаргалтын үе шат, түүнд нөлөөлөгч гадаад хувьсагчдыг тодорхойлох замаар тус онолын суурийг тавьсан гэж үздэг[6]. Хэрэглэгчийн зан төлөвийн талаар олон тодорхойлолтууд байдаг ба судалгааны ажлуудад түгээмэл ашигласан зарим тодорхойлолтыг энд авч үзье. Хэрэглэгчийн зан төлөв гэдэг нь хувь хүн болон бүлгийн бүтээгдэхүүн болон үйлчилгээг сонгох, хэрэглэх мөн бүтээгдэхүүний талаарх туршлага, сэтгэл ханамж, эрэлт хэрэгцээгээ хангах үйл явцын судалгаа юм. Хэрэглэгчийн зан төлөв гэдэг нь хэрэглэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хайх, худалдан авах, ашиглах, тухайн бүтээгдэхүүнээ үнэлэх зэрэг тухайн бүтээгдэхүүн, үйлчилгээг захиран зарцуулахтай холбоотой зан үйлийг хэлнэ. Хэрэглэгчийн зан төлөв байнга хувьсан өөрчлөгдөж байдаг учраас динамик шинж чанартай гэж үздэг[7]. Сэтгэл зүйн, нийгэм соёлын, хувь хүний, маркетингийн иж бүрдлийн болон гадаад, дотоодын өрсөлдөгчид гэх мэт маш олон хүчин зүйлүүдээс шалтгаалан хэрэглэгчийн худалдан авалт хийх, эсэх шийдвэр гардаг. Хэрэглэгчийн зан төлөвийн тайлбарлахад хэрэглэгчийн худалдан авах зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлс, хэрэглэгчийн зан төлөвийн загварууд тусална.

Энэхүү судалгааны ажлын онол арга зүйн үндсийг тодорхойлохын тулд хэрэглэгчийн худалдан авах зан төлөвийн онолын загварууд, хэрэглэгчийн зан төлөв, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаар гадаад, дотоодын судлаачдын бүтээлүүдийг харьцуулан судалсан болно. [8], [9], [10], [11], [12], [13], [14], [15],

[Хүснэгт 1] Хэрэглэгчийн зан төлөвийн онол загварууд, нөлөөлөгч хүчин зүйлс

	Эрдэмтний нэр	Загварын/ бүтээлийн нэр	Загварын онцлог, хүчин зүйлс
1	Andreason A.R	Andreason Model (1965)	Хэрэглэгчийн зан төлөвийн анхны загваруудын нэг бөгөөд энэхүү загвар нь хэрэглэгчийн худалдан авах шийдвэр гаргалтын үйл явцад хэрэглэгчийн хандлага, хэрэглэгчийн үнэ цэн, итгэл үнэмшил, хэм хэмжээ, хэрэглэгчийн худалдан авах чадвар нөлөөлнө гэж үзсэн.
2	Francesco M.Nicosia	Nicosia Model (1966)	Хэрэглэгч худалдан авах шийдвэр гаргах хүртлээ мэдээллийг хүлээн авах, мэдээллийг эрж хайх, мэдээллийг боловсруулах, худалдан авах шийдвэр гаргах гэсэн дөрвөн бүлэг хүчин зүйлс бүхий хэрэглэгчийн зан төлөвийн загвар юм.
3	John Howard & Jagadish Seth	Howard Sheth Model(1969)	Хэрэглэгчийн зан төлөв нь орц, үйл явц(мэдээлэл боловсруулалт), гарц гэсэн бүтэцтэй, хэрэглэгчийн зан төлөвийг тодорхойлох 40-өөд хувьсагч бүхий загвар юм.
4	Кассаржиан Х. (Harold H. Kassarian)	Psychodynamic Model (1971)	Зигмунд Фрейдийн 1890-1930-аад онд боловсруулсан онол, туршилтууд нь одоогийн хэрэглэгчийн худалдан авах үйл явцад илэрдэг сэтгэл зүйн хүчин зүйлстэй нарийн холбоотой болохыг өөрийн судалгаагаараа нотолсон.
5	Moschis	Learning Model(1978)	Хэрэглэгчийн худалдан авах зан төлөвт үйлдвэрлэгч, маркетингийн болон бусад өдөөгчид зайлшгүй байх бөгөөд өдөөгчдийг хүлээн аваад боловсруулах үйл явцад хувь хүний, сэтгэл зүйн байдал чухал

			болохыг өөрийн загвартаа онцолсон.
6	Jagadish Seth & Newman Cross	Sheth Newman Gross Model (1991)	Хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч нийгмийн, хэрэглээний, сэтгэл, хөдлөлийн, мэдлэгийн, нөхцөл байдлын үнэ цэн нөлөөлнө гэж үзсэн.
7	Spaargaren	Sociological Model (1993)	Ф.Котлерийн хэрэглэгчийн хар хайрцагны загвар дээр үндэслэн нийгмийн хүчин зүйлсийн задаргааг нарийвчлан боловсруулсан.
8	Philip Kotler	Black box Model(2003)	Өдөөлт, үйл явц, харну үйлдэл гэсэн үндсэн бүтэцтэй хэрэглэгчийн зан төлөвийн загвар юм.
9	Д. Дагвадорж	Монгол орны үйлдвэрлэгч хэрэглэгчийн харилцан уялдааг хангах маркетингийн удирдлагын арга зүй (2000)	Түүхэн уламжлал, аж төрөх хэм хэмжээтэй уялдуулан Монгол хэрэглэгчийн зан төлөвийн онцлогийг илрүүлэхийг зорьсон.
10	Даваасүрэн.Б	“Монгол хэрэглэгчийн зан төлөвийн онцлог” нэг сэдэвт бүтээлдээ “Хэрэглэгч загвар” (2003)	Монгол хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөх хүчин зүйлсийг дотоод буюу хувийн, гадаад буюу орчны хүчин зүйлс зайлшгүй нөлөөлдөг хэмээн үзсэн. “Хэрэглэгч загвар” нь хувь хүний, хүн амын, эдийн засгийн, соёлын, нийгмийн, маркетингийн, гадаад худалдааны гэсэн 9 хүчин зүйлсээр Монгол хэрэглэгчийн зан төлөвийн онцлогийг судалсан.
11	Бурмаа Б.	“Уланбаатар хотын хэрэглээний хэрэглэгчдийн хэрэглээний ялгаатай бүлгүүдийн онцлог шинж” нэг сэдэвт бүтээл (2014)	Монгол хэрэглэгчийн худалдан авах худалдан авах чадамжийг хүн амын хэрэглээний ялгаатай байдлаар бүлэглэн харуулж, бүлэг тус бүрийн хэрэглээний онцлогийг авч судалсан.
12	Найрамдал.Б	“Монгол хэрэглэгчийн худалдан авах зан төлөвт нөлөөлөх маркетингийн хүчин зүйлсийн судалгаа” (2020)	Монгол хэрэглэгчийн зан төлөвийн онцлогийг маркетингийн бүлэг 4 хүчин зүйлс, 55 хувьсагчийн дагуу авч судалсан. (Ноолууран бүтээгдэхүүний жишээн дээр)

Эх үүсвэр. Судлаачийн боловсруулалт

Дээрх хэрэглэгчийн худалдан авах зан төлөвийн загварууд, хэрэглэгчийн худалдан авах зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлсийг олон улсад хийсэн хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвийн судалгаануудтай харьцуулан судалсан.

3. МОНГОЛЫН ХӨГЖМИЙН УРЛАГИЙН ХЭРЭГЛЭГЧИЙН ЗАН ТӨЛӨВИЙН ОНЦЛОГ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨГЧ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ, АРГАЧИЛАЛ

Дээрх онолын судалгаа болон бусад хамаарах нийтлэлүүдийг үндэслэн судалгааны арга зүй, аргачилалыг дараах байдлаар боловсруулсан. Монголын хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвийн онцлог, түүн нөлөөлөгч хүчин зүйлсийн судалгааг Польш улсын Dabrowa Gornicz их сургуулийн профессор Л. Вроблевский (Lukaz Wroblewski)-ийн “Соёлын үйлчилгээний зах зээл дэх хэрэглэгчийн зан төлөв” судалгаанд ашигласан хүчин зүйлс болон судлаач Б.Найрамдалын “Монгол хэрэглэгчийн худалдан авах зан төлөвт нөлөөлөх маркетингийн хүчин зүйлсийн судалгаа”-ны загварт тулгуурлан 7 бүлэг 58 хүчин зүйлсээр тодорхойлов. [16],

[17], [18]

[Хүснэгт 2] Монгол хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвийг тодорхойлох хүчин зүйлс

Бүтээгдэхүүний хүчин зүйл	1	Дуу, хөгжмийн агуулга, сэдэв
	2	Дуу, хөгжмийн урсгал чиглэл
	3	Уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвар
	4	Уран бүтээлчийн нэмэлт ур чадвар (бүжиглэх, жүжиглэх)
	5	Уран бүтээлчийн танигдсан байдал
	6	Уран бүтээлчийн имиж бүрдүүлэлт
	7	Видео клипний утга, агуулга
	8	Видео клипний дүрийн сонголт
	9	Видео клипийг бүтээсэн студи продакшн сонголт
	10	Дуу, хөгжмийн найруулга, хэмнэл
	11	Дуу хөгжмийн үргэлжлэх хугацаа
	12	Хөгжмийн зохиолчийн сонголт, нэр хүнд
	13	Яруу найрагчийн сонголт, нэр хүнд
Үнийн хүчин зүйлс	1	Би тайзны тоглолтыг орлох хямд үйлчилгээг чухалчилдаг (онлайн, стрийминг)
	2	Би тоглолтын билет худалдаж авахдаа урамшууллыг чухалчилдаг
	3	Би тоглолт үзэхдээ бусад тоглолтуудын үнэтэй заавал харьцуулдаг.
	4	Би чанартай уран бүтээлд хангалттай төлбөр төлхөд бэлэн байдаг
	5	Би дуртай уран бүтээлчийнхээ дуу, хөгжим, тоглолтыг хичээн үнэтэй байсан ч худалдан авдаг/үздэг.
	6	Би үнэгүй тоглолт үзэх дуртай
Маркетингийн сувгийн	1	Би ихэвчлэн хөгжмийг онлайн-аар сонсож/худалдан авдаг
	2	Би тоглолт үзэхдээ автомашины зогсоолыг чухалчилдаг
	3	Би тоглолт үзэхдээ тоглолт болох газрын дотоод орчны тав тухыг эрхэмлэдэг (суудал, хувцасны өлгүүр, буфет, бие засах газар)
	4	Би тоглолт үзэхдээ тоглолт болох газрын гадаад орчны тав тухыг эрхэмлэдэг (гэрэлтүүлэг, дуу чимээ)
	5	Би тоглолтын цагийн хуваарийг чухалчилж үздэг
	6	Би дуу хөгжмийг ихэвчлэн телевиз, FM радигоор хүлээн авч сонсдог
	7	Би тоглолтын билет болон CD-г ихэвчлэн онлайн-аар худалдан авч, хүргүүлдэг
Маркетингийн харилцааны хүчин зүйлс	1	Вэб сайт
	2	Фэйсбүүк пэйж
	3	Инстаграм
	4	Youtube

	5	Телевизийн хөгжмийн суваг/нэвтрүүлэг, сурталчилгаанаас
	6	FM радиогоос
	7	Гудамжны самбар
	8	Найз нөхөд, ойр дотны хүмүүсээс
	9	Сонин сэтгүүлийн зар сурталчилгаа
	10	Тоглолт үзэх, дуу хөгжмийг худалдан авахад борлуулалтын урамшуулал чухал
Уран бүтээлчийн(хүмүүс) хүчин зүйлс	1	Уран бүтээлчийн нэр хүнд
	2	Уран бүтээлчийн ёс зүй
	3	Уран бүтээлчийн царай төрх
	4	Уран бүтээлчийн биеийн галбир
	5	Уран бүтээлчийн биеийн өндөр
	6	Уран бүтээлчийн үс засалт, нүүр будалт
	7	Уран бүтээлчийн хувийн соёл, хүмүүжил
	8	Уран бүтээлчийн гэр бүлийн байдал
	9	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр уран бүтээлчийн өөрийнгөө илэрхийлэх байдал (телевиз, радио, сошиал медиа, вэб....)
	10	Уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвар
	11	Уран бүтээлчийн бүтээлч байдал, хичээл зүтгэл
	12	Уран бүтээлчийн дотоод гадаадын мэргэжлийн уралдаан, тэмцээнд оролцох байдал
Уран бүтээлээ хүргэх үйл явц	1	Шинэ уран бүтээлийн гарах хугацаа
	2	Уран бүтээлийн нээлтийн арга хэмжээ
	3	Тоглолтын зохион байгуулалт
	4	Фэн, дэмжигчидтэйгээ харилцах байдал
Орчины хүчин зүйлс	1	Тоглолтын тайз засалт
	2	Тоглолтын тайзны гэрэлтүүлэг
	3	Тоглолтын үеийн дууны дуугаралт
	4	Техник технологийн шийдэл
	5	Тоглолт зохион байгуулж буй газрын нэмэлт үйлчилгээг шийдсэн байдал

Эх үүсвэр. Судлаачийн боловсруулалт

Хүснэгт 2-т харуулсан 7 бүлэг 58 хүчин зүйлсийн дагуу хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлсон болно.

Судалгааны асуулга боловсруулалт: Энэхүү судалгаанд оролцогчдын талаарх мэдээлэл, Монголын хөгжмийн хэрэглэгчийн ерөнхий зан төлөв, хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлс гэсэн 3 үндсэн хэсэг 23 асуултаас бүрдсэн анкет асуулга болно.

[Хүснэгт 3] Судалгааны асуулгын бүтэц

Хэсэг А	Судалгаанд оролцогчдын талаарх мэдээлэл	Оршин суугаа үндсэн харьяалал, нас, хүйс, боловсролын түвшин, ажил эрхлэлт, нэг сарын дундаж цалин
Хэсэг Б	Хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвийн онцлог	Сонсон сонсдог/үздэг дуу хөгжмийн төрөл/жанр, дуу хөгжим сонсох зорилго, дуу хөгжим сонсох орон зайн болон эх үүсвэрийн сонголт
Хэсэг В	Хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлс	Маркетингийн иж бүрдлийн хүчин зүйлс болох бүтээгдэхүүний, үнийн, сувгийн, идэвхижүүлэлтийн, уран бүтээлчийн(хүмүүс), орчины) гэсэн 7 бүлэг 58 хүчин зүйлс.

Судалгааны өгөгдөл цуглуулалт: Энэхүү судалгаагаар Монголын хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвийн онцлог, түүнд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорисон учир судалгаанд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн иргэдийг хүн амын статистикийн үзүүлэлттэй ойролцоо харьцаатай байхаар сонгож, нийт 716 хэрэглэгчээс судалгаа авсан.

Судалгааны өгөгдөл боловсруулалт, шинжилгээ: Судалгааны өгөгдлийг SPSS24 программыг ашиглан боловсруулж, тодорхойлох статистик, хүчин зүйлс (фактор)-ийн шинжилгээ (хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлж буй хүчин зүйлс) хийв.

4. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Найдвартай байдлын шинжилгээ: Бид боловсруулсан судалгааны асуулгынхаа найдвартай байдлыг шалгах зорилгоор туршилт судалгаа явуулахад(2021 оны 4-р сар) ач холбогдол нь өндөр гарсан тул уг асуулгын дагуу судалгааны өгөгдлийг цуглуулсан. Энэхүү судалгааны өгөгдөлдөө найдвартай байдлын шинжилгээ хийхэд Кронбах альфа (Cronbach's Alpha) коэффициент дундаж үзүүлэлт 0.901, судалгааны түүвэр нь эх олонлогоо төлөөлөх чадварыг шалгах KMO and Bartlett's тест хийхэд KMO коэффициент 0.958 буюу ач холбогдолтой(sig 0.000) гарсан нь энэхүү судалгааны асуулга ойлгомжтой, түүврийн хэмжээ хүрэлцээтэй , түүвэр нь эх олонлогоо төлөөлж чадаж байгааг харуулж байна.


[Хүснэгт 4] Найдвартай байдлыг шинжилгээ

Reliability Statistics <table border="1"> <tr> <td>Cronbach's Alpha</td> <td>Cronbach's Alpha Based on Standardized Items</td> <td>N of Items</td> </tr> <tr> <td>.901</td> <td>.901</td> <td>5325</td> </tr> </table>			Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items	.901	.901	5325	KMO and Bartlett's Test		
			Cronbach's Alpha	Cronbach's Alpha Based on Standardized Items	N of Items						
.901	.901	5325									
			Kaiser-Meyer-Olkin Measure of Sampling Adequacy.	.958							
			Bartlett's Test of Sphericity	Approx. Chi-Square	29706.320						
				df	1596						
				Sig.	.000						

Судалгаанд оролцогчидын талаарх мэдээлэл: Судалгаанд оролцогчдын талаарх мэдээллийг нас, хүйс, боловсрол, ажил эрхлэлтийн байдал, өрхийн ам бүлийн тоо болон нэг сарын дундаж орлого, оршин сууж буй газрын харьяалал гэсэн найман үзүүлэлтүүдээр авч судалсан.


[Хүснэгт 5] Судалгаанд оролцогчдын талаарх мэдээлэл

Хувьсагч	Давтамж	Хувь	Хувьсагч	Давтамж	Хувь
1. Хүйс			5.Боловсролын түвшин		
эрэгтэй	294	41.1	дээд	426	59.5
эмэгтэй	421	58.9	Мэргэжлийн/техникийн	77	10.8
2. Нас			дунд	195	27.2

15 хүртэл	84	11.7	бага	18	2.5
16-18	100	14.0	6.Ажил эрхлэлтийн байдал		
19-23	200	27.9	ажил олгогч (бизнес эрхлэгч)	45	6.3
24-35	148	20.7	төрийн/төсвийн байгууллага	231	32.3
36-45	113	15.8	хувийн хэвшлийн байгууллага	147	20.5
46-54	56	7.8	ИДС, судалгааны байгууллага	6	0.8
55-64	12	1.7	ТББ, олон улсын байгууллага	32	4.5
65 ба түүнээс дээш	3	0.4	мал аж ахуй эрхлэгч, малчин	23	3.2
3. Өрхийн ам бүлийн тоо			өндөр настан, груп	267	5.0
ганцаараа	89	12.4	оюутан	95	13.3
2	75	10.5	сурагч	72	10.1
3	150	20.9	ажилгүй	29	4.0
4	183	25.5	7. Сарын дундаж орлого, төгрөгөөр		
5	134	18.7	420,000 хүртэл	258	36.2
6 ба түүнээс дээш	87	12.1	420,001-600,000	148	20.8
4.Гэрлэлтийн байдал			600,001-900,000	149	20.9
гэрлэсэн	358	50.0	900,001-1,200,000	76	10.7
огт гэрлээгүй	316	44.1	1,200,001-1,500,000	47	6.6
бэлэвсэн	13	1.8	1,500,001-2,500,000	15	2.1
Салсан/ тусдаа амьдардаг	29	4.1	2,500,001-3,500,000	19	2.7
			3,500,001-с дээш	118	2.2
8.Судалгаанд оролцогчдын оршин сууж буй аймаг/дүүрэг					
Улаанбаатар хот					423
Аймаг, сум					248
Дархан хот					28
Эрдэнэт хот					16


Судалгаанд оролцогчдын талаарх дээрх мэдээллийг дээд боловсролын статистик мэдээлэл болон түүврийн тооцоололтой харьцуулан дүгнэхэд эдгээр респондентууд түүврийн зохистой хэмжээг хангаж байна.

Монголын хөгжмийн хэрэглэгчийн ерөнхий зан төлөв: Судалгаанд оролцогчдын дийлэнх нь амрах тайвширах, өөрийгөө идэвхижүүлэх, ямар нэг зүйлийг дурсан санах, ажиллаж байхдаа мөн уйтгарласан үедээ дуу, хөгжмийг сонсдог гэж хариулсан байна.



[Зураг 1] Дуу хөгжим сонсох зорилго ба дуу хөгжим сонсох орон зайн сонголт, хувиар

Харин дуу хөгжмийг сонсох зорилгын хувьд ихэвчлэн гэртээ(37.5) болон машиндаа явж байхдаа(28.7) сонсдог байна. Эрэгтэйчүүд ихэвчлэн өөрийгөө идэвхижүүлэх, ажиллах байхдаа дуу хөгжим сонсдог бол эмэгтэйчүүд гунилсан, уйтгарласан ямар нэг зүйлийг санан дурсах үедээ дуу хөгжим сонсох нь түгээмэл байна.



[Зураг 2] Дуу хөгжмийн төрөл/жан-ийн сонголт ба дуу хөгжим сонсох эх үүсвэр, хувиар

Дуу хөгжмийн сонголтын хувьд хөгжмийн хэрэглэгчдийн дийлэнх нь өөрт таалагдсан дуу, хөгжимөө ямар нэг төрөл, жанр харгалзахгүйгээр сонсон сонсох байдал давамгайлж байна. Ерөнхийдөө поп болон зохиолын дуу нь Монголын хөгжийн хэрэглэгчийн хамгийн их сонгон сонсдог төрөл байна. Сонгодог дуу хөгжмийг 45 хүртлэх насныхан, ардын, зохиолын болон уртын дууг 36-аас дээш насныхан, поп дууг бүх насныхан, рок дуу хөгжмийг 54 хүртлэх насныхан, реп, хип хоп, регги дуу хөгжмийг 24 хүртлэх насныхан түлхүү сонсодог байна. Зураг 2-оос харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь дуу хөгжмийг гар утас, таблет болон youtube-ээс сонсдог байна. Эндээс дуу хөгжмийг сонсох, хүлээн авах эх сурвалж нь дижитал шилжилтийн нөлөөгөөр орчин үеийн техник технологи, интернетийн эх үүсвэтэй шууд холбогож байна. Ковид-19 цар тахалын нөлөөгөөр олон улсад стрийминг үйлчилгээ өндөр өсөлттэй байгаа хэдий ч Монголын хөгжмийн хэрэглэгчидийн цөөнх нь л стрийминг үйлчилгээг хэрэглэж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Дуу, хөгжим сонсох эх үүсвэрийн сонголт нь судалгаанд оролцогчдын насны бүтцээс хэрхэн хамаарч байгааг авч үзвэл:

[Хүснэгт 6] Дуу хөгжим сонсох эх үүсвэр ба судалгаанд оролцогчдын насны хамаарал

		Судалгаанд оролцогчдын насны бүтэц							
		15 хүртэл	16-18	19-23	24-35	36-45	46-54	55-65	65+
1	Тайз (тоглолт үзэх)	7.7%	10.7%	10.3%	10.3%	17.5%	20.7%	17.0%	35.0%
2	Гар утас, таблет	20.5%	25.9%	31.0%	24.3%	21.3%	17.1%	15.0%	15.0%
3	Телевиз	12.8%	11.1%	9.9%	12.8%	17.3%	21.7%	28.0%	40.0%
4	FM радио	5.1%	3.3%	3.9%	7.6%	7.6%	9.2%	8.0%	10.0%
5	Суурин компьютер	2.6%	3.7%	3.9%	6.6%	5.3%	6.5%	11.0%	0.0%
6	Зөөврийн компьютер	7.7%	5.3%	5.0%	4.2%	3.6%	2.8%	5.0%	0.0%
7	I pad, i pod, podcast	10.3%	9.9%	6.7%	6.5%	4.8%	3.2%	1.0%	0.0%
8	Youtube.com	25.6%	24.3%	25.5%	21.4%	14.7%	8.8%	8.0%	0.0%
9	CD/DVD	7.7%	3.7%	3.0%	5.1%	6.5%	7.8%	5.0%	0.0%
10	Бусад	0.0%	2.1%	.9%	1.2%	1.5%	2.3%	2.0%	0.0%


Хүснэгт 6-аас харахад 54 хүртлэх насны хэрэглэгчид гар утас, таблет болон youtube сувгаас, 55-аас дээш насны хэрэглэгчдийн дийлэнх нь тайз, телевиз, радиогоор дуу, хөгжмийг сонсдог гэж хариулжээ. Энд гар утасыг бүхий л насны хэрэглэгчид ашигладаг боловч 55-аас дэш насны хэрэглэгчид бусад насныхантай харьцуулахад харьцангуй бага ашигладаг байна. Дуу хөгжим сонсох эх үүсвэр хот хөдөөгийн хэрэглэгчдийн сонголтод ялгаатай байгаа эсэхийг тодруулахад мэдээллийн технологийн хэрэгслийг ашиглан дуу хөгжим сонсох байдал Улаанбаатар хотод илүү байхад телевиз болон тайзнаас дуу хөгжим сонсох байдал хөдөө орон нутгийн хэрэглэгчдэд илүү байгаа нь харагдсан. Дуу, хөгжмийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулахад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.



[Зураг 3] Дуу хөгжмийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлс

Зураг 3-аас харахад дуу хөгжмийг сонгон сонсоход хамгийн их нөлөөдөг хүчин зүйлсүүд нь дуу хөгжмийн агуулга, сэдэв(44,7), уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвар(37.1), дуу хөгжмийн урсгал чиглэл(35.9), хэрэглэгчийн үзэл бодол, амьдралын хэв маяг(35.7), дэлхийн дуу хөгжмийн зах зээлийн чиг хандлага(25,1) гэж хариулсан байна.


Дуу хөгжмийн гарал үүсэл, зохиогдсон улс орноос хамааран хэрэглэгчдийн дуу хөгжмийн сонголт ямар байхыг тодруулахад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.



[Зураг 4] Дуу хөгжмийг бүтээсэн улсаас хамаарах сонгох байдал

Судалгаанд оролцогчдын дийлэнх нь Монгол, Орос, АНУ, Солонгос, Европ дуу хөгжмийг сонгон сонсдог гэж хариулсан бол 18 хүртлэх насны хэрэглэгчид Солонгос, Англи дуу ихэвчлэн сонсдог бол Монгол, Орос дуу хөгжим бараг сонсдоггүй, 46-аас дээш насны хэрэглэгчид ихэвчлэн Монгол, Орос дууг сонсдог, 24-45 насны хэрэглэгчид бүхий л улс орны дуу, хөгжмийг сонирхон сонсдог гэж хариулжээ.

Судалгаанд оролцогчидоос дуу, хөгжмийн тоглолт үзэх байдлыг тодруулахад дийлэнх нь буюу 31,0 нь улиралд 1-2 удаа, 27,9 нь жилд 1-2 удаа, харин 6,5 нь огт тоглолт үздэггүй гэж хариулснаас харахад цөөн давтамжтай хэдий ч ямар нэг байдлаар тоглолт үздэг болох нь харагдаж байна. (зураг 5)



[Зураг 5] Дуу хөгжмийн тоглолт(тайзнаас) үзэх байдал ба нэг удаагийн тоглолтод зарцуулдаг мөнгөн дүн


Дуу, хөгжмийн тоглолт үзэх давтамж судалгаанд оролцогчдын наснаас хэрхэн хамаарахыг авч үзэхэд 36-аас дээш насны иргэдийн тоглолт үзэх тоо бусад насны иргэдээс олон байгаа бөгөөд 65-аас дээш насны иргэдийн 50 нь жилд 1-2 удаа тоглолт үздэг гэж хариулсан. Судалгааны үр дүнгээс харахад дуу, хөгжмийн хэрэглэгчид нэг удаа тоглолт үзэхэд дундажаар 33,500 төгрөг зарцуулдаг. Зураг 5-аас харахад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 26.1 нь 15,000-30,000 төгрөг, 20.5 нь 30,000-45,000 төгрөг, 17.7 нь 5,001-15,000 төгрөгөөр дуу, хөгжмийн тоглолт үздэг гэж хариулсан. Хот, хөдөөгийн хэрэглэгчдийн нэг удаагийн тоглолтод зарцуулах мөнгөн дүн ялгаатай байгаа бөгөөд Улаанбаатар хотын иргэд ихэвчлэн 15000-60000₮-ийг төлдөг бол хөдөө орон нутгийн иргэд 5000-30000 төгрөгийг төлдөг байна.

Монгол дуу хөгжмийг сонгон үйлчлүүлэх байдлыг тодруулахад судалгаанд оролцогчдын 13.3 нь зөвхөн Монгол дуу хөгжим сонсдог, 82.7 нь таалагдсан Монгол дуу хөгжмийг сонсдог гэж хариулсан бол 4 нь Монгол дуу хөгжим сонсдоггүй гэж хариулсан байна. Тэгвэл Монгол дуу, хөгжмийн сонголт судалгаанд оролцогчдын наснаас хэрхэн хамаарахыг авч үзэхэд:

[Хүснэгт 7] Монгол дуу хөгжмийн сонголт ба судалгаанд оролцогчдын насны хамаарал

		Судалгаанд оролцогчдын насны бүтэц, хувиар								
		15 хүртэл	16-18	19-23	24-35	36-45	46-54	55-65	65+	
1	Зөвхөн монгол дуу хөгжим сонирхдог	8.3	4.7	8.9	12.9	13.1	21.3	34.1	22.2	
2	Таалагдсан монгол дуу хөгжмийг сонсдог	75.0	84.9	88.2	84.0	83.0	74.2	65.9	77.8	
3	Монгол дуу хөгжим сонирхдоггүй	16.7	10.5	3.0	3.1	4.0	4.5	0.0	0.0	

Хүснэгт 7-оос харахад 18 хүртлэх насны хэрэглэгчдийн дийлэнх нь Монгол дуу хөгжим төдийлөн сонирхдоггүй бол 55-аас дээш насны хэрэглэгчид гадаад дууг огт сонсдоггүй зөвхөн Монгол дуу хөгжмийг сонгон сонсдог. Харин таалагдсан Монгол дуу хөгжмийг сонсдог хэрэглэгчийн хувьд тухайн дуу хөгжмийн урсгал чиглэлээс хамааран өөрт таалагдсан дуу хөгжмийг сонгон сонсдог байна. Цаашид Монголд хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдлийг тодруулахад судалгаанд оролцогчид дараах байдлаар хариулсан байна.



[Зураг 6] Монголд хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдэл

Монголд хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдлийг 1)уран бүтээлийн чанарыг сайжруулах, инноваци хийх, уран нэр төрлийг нэмэгдүүлэх(26.3%), 2)дуу хөгжмийн маркетинг, менежментийг сайжруулах, продюсингийн үйлчилгээг хөгжүүлэх 3) уран бүтээлийн агуулга, үг, найруулгыг сайжруулах, уул хараад уул гэж дуулахгүй байх, 4)уран бүтээлчид мэргэжлийн ур чадвараа сайжруулах, цаашид зэрэглэлтэй болох, 5) уран бүтээлч болон уран бүтээлийг төрөөс бодлогоор дэмжих, 6) уран бүтээл болон уран бүтээлчдийн нийгэмд үзүүлэл нөлөөлөл, уран бүтээлчид ёс зүй- биеэ авч явах байдалдаа анхаарах гэсэн саналыг хэлжээ.

Монголын хөгжмийн хэрэглэгчийн ерөнхий зан төлөвт нөлөөлөг хүчин зүйлс: Хүчин зүйлийн шинжилгээний шалгуурыг 0.7<-аас эхэлж өсгөж, шаардлага хангаагүй(хамаарал багатай) нийт 17 хүчин

зүйлсийг хасч, фактор шинжилгээний үр дүнд Монголын хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлсийг илэрхийлэх чадвартай гэж үзсэн нийт 41 хүчин зүйлсийг Хүснэгт 8-д харуулав.

[Хүснэгт 8] Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Rotated Component Matrix ^a									
№		Хүчин зүйлс	Component						
			1	2	3	4	5	6	7
4	Бүтээгдэхүүн	Уран бүтээлчийн нэмэлт ур чадвар (бүжиглэх, жүжиглэх)	.861						
5		Уран бүтээлчийн танигдсан байдал	.787						
6		Уран бүтээлчийн имиж бүрдүүлэлт	.704						
8		Видео клипний дүрийн сонголт	.773						
9		Видео клипийг бүтээсэн студи продакшний сонголт	.845						
10		Дуу, хөгжмийн найруулга, хэмнэл	.821						
11		Дуу хөгжмийн үргэлжлэх хугацаа	.746						
12		Хөгжмийн зохиолчийн сонголт, нэр хүнд	.875						
13		Яруу найрагчийн сонголт, нэр хүнд	.737						
1	Үнэ	Би тайзны тоглолтыг орлох хямд үйлчилгээг чухалчилдаг (онлайн, стрийминг)		.720					
2		Би тоглолтын билет худалдаж авахдаа урамшууллыг чухалчилдаг		.711					
3		Би тоглолт үзэхдээ бусад тоглолтуудын үнэтэй заавал харьцуулдаг.		.784					
6		Би үнэгүй тоглолт үзэх дуртай		.809					
2	Хуваарилалт	Би тоглолт үзэхдээ автомашины зогсоолыг чухалчилдаг							
3		Би тоглолт үзэхдээ тоглолт болох газрын дотоод орчны тав тухыг эрхэмлэдэг (суудал, хувцасны өлгүүр, буфет, бие засах газар)			.711				
4		Би тоглолт үзэхдээ тоглолт болох газрын гадаад орчны тав тухыг эрхэмлэдэг (гэрэлтүүлэг, дуу чимээ)			.721				
5		Би тоглолтын цагийн хуваарийг чухалчилж үздэг			.703				
1	Идэвхижүүлэлт	Фэйсбүүк пэйж				.852			
4		Youtube				.802			
5		Телевизийн хөгжмийн суваг/нэвтрүүлэг, сурталчилгаанаас				.760			
6		FM радиогоос				.809			
7		Гудамжны самбар				.849			
8		Найз нөхөд, ойр дотны хүмүүсээс				.740			
2		Уран бүтээлчийн ёс зүй					.880		

3		Уран бүтээлчийн царай төрх					.835		
4		Уран бүтээлчийн биеийн галбир					.883		
5		Уран бүтээлчийн биеийн өндөр					.850		
6		Уран бүтээлчийн үс засалт, нүүр будалт					.783		
7		Уран бүтээлчийн хувийн соёл, хүмүүжил					.817		
8		Уран бүтээлчийн гэр бүлийн байдал					.755		
9		Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр уран бүтээлчийн өөрийнгөө илэрхийлэх байдал (телевиз, радио, сошиал медиа, вэб....)					.743		
10		Уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвар					.835		
11		Уран бүтээлчийн бүтээлч байдал, хичээл зүтгэл					.926		
1	Үйл явц	Шинэ уран бүтээлийн гарах хугацаа						.704	
3		Тоглолтын зохион байгуулалт						.881	
4		Фэн, дэмжигчидтэйгээ харилцах байдал						.823	
1	Орчин	Тоглолтын тайз засалт							.907
2		Тоглолтын тайзны гэрэлтүүлэг]							.916
3		Тоглолтын үеийн дууны дуугаралт							.955
4		Техник технологийн шийдэл]							.928
5		Тоглолт зохион байгуулж буй газрын нэмэлт үйлчилгээг шийдсэн байдал							.842

Фактор анализ хийхэд бүтээгдэхүүний хүчин зүйлсээс 3, үнийн хүчин зүйлсээс 2, хуваарилалтын сувгийн хүчин зүйлсээс 2, идэвхижүүлэлтийн хүчин зүйлсээс 4, уран бүтээлчийн хүчин зүйлсээс 2, үйл явцын хүчин зүйлсээс 1 хувьсагч шаардлага хангаагүй тул тус тус хасагдсан. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнгээс харахад ерөнхийдөө бүтээгдэхүүний, үйлчилгээ үзүүлэгч хүмүүс буюу уран бүтээлч, орчин, идэвхижүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөөлөл өндөр гарсан. Хүчин зүйлс тус бүрээр судалгааны үр дүнг авч үзвэл:

- Бүтээгдэхүүний хүчин зүйлсээс уран бүтээлчийн нэмэлт ур чадвар, уран бүтээлийн видео клип, дуу бичлэгийг бүтээсэн студи продакшний сонголт, дуу хөгжмийн хэмнэл, найруулга, хөгжмийн зохиолчийн сонголт, нэр хүнд хамгийн өндөр,
- Үнийн хүчин зүйлсээс үнэггүй тоглолт, урамшуулалтай тоглолт хамгийн өндөр,
- Хуваарилалтын сувгийн хүчин зүйлсээс тоглолт болох газар(танхим, заал)-ын гадаад дотоод орчины тохь тух, техник технологийн шийдэл хамгийн өндөр,
- Идэвхжүүлэлтийн хүчин зүйлсээс уран бүтээлчийн фэйсбүүк пэйж хуудас хөгжүүлэлт, youtube суваг, гудамжны самбарын мэдээлэл хамгийн өндөр,
- Уран бүтээлчийн хүчин зүйлсийн хувьд уран бүтээлчийн ёс зүй, уран бүтээлчийн царай төрх, уран бүтээлчийн биеийн галбир, уран бүтээлчийн биеийн өндөр, уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвар, уран бүтээлчийн бүтээлч байдал, хичээл зүтгэл гэсэн хүчин зүйлс өндөр,
- Үйл ажиллагааны хүчин зүйлсээс тоглолтын зохион байгуулалтын шийдэл, фэн дэмжигчидтэйгээ тууштай тасралтгүй харилцаатай байх гэсэн хүчин зүйлс,
- Орчины хүчин зүйлсээс тоглолтын тайз засалт, гэрэлтүүлэг, дуугаралт, тоглолтын техник технологийн шийдэл гэсэн хүчин зүйлс хамгийн ихээр нөлөөлж байгаа нь фактор шинжилгээний үр дүнгээс харагдаж байна.

5. ДҮГНЭЛТ

Монголын хөгжмийн урлагийн хэрэглэгчид ихэвчлэн амрах тайвширах, өөрийгөө идэвхижүүлэх, ямар нэг зүйлийг дурсан санах зорилгоор, гэртээ болон машиндаа явахдаа гарт утас таблет ашиглан, голдуу youtube-ээс дуу хөгжмийг сонсдог байна. Дуу хөгжмийн төрөл/сонголтын хувьд хөгжмийн хэрэглэгчдийн дийлэнх нь өөрт таалагдсан дуу, хөгжимөө ямар нэг төрөл, жанр харгалзахгүйгээр сонгон сонсох байдал давамгайлж байна. Ерөнхийдөө поп болон зохиолын дуу нь Монголын хөгжмийн хэрэглэгчийн хамгийн их сонгон сонсдог төрөл байна. Судалгаанд оролцогчдын 13.3% нь зөвхөн Монгол дуу хөгжим сонсдог, 82.7% нь таалагдсан Монгол дуу хөгжмийг сонсдог гэж хариулсан бол 4% нь Монгол дуу хөгжим огт сонсдоггүй байна. Хөгжмийн хэрэглэгчдийн дийлэнх нь Монгол, Орос, АНУ, Солонгос, Европ дуу хөгжмийг сонгон сонсдог гэж хариулсан бол 18 хүртлэх насны хэрэглэгчид Солонгос, Англи дуу ихэвчлэн сонсдог бол Монгол, Орос дуу хөгжим бараг сонсдоггүй, 46-аас дээш насны хэрэглэгчид ихэвчлэн Монгол, Орос дууг сонсдог, 24-45 насны хэрэглэгчид бүхий л улс орны дуу, хөгжмийг сонирхон сонсдог байна. Дуу хөгжмийн сонголтод нөлөөлөгч гол хүчин зүйлс нь нас, ажил мэргэжил, амьдарч буй газрын байршил, техник технологийн орчин болно.

Судалгаанд оролцогчдын 16.5% нь тайзнаас тоглолт үздэг ба нэг удаа тоглолт үзэхэд дундажаар 33,500 төгрөг зарцуулдаг. Хот, хөдөөгийн хэрэглэгчдийн нэг удаагийн тоглолтод зарцуулах мөнгөн дүн ялгаатай байгаа бөгөөд Улаанбаатар хотын иргэд ихэвчлэн 15000-60000₮-ийг төлдөг бол хөдөө орон нутгийн иргэд 5000-30000 төгрөгийг төлдөг. Монголд хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, шийдлийг 1)уран бүтээлийн чанарыг сайжруулах, инноваци хийх, уран нэр төрлийг нэмэгдүүлэх(26.3%), 2)дуу хөгжмийн маркетинг, менежментийг сайжруулах, продюсингийн үйлчилгээг хөгжүүлэх 3)уран бүтээлийн агуулга, үг, найруулгыг сайжруулах(“уул хараад уул байнааа гэж дуулахгүй байх...”), 4)уран бүтээлчид мэргэжлийн ур чадвараа сайжруулах, цаашид зэрэглэлтэй болох, 5) уран бүтээлч болон уран бүтээлийг төрөөс бодлогоор дэмжих, 6) уран бүтээл болон уран бүтээлчдийн нийгэмд үзүүлэл нөлөөлөл, уран бүтээлчид ёс зүй- биеэ авч явах байдалдаа анхаарах хэрэгтэй гэж үзсэн.

Монголын хөгжмийн урлагийн хэрэглэгчийн зан төлөвт нөлөөлөгч хүчин зүйлсийг маркетингийн иж бүрдлийн 7 бүлэг 58 хүчин зүйлсийн дагуу судлаж, хүчин зүйлсийн шинжилгээ хийсэн. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүнд хөгжмийн хэрэглэгчийн зан төлөвт оричны хүчин зүйлс-0.909, уран бүтээлчийн(хүмүүс)-0.831, үйл явцын(процесс)-0.803, бүтээгдэхүүний-0.737, идэвхижүүлэлтийн хүчин зүйлс-0.781 хамгийн ихээр нөлөөлдөг болох нь харагдсан. Энэхүү хөгжмийн урлагийн хэрэглэгчийн зан төлөвийн онцлог, түүнд түүнийг илэрхийлэгч хүчин зүйлсээс харахад цаашид дуу, хөгжмийг зах зээлийг хөгжүүлэхэд уран бүтээлчийн мэргэжлийн ур чадвараас илүүтэйгээр имиж бүрдүүлэлт, уран бүтээлчийн ёс зүй, нийгэм ба хэрэглэгчидтэйгээ харилцах харилцаа-хандлага болон хувь хүний дотоод мөн чанар-ёс суртахуун, биеэ авч явах байдал чухал байна. Мөн дотоодын зах зээлд дуу, хөгжмийн бүтээл амжилт олоход орчин үеийн техник технологийн шийдэл, орчиныг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх асуудал чухал байна.

НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

- [1] Art Basel, Sales in global art market-2018 report
- [2] IFPI Global Music Report 2019
- [3] IFPI's Global Music Listening 2019
- [4] МУҮСХ, Салбарын танилцуулга-2019
- [5] Баасанжаргал П. Оюунцэцэг Л, Монгол улсын теарт чуулгын маркетингийн өнөөгийн байдалд хийсэн судалгаа, 2020
- [6] Бурмаа.О.(2014). Улаанбаатар хотын хэрэглэгчийн хэрэглээний ялгаатай бүлгүүдийн онцлог шинж.
- [7] Найрамдал.Б. (2020). “Монгол хэрэглэгчийн худалдан авах зан төлөвт нөлөөлөх маркетингийн хүчин зүйлсийн судалгаа”
- [8] Даваасүрэн. Б(2003). Монгол хэрэглэгчийн зан төлөвийн онцлог.
- [9] Дагвадорж.Д(2000). Монгол орны үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн харилцан уялдааг хангах маркетингийн удирдлагын асуудлууд.
- [10] Solomon, M. e. (2006). *Consumer Behavior: A European Perspective. 3rd edition.* Prentice Hall.

- [11] Schieffman, L. G. (2007). *Consumer behavior. 9th edition*. New Jersey: Prentice Hall.
- [12] Richarme, M(1964). *Consumer Decision Making Models. Strategies and Theories*.
- [13] Ram Komal Prasad and Manoj K.Jha, *Consumer buying decision models: A descriptive study*, 2014
- [14] Ram Komal Prasad , *Consumer buying decision model5 A descriptive study*, 2014
- [15] Otavio Bandeira De Lamonica Friere, *The influence of music in consumer behavior*, 2012
- [16] Lukaz Wroblewski, *Consumer behavior in the market of cultural services*, 2018
- [17] Lukaz Wroblewski, *Polish-Czech micro-project as tool for shaping consumer behavior on the cross-border market for cultural services*, 2020
- [18] Dominique Bourgeon-Renault, *Evaluating Consumer behavior in the field of Arts and Cultural Marketing*, 2015

ITOS-19

Хөдөлгөөний мэдрүүр ашигласан гольфын савалт Таних төхөөрөмжийн хөгжүүлэлт

Цэвээндоржийн Цэлмэг¹, Аюурзанын Одгэрэл², Ким Ён Хүн³

¹ШУТИС, МХТС, Электроникийн салбар, Магистрант

²ШУТИС, МХТС, Электроникийн салбар, Доктор

³Phinetworks ХХК, Захирал

¹ tselmeg.tsj@gmail.com, ² odgere155@must.edu.mn, ³ phizigi@phigolf.com

Хураангуй

Энэхүү судалгааны ажлаар MPU9250 хөдөлгөөний мэдрүүр ашиглан гольфын цохиурын савалтыг таних, хөдөлгөөний анализ хийх техникийн шийдэл болон шинэ алгоритм боловсруулан хөгжүүлж, туршилт хийсэн. Хөдөлгөөн мэдрүүр (Inertial Measurement Unit) нь ихэвчлэн биеийн эргэлт хэмжигч гироскоп (Gyroscope), шугаман хөдөлгөөний хурдатгал хэмжигч (Accelerometer) мөн нэмэлтээр зүг чиг тодорхойлох соронзон хэмжүүр (Magnetometer) агуулсан бичил цахим элемент юм. Биеийн байршил тодорхойлох, хөдөлгөөний шинж чанарын анализ судалгаа хийх, техник тоног төхөөрөмжийг удирдах гэх мэт зорилгоор хөдөлгөөн мэдрүүр нь навигацийн төхөөрөмж түүний бүрдэл хэсэг, ухаалаг болон зүүдэг төхөөрөмжүүд, биеийн тамир спорт, тоглоомын хэрэгслүүд, хяналт мониторингийн системүүдэд өргөн ашиглагдаж байна.

Түлхүүр үг: Шугаман хөдөлгөөн, хурдатгал хэмжигч, гироскоп, шуугианы шүүлтүүр, кватернион тооцоолол

Удиртгал

Гольфын спортод цохиурын савалтыг таних, хөдөлгөөний анализ хийхэд High speed motion capture, LiDAR, RADAR, IMU гэх мэт олон төрлийн тоног төхөөрөмж, мэдрүүр, технологиудыг ашиглаж байна [1, 2, 3].

Хөдөлгөөн мэдрүүр (IMU) нь гироскоп, хурдатгал хэмжигч, зарим тохиолдолд соронзон хэмжигчийг хамруулан хамтад нь нэг микро чипд интеграци хийж оруулсан үнэ хямд, энергийн зарцуулалт багатай, хэмжилтийн нарийвчлалыг хэрэглээний шаардлагад нийцүүлэн өөрчлөх тохируулах боломжтой олон зориулалт бүхий MEMS (Micro-Electro-Mechanical Systems) цахим элемент юм. Хэрэглээнд өргөн ашиглагдаж байгаа хөдөлгөөн мэдрүүрүүд нь хэмжүүрүүдийн гаралтын өгөгдлийг I2C портоор 400kHz эсвэл SPI портоор 1MHz хүртэл хурдтайгаар хүлээн авагч модулд дамжуулж байна. Үйлдвэрлэгчийн загвараас хамааран гироскоп нь ± 250 , ± 500 , ± 1000 , ± 2000 , $\pm 4000^\circ/\text{sec}$ (degree per second) хүртэл эргэлтийн өнцгийг хэмжих, хурдатгал хэмжигч нь $\pm 2g$, $\pm 4g$, $\pm 8g$, $\pm 16g$, $\pm 32g$ хүртэл хурдатгал хэмжих хязгаартайгаар хэмжилтийн нарийвчлалыг тохируулдаг.

Гольфын спортод хөдөлгөөн мэдрүүр ашиглан цохиурын савалтанд анализ хийхэд дараах үндсэн аргуудыг ихэвчлэн ашиглаж байна [4, 5, 6]. Үүнд:

1. Мэдрүүрийг цохиурт (ишний дунд, төгсгөлд гэх мэт) эсвэл гарны мөчийн хэсэгт (гарын сарвууны ар тал, бугуй гэх мэт) тодорхой чиглэлд тохируулан бэхлэх
2. Мэдрүүрийн өгөгдлийн цуглуулах, тоон дохио боловсруулалтанд үйлдвэрлэгчийн SDK-г ашиглах, firmware программд интеграци хийж нэгтгэх
3. Цохиурын савалтыг хөдөлгөөний эрчимд үндэслэн таних
4. Хэмжилт, тооцооллын үр дүнг бодит цохиурын савалтанд дөхүүлэн хувиргахдаа туршилт/сургалтын өгөгдөлтэй харьцуулан жиших арга ашиглах


Энэхүү судалгааны ажлаар гольфын цохиурын савалтанд анализ хийх дээр дурдсан уламжлалт аргыг сайжруулах дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. Хөдөлгөөн мэдрүүрийг бэхлэх чиглэлээс үл хамааран савалт таних алгоритм боловсруулах
2. Тоон дохио боловсруулалт, цохиурын савалтанд анализ хийх программ хангамжийг API (Application Programming Interface) болгон загварчлах
3. Хэмжилт, тооцооллын үр дүнг бодит цохиурын савалтад полиномиал функцээр дөхүүлэн хувиргах

1. Гольфын спортын тухай

Гольф нь цохиурын савалт, түүний техникт суурилсан спорт. Дараах үндсэн чадвар техникт суралцаж хөгжүүлэх шаардлагатай байдаг. Үүнд:

1. Цохиурын савалтын зөв техниктэй байх
 - Цохиур саваhad бэлтгэх биеийн байрлал
 - Цохиур савж байх үеийн гар, их бие, хөлийн хөдөлгөөн, хүчний шилжилт
 2. Бөмбөг хөөргөх зайнаас хамааран цохиурын савалт, хүчийг тохируулах
- Зураг 1-д цохиурын савалтын үндсэн хөдөлгөөн ба байрлалыг харуулав [6].



Зураг 1. Цохиурын савалтын хөдөлгөөн, байрлал

Цохиурын савалтанд хийсэн анализын үр дүнг дараах үзүүлэлтүүдийн хэмжилтээр тодорхойлдог. Үүнд:

1. Бөмбөг цохих үеийн хурд (Club head speed)
2. Бөмбөг цохих үеийн савалтын чиглэл ба зорилтот чиглэл хоорондын өнцөг (Swing path)

3. Цохиурын толгойн нүүр хэсэг бөмбөгтэй харьцах үеийн хэвтээ өнцөг (Face angle)
4. Цохиурын толгойн нүүр хэсэг бөмбөгтэй харьцах үеийн босоо өнцөг (Attack angle)
5. Цохиурыг савах үеийн хугацааны харьцаа (Tempo = Back swing / Down swing)

2. Цохиурын савалтын шинжилгээ

Гольфын цохиурын савалтанд шинжилгээ хийх төхөөрөмжийн ажиллагаа нь Зураг 2-г үзүүлсэн дэд процессуудад хуваагдана.



Зураг 2. Савалтанд шинжилгээ хийх процессууд


2.1 Өгөгдөл цуглуулах

Хөдөлгөөн мэдрүүрээс гироскоп, хурдатгал хэмжигчийн гаралтын өгөгдлийг Bluetooth 4.2 [7] утасгүй сүлжээгээр хүлээн авагч төхөөрөмжид дамжуулна. Хүлээн авагч төхөөрөмж нь гольфын цохиурын бэлтгэх байдлаас эхлэн савалт дуусах хүртэлх мэдрүүрийн багц өгөгдлийг [8, 9] хүснэгт 1-д үзүүлсэнээр санах ойд цуглуулна.

Хүснэгт 1. Хөдөлгөөн мэдрүүрийн нэг багц өгөгдөл, нийт 12 байт

Нэр	Тайлбар
ACCEL_XOUT_H, ACCEL_XOUT_L	Хурдатгал хэмжигчийн X утгын ахлах ба бага байт
ACCEL_YOUT_H, ACCEL_YOUT_L	Хурдатгал хэмжигчийн Y утгын ахлах ба бага байт
ACCEL_ZOUT_H, ACCEL_ZOUT_L	Хурдатгал хэмжигчийн Z утгын ахлах ба бага байт
GYRO_XOUT_H, GYRO_XOUT_L	Гироскопын X утгын ахлах ба бага байт
GYRO_YOUT_H, GYRO_YOUT_L	Гироскопын Y утгын ахлах ба бага байт
GYRO_ZOUT_H, GYRO_ZOUT_L	Гироскопын Z утгын ахлах ба бага байт

Өгөгдлийг утасгүй сүлжээгээр дамжуулах firmware түвшний протоколыг зураг 3-д дүрсэлсний дагуу загварчилж, хүснэгт 2-г протоколын тайлбарыг үзүүлэв.



Зураг 3. Өгөгдөл дамжуулах Sequence UML Diagram

Хүснэгт 2. Өгөгдөл дамжуулах протокол

Нэр	Тайлбар			
	STX	CMD	LEN	Payload
CMD_PLAY_MODE (API – Device)	0xF7	0x20	0x02	0x01/0x00
REPLY_RAW_DATA (Device – API)	0xF7	0x88	0x0D	Packet
CMD_SENSOR_SWNG (API – Device)	0xF7	0x2C	0x01	0x00
	Хөдөлгөөн мэдрүүрийн төхөөрөмж LED-Цохиурын савалт төлөв			

2.2 Дохио боловсруулах

Хөдөлгөөний мэдрүүрээс хүлээн авсан тоон дохионд дараах боловсруулалтыг хийнэ. Үүнд:

1. Шуугиан таних – Өгөгдөл нь тодорхой давтамжтай байх учир шуугианыг хугацааны график дээрх зэргэлдээ 3 утгын үүсгэх өнцөг, болон мэдрүүрийн хэмжих хязгаарын утгыг ашиглан мэдэж болно. Хэрэв зэргэлдээ 3 дохио нь A, O, B бол

$$\vec{a} = \overrightarrow{OA}, \quad \vec{b} = \overrightarrow{OB}, \quad \alpha = \cos^{-1} \frac{\vec{a} \cdot \vec{b}}{|\vec{a}| \cdot |\vec{b}|} \quad (1)$$

Хэрэв $\alpha < \alpha_{min}$ бол шуугиан (Spike noise) байх магадлалтай байна.

Хэрэв $|\vec{a}| \geq l_{max}, |\vec{b}| \geq l_{max}$ бол мэдрүүр нь боломжит хамгийн их утгаа авсан эсвэл бодит хөдөлгөөн нь хэмжүүрийн хязгаараас давсан байна.

2. Шуугиан шүүх – Шуугианы далайц нь харьцангуй сул бол арифметик дунжийн (Moving Average) шүүлтүүр ашиглаж болно.

$$MA = \frac{(A+O+B)}{3} \quad (2)$$

Шуугианы далайц харьцангуй өндөр бол хэт хазайлттай дохиог интерполяцийн аргаар байгуулсан функцийг тусламжтай засаж болно. Үүний тулд Cubic spline [10] интерполяцийг ашиглав. Cubic spline нь өгөгдсөн цэгүүдийг дайран өнгөрөх куб тэгшитгэл байгуулах замаар дундын цэгүүд болон тодорхойгүй эсвэл хэт хазайлттай цэгүүдийг хазайлт багатай (муруйн мөлгөр байдлыг алдагдуулахгүйгээр) цэгээр нөхөн орлуулна.

Өгөгдсөн n цэг $(x_1, y_1), (x_2, y_2), \dots, (x_n, y_n)$ бол интервал бүр дээрх Cubic spline функцүүд нь:

$$S_1(x) = y_1 + b_1(x - x_1) + c_1(x - x_1)^2 + d_1(x - x_1)^3, \quad x \in [x_1, x_2]$$

$$S_2(x) = y_2 + b_2(x - x_2) + c_2(x - x_2)^2 + d_2(x - x_2)^3, \quad x \in [x_2, x_3]$$

...

$$S_{n-1}(x) = y_{n-1} + b_{n-1}(x - x_{n-1}) + c_{n-1}(x - x_{n-1})^2 + d_{n-1}(x - x_{n-1})^3, \quad x \in [x_{n-1}, x_n] \quad (3)$$

байна.

Интерполяцийн нөхцөлийн дагуу функцүүд нь дараах шаардлагыг хангана:

$$S_i(x_i) = y_i, \quad i = 1, \dots, n - 1$$

$$S_{n-1}(x_n) = y_n$$

$$S_i(x_{i+1}) = S_{i+1}(x_{i+1}) = y_{i+1}, \quad i = 1, \dots, n - 2 \quad (4)$$

Функцүүдийн муруй нь мөлгөр (smoothness) байхын тулд нэг ба хоёрдугаар эрэмбийн уламжлалууд нь дараах шаардлагыг хангана:

$$S'_i(x_{i+1}) = S'_{i+1}(x_{i+1}), \quad i = 1, \dots, n - 2$$

$$S''_i(x_{i+1}) = S''_{i+1}(x_{i+1}), \quad i = 1, \dots, n - 2 \quad (5)$$

Нэмэлт нөхцөл (Natural Spline):

$$S''_1(x_1) = 0, \quad S''_{n-1}(x_n) = 0 \quad (6)$$

3. Цохиурын бэлтгэх байрлал (address) - г таних – Бэлтгэх байрлал нь мэдрүүр хөдөлгөөнгүй эсвэл маш бага хөдөлгөөнтэй бөгөөд цохиурын иш нь хүндийн хүчний векторт тодорхой заасан өнцгөөр налсан байх нөхцлөөр тодорхойлогдоно.

$$gyro_{magn} = \sqrt{gyro_x^2 + gyro_y^2 + gyro_z^2};$$

$$accl_{magn} = \sqrt{accl_x^2 + accl_y^2 + accl_z^2};$$

$$accl_{z,norm} = \frac{accl_z}{accl_{magn}};$$

$$\varphi = \cos^{-1}(accl_{z,norm}); \quad (7)$$


Хэрэв $gyro_{min} \leq gyro_{magn} \leq gyro_{max}$ ба $Address_{min} \leq \varphi \leq Address_{max}$ нөхцлийг хангаж байвал цохиур нь бэлтгэх байдалд байна гэж үзнэ.

Бэлтгэх байрлалын тайван нөхцөлд байгаа хурдатгал хэмжүүрийг ашиглан биеийн (body) координатын систем дэх мэдрүүрийн хазайлт (inclination) буюу Эйлерийн өнцгүүдийг [11] дараах байдлаар тодорхойлж болно (Зураг 4).

$$\theta = \tan^{-1} \frac{accl_x}{\sqrt{accl_y^2 + accl_z^2}}$$

$$\psi = \tan^{-1} \frac{accl_y}{\sqrt{accl_x^2 + accl_z^2}}$$

$$\phi = \tan^{-1} \frac{\sqrt{accl_x^2 + accl_y^2}}{accl_z} \quad (8)$$



Зураг 4. Хурдатгал хэмжигчийн хазайлтын өнцөг (Эйлерийн өнцөг)

2.3 Цохиурын савалт таних

Цохиурын савалтыг гурван хэмжээст огторгуйд бэхлэгдсэн цэгээс ойролцоогоор тогтмол зайд (тоглогчийн цээж ба гарын сарвуу хүртэлх зай) эргэлдэх хөдөлгөөн хийж байгаа биет (мэдрүүр) гэж төсөөлж болно. Савалт танихдаа мэдрүүрийн эргэлдэх хөдөлгөөний траекторг тулгуурлах учир кватернион (quaternion) тооцоолол ашиглав. Цохиурын савалт таних алгоритм:

1. Цохиурын бэлтгэх байрлалын Эйлерийн өнцгүүдийг кватернионд хувиргаж анхны төлөвийн векторыг тодорхойлно.
2. Цохиурыг савах үеийн гироскоп ба хурдатгал хэмжигчийн өгөгдлийг цуглуулан анхны төлөвт орших векторыг эргүүлэх кватернионы олонлогийг Мадвикийн шүүлтүүр (Madgwick Filter)[12] ашиглан үүсгэнэ.
3. Кватернионуудыг чиглэлийн косинус (direction cosine)-д хувирган савалтын траекторыг тодорхойлно.
4. Чиглэлийн косинусаар илэрхийлэгдэх траекторыг гольфын савалтын ерөнхий хэв загвартай харьцуулан танилт хийнэ.

1843 онд математикч William Rowan Hamilton комплекс тоог өргөтгөн hyper-complex number болох кватернион (quaternion)-г [13] нээжээ. Кватернион нь гурван хэмжээст огторгуй дахь хоёр векторын харьцааг илэрхийлдэг.

Кватернионы ерөнхий хэлбэр[13]:

$$q = q_0 + \mathbf{q} = q_0 + iq_1 + jq_2 + kq_3$$

$$i^2 = j^2 = k^2 = ijk = -1, \quad ij = k = -ji,$$

$$jk = i = -kj, \quad ki = j = -ik \quad (9)$$

Эйлерийн өнцгийг Кватернионд хөрвүүлэх[13]:

$$\begin{aligned} q_0 &= \cos \frac{\psi}{2} \cos \frac{\theta}{2} \cos \frac{\phi}{2} + \sin \frac{\psi}{2} \sin \frac{\theta}{2} \sin \frac{\phi}{2} \\ q_1 &= \cos \frac{\psi}{2} \cos \frac{\theta}{2} \sin \frac{\phi}{2} - \sin \frac{\psi}{2} \sin \frac{\theta}{2} \cos \frac{\phi}{2} \\ q_2 &= \cos \frac{\psi}{2} \sin \frac{\theta}{2} \cos \frac{\phi}{2} + \sin \frac{\psi}{2} \cos \frac{\theta}{2} \sin \frac{\phi}{2} \\ q_3 &= \sin \frac{\psi}{2} \cos \frac{\theta}{2} \cos \frac{\phi}{2} - \cos \frac{\psi}{2} \sin \frac{\theta}{2} \sin \frac{\phi}{2} \end{aligned} \quad (10)$$

Гурван хэмжээст огторгуй дахь векторыг кватернионоор эргүүлэх[13]:

Вектор $\mathbf{v} \in R^3$ ба $v = 0 + \mathbf{v}$ гэсэн цэвэр хуурмаг кватернион гэж үзье. Векторыг өгөгдсөн $q = q_0 + \mathbf{q}$ кватернионоор эргүүлэх эргүүлэлэлт нь

$$\begin{aligned} \mathbf{w} &= \mathbf{q}\mathbf{v}\mathbf{q}^* = (q_0 + \mathbf{q})(0 + \mathbf{v})(q_0 - \mathbf{q}) = \\ &= (2q_0^2 - 1)\mathbf{v} + 2(\mathbf{q} \cdot \mathbf{v})\mathbf{q} + 2q_0(\mathbf{q} \times \mathbf{v}) \end{aligned} \quad (11)$$

буюу матриц хэлбэрээр бичвэл

$$\begin{aligned} \begin{bmatrix} w_1 \\ w_2 \\ w_3 \end{bmatrix} &= \begin{bmatrix} m_{11} & m_{12} & m_{13} \\ m_{21} & m_{22} & m_{23} \\ m_{31} & m_{32} & m_{33} \end{bmatrix} \begin{bmatrix} v_1 \\ v_2 \\ v_3 \end{bmatrix} \\ m_{11} &= 2q_0^2 - 1 + 2q_1^2 \\ m_{12} &= 2q_1q_2 - 2q_0q_3 \\ m_{13} &= 2q_1q_3 + 2q_0q_2 \\ m_{21} &= 2q_1q_2 + 2q_0q_3 \\ m_{22} &= 2q_0^2 - 1 + 2q_2^2 \\ m_{23} &= 2q_2q_3 - 2q_0q_1 \\ m_{31} &= 2q_1q_3 - 2q_0q_2 \\ m_{32} &= 2q_2q_3 + 2q_0q_1 \\ m_{33} &= 2q_0^2 - 1 + 2q_3^2 \end{aligned} \quad (12)$$

болно.

2.4 Цохиурын савалтанд анализ хийх


Мэдрүүрийн хөдөлгөөн нь цохиурын савалтын хэв загвартай гэж танигдсан бол дараах үндсэн үзүүлэлтүүдийг тооцоолно.

1. Club head speed – бөмбөгтэй харьцах байрлал дахь гироскопын магнитуд утгыг бодит цохиурын хурдад хөрвүүлэх полиномиаль

$$f(x) = ax^3 + bx^2 + cx^1 + d \quad (13)$$


функциыг ашиглан тодорхойлно.

2. Swing path – бөмбөг хөөргөх зорилтот чиглэлийн вектор ба бөмбөг цохих үеийн савалтын траекторт шүргэгч вектор хоорондын өнцгөөр тодорхойлно (Зураг 5).



Зураг 5. Swing path

3. Face angle – бөмбөгтэй харьцах байрлал дахь цохиурын толгойн нүүрний хавтгайд нормаль вектор ба зорилтот чиглэлийн вектор хоорондын өнцгөөр тодорхойлно (Зураг 6).
4. Attack angle - бөмбөгтэй харьцах байрлал дахь цохиурын иштэй ижил чигтэй вектор ба хүндийн хүчний вектор хоорондын өнцгөөр тодорхойлно (Зураг 6).




Зураг 6. Face and attack angle

5. Хугацааны харьцаа (Tempo = Back swing / Down swing)

3. Системийн дизайн, туршилт

3.1 Төхөөрөмжийн бүтэц

Судалгааны ажилд InvenSense компанийн MP9250 multi-chip module (MCM) [8,9], Dialog Semiconductor компанийн DA14580 System on Chip (SoC) [7] ашиглан гольфын цохиурын ишний төгсгөлд бэхлэгдэх мэдрүүрийн төхөөрөмж зохион бүтээж туршив (Зураг 7, Хүснэгт 3).



Зураг 7. Хөдөлгөөний мэдрүүр болон төхөөрөмжийн ерөнхий бүтэц


Хүснэгт 3. Хөдөлгөөн мэдрүүрийн тохируулга

Тайлбар	Тохируулга
Мэдрүүрийг туршилтанд ашиглахаас өмнө calibration хийж үйлдвэрлэлийн хазайлтыг засварласан.	
Мэдрүүрийн өгөгдөл дамжуулах давтамж	100Гц (10мсек)
Гироскопын хэмжилт хязгаар (Gyroscope full-scale range)	±2000 °/сек (өнцөг/секунд)
Хурдатгал хэмжигчийн хэмжилт хязгаар (Accelerometer full-scale range)	±16g

Төхөөрөмжийн DA14580 SoC чип дээрх Firmware программ нь гироскоп, хурдатгал хэмжигчийн өгөгдлийн багцыг Bluetooth холболтоор хүлээн авагч төхөөрөмжид дамжуулна.

Хүлээн авагч нь Bluetooth холболтыг дэмжих ухаалаг төхөөрөмж, компьютер байх ба цохиурын савалтад анализ хийх API (application programming interface)-г интеграци хийж нэгтгэсэн симуляци программыг ажиллуулна.

Туршилтанд ашигласан төхөөрөмжийн printed circuit board (PCB) түүнийг цохиурт бэхлэх байдлыг зураг 8-д үзүүлэв.



Зураг 8. Төхөөрөмжийн PCB түүнийг цохиурын ишинд бэхэлсэн байдал

3.2 Туршилт

Туршилтанд бодит цохиурыг орлох сургалтын зориулттай цохиур ашиглаж савалтын дараах хэлбэрүүдийг хийж туршсан.

1. Full swing – Хамгийн их хурд, хүчтэй савах;
2. Half swing – Хүчтэй савалтаас 10%-30% бага байхаар савах;
3. Approach swing – Хүчтэй савалтаас 30% - 80% бага байхаар савах;
4. Chip shot – Хүчтэй савалтаас 80% - 95% бага байхаар савах;
5. Putting – Бөмбөгийг 0.1-25 метр зайд өнхрүүлэх хэмжээний савалтууд

Туршилтын үр дүнг тайлбарлах зорилгоор Full swing-н анализыг жишээ болгон авав.

A. Өгөгдөл цуглуулалт


Цохиурын савалтын үед хөдөлгөөн мэдрүүрээс цуглуулсан гироскоп, хурдатгал хэмжигчийн гаралтын өгөгдлийг Зураг 9-д үзүүлэв.


ID	ACCEL HIGH, LOW BYTE			GYRO HIGH, LOW BYTE		
	AX	AY	AZ	GX	GY	GZ
0	009E	FEEE	02E7	01A5	FF85	F7E9
1	0095	FEDF	02E1	01B2	FFBD	F901
2	007E	FED9	02FD	01B7	FFEB	FA1C
3	0068	FECF	0307	01BF	0005	FB03
4	0050	FECD	032C	01C3	0021	FBA2
5	0030	FED8	0349	01C5	0037	FBE5
...

Зураг 9. Цуглуулсан өгөгдөл

B. Дохио боловсруулах

Мэдрүүрийн өгөгдлөөс шуугиан таниж, шүүлт (Moving Average, Cubic Spline) хийсэн үр дүнг зураг 10-д графикаар харуулав.






Зураг 10. Гирископын өгөгдөл (a), Moving Average ба Cubic Spline шуугианы шүүлт (b)

C. Савалт таних

Цохиурын савалтын траекторыг чиглэлийн косинус (direction cosine)-р илэрхийлсэн гурван хэмжээст огторгуй дахь графикийг зураг 11-т үзүүлэв.




Зураг 11. Цохиурын савалтын траектор

D. Савалтанд анализ хийх

1. Club head speed


Гирископын магнитуд утгын графикийг зураг 12-т үзүүлэв. Туршилтын савалтын үед тодорхойлогдсон гирископын магнитуд их утга $\approx 33.4\text{dps}$ -г Driver цохиурын Club head speed-д полиномиал ашиглан хувиргавал $\approx 42\text{м/с}$ болно.



Зураг 12. Гирскопын магнитуд утга

2. Swing path


Бөмбөг хөөргөх зорилтот чиглэлийн вектор ба траекторын шүргэгч векторын хоорондын өнцгийн графیکیг зураг 13-т үзүүлэв. Туршилтын савалтын Swing path ≈ 4.50 байна.



Зураг 13. Зорилтот чиглэлийн болон траекторын вектор

3. Face angle


Бөмбөг хөөргөх зорилтот чиглэлийн вектор ба цохиурын толгойн нүүрний хавтгайд нормаль вектор хоорондын өнцгийн графیکیг зураг 14-т үзүүлэв. Туршилтын савалтын Face angle ≈ 3.70 байна.



Зураг 14. Зорилтот чиглэлийн болон цохиурын нүүрний нормаль вектор

4. Attack angle

Бөмбөгтэй харьцах байрлал дахь цохиурын иштэй ижил чигтэй вектор ба хүндийн хүчний векторын графیکیг зураг 15-д үзүүлэв. Туршилтын савалтын Attack angle ≈ -2.00 байна.



Зураг 15. Хүндийн хүчний болон цохиурын ишний вектор

5. Tempo = Back swing / Down swing

Туршилтын савалтын Tempo ≈ 3.0 байна.

Төхөөрөмжийн нарийвчлалыг тооцоходоо доплер эффектийн мэдрүүр ашигласан төхөөрөмж TrackMan-ны PGA TOUR статистик дундаж утгыг ашигласан (Зураг 16).

	Club Speed (mph)	Attack Angle (deg)	Ball Speed (mph)	Smash Factor	Launch Ang. (deg)	Spin Rate (rpm)	Max Height (yds)	Land Angle (deg)	Carry (yds)
Driver	113	-1.3°	167	1.48	10.9°	2686	32	38°	275

Зураг 16. TrackMan статистик

Дүгнэлт

Гольфын цохиурын савалтанд анализ хийх туршилтанд дараах шинэлэг аргуудыг ашигласан. Үүнд:

- Мэдрүүрийг ХҮ хавтгайд дурын байрлалд бэхэлж цохиурын савалтын хөдөлгөөнийг тодорхойлж анализ хийсэн
- Мэдрүүрийн өгөгдлийг савалтын хөдөлгөөнд хувиргах, танилт тооцооллыг өгөгдөл дамжуулалтын үед зэрэгцээ хийж анализын хугацааны хоцролыг багасгасан
- Firmware программ нь мэдрүүрийн өгөгдлийг дамжуулах энгийн үүрэгтэй болсноор өндөр үзүүлэлттэй удирдлагын модулын хэрэглээг багасгаж, эрчим хүчний хэрэглээг хэмнэсэн
- Мэдрүүрийн өгөгдлийг савалтын хөдөлгөөнд хувиргах, анализ хийх программыг C++ хэл дээр API загвараар хөгжүүлсэн учир төрөл бүрийн платформд нийцтэй (Windows, MacOS, Android, iOS), гуравдагч контент хөгжүүлэгч хялбар ашиглах, интеграци хийх боломжтой болгосон
- Туршилтын төхөөрөмжийг хөгжүүлж, цахим гольфын тоглоомын эхний загварыг гарган туршилтууд хийсэн.

Ном зүй

- [1] Patent Application Publication, Patent No.: US 7,022,026 B2.
- [2] Patent Application Publication, Patent No.: US 9,247,212 B2.
- [3] Patent Application Publication, Pub. No.: US 2006/02871 17 A1.
- [4] Warangkhan Kimpan, Natee Rientrakulchai and Wisan Tangwongcharoen “Pattern Analysis of Golf Swing using Motion Sensors”, International Conference, ICCEB-2013, Bangkok Thailand, Nov 23-24, pp. 44-48
- [5] Myeongsub Kim, Sukyung Park, “Golf Swing Segmentation from a Single IMU Using Machine Learning”, MDPI Journal of Sensors, Aug 10, 2020
- [6] Ho-Han Kim¹, Sung-Young Kim, “Implementation of Golf Swing Analysis System Based on Swing Trajectories Analysis”, Journal of JAITS, Vol. 9, No. 2, Dec 31, 2019, pp.65-74
- [7] Dialog Semiconductor, “DA14580 Bluetooth Low Energy 4.2 SoC Datasheet”, Revision 3.4, 09-Nov-2016.

- [8] InvenSense, “MPU-9250 Product Specification”, Revision: 1.1, 06/20/2016.
- [9] InvenSense, MPU-9250 Register Map and Descriptions”, Revision: 1.6, 01/07/2015.
- [10] Larry L. Schumaker, “Spline Functions: Basic Theory”, Third edition, Cambridge University Press, August 2007.
- [11] Analog Devices, “AN-1057 Application Note”, 2010.
- [12] Sebastian O.H. Madgwick, “An efficient orientation filter for inertial and inertial/magnetic sensor arrays”, Book, April 30, 2010
- [13] Jack B. Kuipers, “Quaternions and Rotation sequences”, Princeton University Press.

ETCP-20

УЛААНБААТАР ХОТЫН НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Б.Батсүрэн¹, Б.Золзаяа², З.Туяа³,
Б.Батсүрэн¹, МУИС АЖХГС², B.Batsuren@mnun.edu.mn
Б.Золзаяа² МУИС АЖХГС² Ba.Zolzaya@mnun.edu.mn
З.Туяа, Нью Урбанизм ХХК, Z.Tuya@newurbanizm.com*

Хураангуй

Манай оронд ногоон байгууламжийн нэгдсэн ангиллын талаар “Хот төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм”, “Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”, “Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын ТЭЗҮ”, “Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам” гэсэн 4 баримт бичигт тодорхойлсон ногоон байгууламжийн ангилал, хэмжээ, цэцэрлэгжих хувь нь өөр өөр байгаагаас харахад нэгдсэн ангилал шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэ нь цаашид тоон мэдээлэл гаргах суурь болж, улмаар Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, түүний өгөөжийг хэмжихэд нэн шаардлагатай юм. Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн асуудал нь Хот байгуулалтын тухай хуулиар зохицуулагдаж байгаа ч түүнийг байгуулах, ашиглалтыг бий болгох үйл явц нь Барилгын тухай хууль, Газрын тухай хуулиар зохицуулж байна. Түүнчлэн цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааны буюу модыг тарих, зөөвөрлөх, арчлах хамгаалах үйл ажиллагааны технологийн нийт 15 стандарт байдаг байна.

Хот байгуулалтын тухай хууль нь хот төлөвлөлтийн нормыг хангуулах бүхий л харилцааг зохицуулагдахад чиглэж байгаа ч одоогийн байдлаар эдгээр эрх зүйн болон техникийн бичиг баримтуудын зөрөөтэй байдлыг судаллаа.

Түлхүүр үг

Ногоон байгууламж, ногоон байгууламжийн бүртгэл, ногоон байгууламжийн ангилал

Үндэслэл

Ногоон байгууламжийг бий болгох чиглэлээр төрөөс болон хотын захиргаанаас олон ажил хийгдэж байгаа ч хотын захиргааны ашиглалтад байгаа төвийн хэдэн цэцэрлэгүүдэд арчилгаа, тордолгоо явагдаж, шинээр цэцэрлэгжсэн талбай нэмэгдүүлж чадахгүй байгаа билээ. Үүнд хотыг тохижуулж, цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж байгаа эрх зүйн орчин, бүтэц зохион байгуулалтын үйл ажиллагаа оновчтой бус байгаа нь нөлөөлж байна.

Орчин үеийн томоохон хотуудын хөгжлийн гол үзүүлэлтүүдийн нэг нь ногоон байгууламжийн эзлэх хувь байдаг билээ. Нийслэл Улаанбаатар хотын хувьд хүн амын тоонд харьцуулсан үзүүлэлтээр ногоон байгууламжийн хэмжээ нь шаардлагатай түвшингээс 10 дахин бага байна. Улаанбаатар хотын ногоон байгууламж байх газрын 11% -ийг гудамж зам дагуух ногоон байгууламж эзэлж байна.

Томоохон хот суурин газрууд шаардлагатай барилга орон сууц, зам талбайг барьж байгуулаад бусад хэсэгт нь ногоон байгууламж байгуулдаг. Эсвэл эко хавтангаар хучдаг туршлага ч байдаг. Харин Улаанбаатар хотын хувьд газар эзэмшигч ашиглагчдад цэцэрлэгжүүлэх үүрэг хариуцлага тодорхой байдаггүйгээс аль алиныг нь хангалттай хийдэггүй учир сул шороо ихтэй, үүнийг дагаад тоосжилт агаарын бохирдол ч мөн нэмэгддэг байна. Иймээс Улаанбаатар хотын ногоон байгууламжийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд юуны өмнө эрх зүйн орчныг сайжруулах шаардлага нь судалгааны ажлын үндэслэл болно.


Зорилго, зорилт

Хотын ногоон байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэн, сайжруулах ажлын хүрээнд юуны өмнө нийслэлийн төрийн өмчийн болон хувийн хэвшлийн байгууллагууд буюу газар ашиглагч эзэмшигч өмчлөгчдөд оноосон үүрэг хариуцлагын системийг хөгжүүлэх шаардлагын үүднээс Улаанбаатар хотын ногоон байгууламжийн эрх зүйн орчны талаар судлах, нийслэлийн ногоон байгууламжийн одоогийн байдлыг судлаж орон зайн зураг гаргах зорилгоор дараах зорилтуудыг тавьсан. Үүнд:

1. Эрх зүйн баримт бичгүүдийн дагуу гарсан ногоон байгууламжийн ангилал, бүртгэлийг судлах
2. Баримт бичгүүдэд ногоон байгууламжийн заагдсан хувь, стандартын хэмжээг харьцуулах
3. Нийслэлийн ногоон байгууламжийн байршилыг сансрын зураг ашиглан зураглах, тоон мэдээг боловсруулах


Судалгааны объект

Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хязгаарыг Нийслэлийн засаг даргын 2017 он 1-р сарын 9-ний өдрийн А/18-р захирамжаар баталгаажуулсан байна. Батлагдсан хилийн цэсийг цаашид үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2013 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгоолоор батлагдсан Улаанбаатар хотын суурьшлын бүсийн хилийн цэсээр судалгааны объектийг сонгож авлаа.



Зураг 1. Судалгааны бүсийн хил хязгаар

Судалгааны арга зүй



Судлагдсан байдал

Сүүлийн жилүүдэд Нийслэлийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр цөөнгүй судалгаа бодолгын баримт бичгүүд боловсруулагдаж байна. Тухайлбал:

1. “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр - Хотын тоос, тортог, хог хаягдлыг багасгах, мод, зүлэг зэрэг ногоон байгууламжийн нэг хүнд ногдох хэмжээг 20 м² хүртэл нэмэгдүүлэх /4.1.19/;
2. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага- 2.3.5. Хотын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж - Хотын ногоон байгууламжийн хүртээмжийг дээшлүүлэн, сайжруулах ажлын хүрээнд гол төлөв нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийг түлхүү байгуулах ба хуучныг сэргээн засварлах замаар хотын ногоон байгууламжийн сүлжээг бий болгон хөгжүүлж, нэг хүнд ногдох цэцэрлэгжсэн талбайг 2020 онд 15-20 м²-д тус тус хүргэнэ.
3. МУ-ын ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан холбогдох заалт

Судалгааны үр дүн

Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн одоогийн нөхцөл байдал

Хууль эрх зүйн байдал

Хотын ногоон орчныг бүрдүүлэхэд төрийн бодлого, зохицуулалтын өөрчлөлтийг хийх шаардлагатай байгааг өнөөгийн сошиал сүлжээнд болж буй нийгмийн харилцаанаас харж болно.

Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн асуудал нь Хот байгуулалтын тухай хуулиар зохицуулагдаж байгаа ч түүнийг байгуулах, ашиглалтыг бий болгох үйл явц нь Барилгын тухай хууль, Газрын тухай хуулиар зохицуулж байна. Түүнчлэн цэцэрлэгжүүлэх үйл ажиллагааны буюу мод тарих, зөөвөрлөх, арчлах хамгаалах үйл ажиллагааны технологийн нийт 15 стандарт байна. Мөн эрх зүйн хэд хэдэн бичиг арифт байгаа ч ногоон байгууламжийг бүртгэх тоолох эрх зүйн баримт бичиг байхгүй байна.

Хот байгуулалтын тухай хууль нь хот төлөвлөлтийн нормыг хангуулах бүхий л харилцааг зохицуулагдахад чиглэж байгаа ч одоогийн байдлаар эдгээр эрх зүйн болон техникийн бичиг баримтуудад харилцан зөрчилдөөнтэй заалтууд байсаар байна. Энэ нь эдгээр хуулийн хэрэгжилтийг хангуулах эрх бүхий байгууллагуудад хүндрэл үзүүлж байна. Эдгээр бичиг баримтаас зөрчилдөж буй дараах асуудлууд байна. Үүнд:

Ногоон байгууламж, нийтийн зориулалттай газрын бүс, ангилал

1. Хот байгуулалтын тухай хуулийн 13 дугаар зүйлд Хот тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэлийг хот байгуулалтын норм ба дүрэм, журмын дагуу төлөвлөж тогтооно гээд 13.1.4 ногоон байгууламж, амралт, аялал жуулчлалын бүс гэж тусдаа бүс байхаар оруулсан байна.

Гэтэл Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-02-04-ийн 4-ийн 1-д Нийтийн, хязгаарлагдмал, тусгай гэж зориулалтаар ангилсан байна.

Өөрөөр хэлбэл төлөвлөлтийн хувьд нийтийн хэрэгцээний болон тусгай зориулалтын зарим дэд ангилал нь хот байгуулалтын хуульд заасантай адил газар ашиглалтын хувьд тусдаа ногоон байгууламжийн бүс байж болох хэдий ч хязгаарлагдмал зориулалттай ногоон байгууламжийн бүсэд оруулах эсэх нь тодорхойгүй байна.

Хот байгуулалтын тухай хуулийн дагуу тусдаа бүс байх нийтийн зориулалттай ногоон бүс нь Төрийн өмчийн тухай хуулийн 4 зүйлийн 2.1-д иргэдэд өмчлүүлснээс бусад газар, 2.8-д хуулиар нийтийн зориулалтаар ашиглахаар тогтоосон бусад эд хөрөнгө гэсний дагуу төрийн нийтийн өмч юм. Мөн уг 4-р зүйлийн 2.3-т Төрийн нийтийн зориулалттай өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлэх ба үүнтэй холбогдон үүсэх харилцаанд энэ хууль үйлчлэхгүй гэжээ.

Ногоон байгууламжийн ангилал

Улаанбаатар хотын хилийн цэс батлагдсан ч одоог хүртэл хотын мэдээлэл нь батлагдсан хилийн цэсээр статистикийн мэдээлэл ангилагдаж гардаггүй байна.

Судалгааг боловсруулахад хийгдсэн албан ёсны эдгээр мэдээллээс харахад ногоон байгууламжийн ангилал эцэслэн тодорхойлогдоогүйгээс тоон мэдээллүүд эх үүсвэрээс хамаарч өөр өөр гарсан байна. Тухайлбал:

- Эрүүл аюулгүй байдлын индексийн 2015 оны үзүүлэлтээр нэг хүнд 0,2 м² ногоон байгууламж ногдож байна.
- Нийслэлийн 2016 оны статистикийн мэдээллээр нийслэлд 7450,7 га газар цэцэрлэгжсэн бөгөөд үүний 4315,6 га газар нь зүлэгжсэн талбай байдаг байна.
- Нийслэлийн захирагчийн ажлын албанаас 2017 онд хийсэн төвийн 6 дүүргийн 143 гудамж талбайн болон томоохон цэцэрлэгт хүрээлэнгийн тооллогоор нийт 121 га талбайг цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн гэсэн тоо өөр хоорондоо зөрүүтэй баримтууд байна. Учир нь Улаанбаатар хот дахь ногоон байгууламжийн тухай баримт бичгүүд нь хоорондоо ангилал, бүртгэлийн хувьд нилээд ялгаатай байгаа юм.

Нийслэлийн ногоон байгууламжийн ангиллыг дараах баримт бичгүүдэд ангилан бичсэн байна. Үүнд:

1. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-03
2. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө
3. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам
4. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам

Эдгээр бичиг баримтанд ногоон байгууламжийн хэд хэдэн ангилал гарсан байна.

Хүснэгт 1. Ногоон байгууламжийн ангиллын зөрүү

Баримт бичгийн нэр	Ангилал				
Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-03	Нийтийн хэрэгцээн ий цэцэрлэгжүүлэлтэд	Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтэд	Тусгай зориулалтын цэцэрлэгжүүлэлтэд		
Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө	Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай	Хязгаарлагдмал зориулалтын ногоон байгууламж		Гудамж, авто зам дагуух ногоон байгууламж	
Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам	Нийтийн эзэмшлийн	Хязгаарлагдмал /байгууллага орчмын/	Тусгай зориулалтын болон Туул, Сэлбэ, Дунд голын дагуух хотын барилгажсан хэсэгт хамаарах зурвас		Орон сууцны хорооллын
Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл	I ангилал – Төв, хот суурин		I ангилал - Эргийн		III ангилал – Гэр хорооллын

Эх сурвалж: Зохиогч

1. Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04

Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-д Хот тосгоны цэцэрлэгжүүлэлтийг төлөвлөхдөө нийтийн хэрэгцээний, хязгаарлагдамал зориулалттай, тусгай зориулалттай гэсэн ангиллыг баримтална гэж тусгасан байдаг. Үүнд:

- Нийтийн хэрэгцээний цэцэрлэгжүүлэлтэд хот тосгоны нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт төгөл, орон сууц, үйлдвэрийн хорооллын чанартай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай, цэцэрлэгт гудамж, модот гудамж болон зүлэгжүүлсэн гудамж хамрагдана.
- Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтэд сургууль, цэцэрлэг, ясли, эмнэлгийн байгууллага, авто болон төмөр замын барилга байгууламжийн хамгаалалтын зурвас, иргэн, олон нийтийн барилгын эдэлбэр газрын цэцэрлэгжүүлэлт орно.
- Тусгай зориулалтын цэцэрлэгжүүлэлтэд ботаник цэцэрлэг, орон сууцны хорооллыг үйлдвэрийн газраас тусгаарласан хамгаалалтын бүс, гудамж замын цэцэрлэгжүүлэлт, гуу жалга зэрэг хөрсний эвдрэл, элсний нүүлт зэргээс хамгаалсан ногоон суулгамал болон гол горхи, нуур цөөрмийн эргийн хамгаалалтын зурвас, хүчтэй салхи, элс, цасны хунгарлалтаас хамгаалсан ногоон байгууламж орно гэж заасан байна.

Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө

Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд засаг захиргааны нэгжид тулгуурлан 2030 он гэхэд ногоон байгууламж болгосон байх талбайн 5 ангиллыг санал болгосон. Үүнд:

1. Нийтийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай
 - 1.1 Хотын цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгүүд
 - 1.2 Дүүргийн цэцэрлэг, цэцэрлэгт хүрээлэнгүүд
2. Гудамж, авто зам дагуух ногоон байгууламж
3. Хязгаарлагдмал зориулалтын ногоон байгууламж

Түүнчлэн Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө нь ногоон байгууламжийг үүрэг зориулалтаар нь

- ✓ Нийтийн зориулалттай ногоон байгууламж,
- ✓ Хязгаарлагдмал үүрэг зориулалт бүхий ногоон байгууламж,
- ✓ Тусгай үүрэг, зориулалт бүхий ногоон байгууламж,
- ✓ Ногоон байгаль гэж ангилжээ. Эдгээр үүрэг, зориулалт нь яваандаа өөрчлөгдөх хандлагатай байна.

2. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам

Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журамд ногоон байгууламжийг үүрэг зориулалтаар нь

- ✓ Нийтийн эзэмшлийн
- ✓ Хязгаарлагдмал /байгууллага орчмын/
- ✓ Орон сууцны хорооллын
- ✓ Тусгай зориулалтын болон Туул, Сэлбэ, Дунд голын дагуух хотын барилгажсан хэсэгт хамаарах зурвас бүс гэж ангилна.

3. Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл

ТЭЗҮ боловсруулах ажлын хүрээнд Тасганы овоо цэцэрлэгт хүрээлэнгийн төслийг хэрэгжүүлсэн туршлагаас харахад том, жижиг талбайг зааглах тохиромжит босго хэмжээ нь 5 га байхаар байна. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн салбарын өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзвэл 5 га-аас том талбайд ногоон бүтээн байгуулалт хийнэ гэдэг нь тусгай боловсруулалт, бэлтгэл ажил, төсөлд суурилсан удирдлагын арга хандлага шаардсан ажил болох нь хэд хэдэн жишээнээс харагдсан.

Энэхүү тайлангаар талбайн босго хэмжээг 5 га гэж үзэн нийтийн зориулалттай ногоон байгууламжийг 3 ангилсан ба ангилал тус бүрийн онцлог шинжийг доорх хүснэгтэд үзүүлэв. Жижиг хэмжээтэй ногоон байгууламжийг хөгжүүлэх төлөвлөгөө (ЖХНБХТ) нь барилгажсан талбайд (Төрийн ордны хойд цэцэрлэг, орон сууцны дундах хүүхдийн тоглоомын талбай) байрлах хязгаарлагдмал байрлал болон хэмжээнээсээ шалтгаалаад үзүүлэх үйлчилгээ нь ч мөн хязгаарлагдмал байдаг ногоон байгууламжид хамаарна. Сийрэгдүү байгууламжит орчинд (гэр хороолол: иргэдийн нүүлгэн шилжүүлэх хөтөлбөр, ҮЦХ: ямар ч барилга байгууламжгүй задгай талбай) олон төрлийн үйлчилгээ үзүүлэх боломж бүхий II болон III ангиллын ногоон байгууламжид төсөлд суурилсан

удирдлагын арга хандлагыг нэвтрүүлэхийг зөвлөсөн байна.

Хүснэгт 2. Ногоон байгууламжид санал болгосон үндсэн ангилал

Ангилал	Байршил	Хэмжээ
I ангилал – Төв, хот суурин	Бүрэн тохижилт үйлчилгээ бүхий хотын төв	Ямар ч хэмжээтэй байж болно. (Өнөөдрийн байдлаар)
<i>Ia ангилал</i>		< 5 га
<i>Iб ангилал</i>		> 5 га
II ангилал - Эргийн	Эрэг дагуух талбай / гэр хороолол байхгүй	> 5 га
<i>IIa ангилал</i>	<i>Туул гол</i>	
<i>IIб ангилал</i>	<i>Сэлбэ гол</i>	
<i>IIв ангилал</i>	<i>Улиастай гол</i>	
III ангилал –Гэр хороолол	Гэр хороолол / үржил шимгүй, эргийн дагуух талбай	Ямар ч хэмжээтэй байж болно.
<i>IIIa ангилал</i>		< 5 га
<i>IIIб ангилал</i>		> 5 га

Эх үүсвэр: ДБ. Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл 2015.

Нийтийн эзэмшлийн эдэлбэр, ногоон байгууламжийн бүртгэлийн асуудал:

Барилга хот байгуулалтын яамны сайдын 2016 онд батлагдсан **Кадастрын зураглал үйлдэх технологийн аргачлалын 7.2-т** Нэгж талбарын газрын хилийн шугамыг газарт тэмдэглэхдээ дараах баримт материалуудыг үндэслэнэ гэсэн байна. Үүнд:

- Газар өмчлөгч Монгол улсын иргэн, аж ахуйн нэгж, газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, газар ашиглагч гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын иргэн, харьяалалгүй хүний газар олголтын захирамж;
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ;
- Газар эзэмших, ашиглах гэрээ;
- Баталгаат хэмжээг тогтоосон акт.

Гэтэл төрийн нийтийн өмчийн бүртгэлийн систем байхгүй тул ногоон байгууламжийг кадастрт бүртгэх боломжгүй байдал үүсчихсэн байгаа бөгөөд одоогоор Улаанбаатар хотод ногоон байгууламжийг бүртгэх кадастрын бүртгэл байхгүй байна.

Ногоон байгууламжийн эдэлбэр газарт эзлэх хувь

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04 нь монгол улсын нутаг дэвсгэр дээрх хот суурин орон зайн стандарт юм. Энэ орчныг бүрдүүлэх эрх зүйн баримт бичиг нь Хот байгуулалтын тухай хууль бол газрын харилцааны асуудал нь Газрын тухай хуулиар, барилга байгууламжийн чанарын асуудал нь Барилгын тухай хуулиар зохицуулагддаг билээ.

Хүснэгт 3. Эрх зүйн баримт бичгүүдэд ногоон байгууламжийн заагдсан хувь хэмжээ

№	Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04	Хот байгуулалтын тухай хуульд	Барилгын тухай хуульд	Газрын тухай хууль
1	Хот суурины барилгажсан нийт талбайн 40%-иас багагүй	Төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн 30-аас доошгүй хувь	Барилга байгууламжийн гадна тохижилтын талбай, ногоон байгууламж хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт заасан хэмжээнээс багагүй байна	Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг
2	Орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбай 6м ² -с багагүй	Барилгажих талбай нь тухайн газрын 70 хувиас илүүгүй		

Эдгээр хууль эрхзүйн баримт бичгүүдэд хотын ногоон байгууламжийн асуудал дараах байдлаар зөрчилдөж байна. Үүнд:

Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04-д ногоон байгууламж, цэцэрлэгжсэн талбайн хэд хэдэн заалт байдаг. Үүнд:

- I) 4.2-т Хот суурины барилгажсан нийт талбайн **40%**-иас багагүй нь, сууцны хорооллын барилгажсан нутаг дэвсгэрийн **25%**-иас багагүй нь цэцэрлэгжүүлсэн нутаг дэвсгэр байна гэж заасан байдаг;
- II) 2.10-т Орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбай 6м^2 -с багагүй байна. Энэ тооцоонд ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллагын барилгын эдэлбэр газрын талбай хамаарахгүй тайлбараар мөн Орон сууцны хорооллын ногоон бүсэд амралтын, хүүхдийн тоглоомын, явган зам талбайг оруулан тооцох ба нийт эзлэх талбай нь ногоон бүсийн талбайн 30 хувиас ихгүй байна.

Судалгаанд ашигласан ангилал, одоогийн байдал

Албан ёсны нэгдсэн ангилал гараагүй тул World view2 сансрын зураг, Нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газрын нээлттэй эх үүсвэрээс газрын мэдээллийн систем програм хангамж болох /ArcGIS/ ашиглаж тоолсон нийт 10844.69 га газрын 3578 нэгж талбарын талбайн зориулалт, ашиглалтын хэлбэр, байршлыг харгалзан дээрх бичиг баримтуудад ногоон байгууламжийг ангилсан байдлыг харгалзан Хот, тосгон төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм БХБД 30-01-04-д тогтоосон хот тосгоны цэцэрлэгжүүлэлтийн 3 ангилалд суурьлан дэд ангилалуудыг тодорхойлж одоогийн байдлын тоон мэдээллийг боловсрууллаа. Хүснэгт 4.

Түүнчлэн Улаанбаатар хотын бүх газар нутаг бүрэн дүүрэн тохижоогүй тул цэцэрлэгжсэн болон цаашид цэцэрлэгжүүлж, тохижуулах боломжтой гэж газар нутгийг ангилсаны үндсэн дээр хотын нэг хүнд ногоон байгууламжийн хэмжээг тодорхойллоо.

Хүснэгт 4. Улаанбаатар хотын одоогийн байгууламжийн хэмжээ, ангилалаар

No	Ангилал	Нийт		Одоогийн байдлаар цэцэрлэгжсэн талбай /га/	
		Талбайн хэмжээ /га/	Талбарын тоо /ш/	Талбайн хэмжээ /га/	Талбарын тоо /ш/
I	НИЙТИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ	8382.55	2078.00	242.55	1807.00
1.1	Гудамж, зам талбай	96.87	1158	93	1103
1.2	Орон сууцны хороолол	126.47	779	115.13	703
1.3	Олон нийтийн зориулалттай бүс	986.75	4.00	33.98	1.00
1.4	Байгалийн ногоон бүс	7172.46	137.00	0.00	0.00
II	ХЯЗГААРЛАГДМАЛ ЗОРИУЛАЛТТАЙ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ	1131.01	1370.00	239.41	1118.00
2.1	Нийгмийн хангамжийн байгууллага	115.24	461	115	461
2.2	Төрийн үйлчилгээний байгууллага	41.24	136	41.24	136.00
2.3	Төрийн бусад байгууллага	14.01	61	14	61
2.4	Хувийн ААН	68.92	460	68.92	460.00
2.5	Инженерийн байгууламж бүхий газар	766.59	181	0	0
2.6	Цэцэрлэгжүүлэх шаардлагатай	125.01	71.00		
III	ТУСГАЙ ЗОРИУЛАЛТТАЙ ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТ	143.29	113.00	0.00	0.00
	НИЙТ	10844.69	3578.00	509.64	2925.00

Улаанбаатар хотын хэмжээнд нийт 10844.69 га газрын 3578 нэгж талбарт цэцэрлэгжсэн болон цаашид цэцэрлэгжүүлэх боломжтой талбай байгаагийн ихэнх нь буюу 95% нь цаашид цэцэрлэгжүүлэх боломжтой талбай, 5% нь одоогийн байдлаар цэцэрлэгжсэн талбай байна. Мөн нийт цаашид цэцэрлэгжүүлэх боломжтой газрын 8.7% буюу 895.28 га нь Улаанбаатар хотын хойд бүс дэхь суурьшилд хамаарах ногоон бүс байна.

Дүгнэлт, санал зөвлөмж

1. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ангилал, бүртгэл, тогтоосон хувь хэмжээний стандартын эрх зүйн болон бусад үндслэх баримт бичгийг судлахад Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ангилал бүртгэлийн талаар үндсэн 4 баримт бичиг байна.
2. Төрийн нийтийн өмчийн бүртгэлийн систем байхгүй тул хотын ногоон байгууламжийг кадастрт бүртгэх боломжгүй байдалтай байна.
3. **Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм БНБД 30-01-04**-д Хот суурины барилгажсан нийт талбайн **40%**-иас багагүй, Орон сууцны хорооллын ногоон бүсийн нэг хүнд ногдох талбай 6м^2 -с багагүй, **Хот байгуулалтын тухай хуульд** Төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн **30**-аас доошгүй хувь, Барилгажих талбай нь тухайн газрын **70** хувиас илүүгүй, **Барилгын тухай хуулинд** Барилга байгууламжийн гадна тохижилтын талбай, ногоон байгууламж хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичигт заасан хэмжээнээс багагүй, **Газрын тухай хуулинд** Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын **10**-аас доошгүй хувийг тооцно хэмээн тус тус өөр ххоорондоо ялгаатай заалтууд орсон байгаагаас үүдэн нийслэлийн ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэхгүй, эзэнгүйдэх, арчилгаа тордолгооны асуудал орхигдох зэрэг асуудал тулгарч байгаа юм. Иймээс Улаанбаатар хотын ногоон байгууламжийг нарийн бүртгэх, тоолох, жил бүр мэдээ тайлан гарч байх шаардлага зүй ёсоор тулгарч байна.
4. Улаанбаатар хотын хэмжээнд нийт 10844.69 га ногоон байгууламж байгаа бөгөөд үүнийг дүүргээр ангилбал хамгийн их ногоон байгууламжтай дүүрэг нь нийт ногоон байгууламжийн 27% буюу 929 талбарын 138.61 га газарт ногоон байгууламж байгуулснаараа БЗД, хамгийн бага ногоон байгууламжтай дүүрэг нь ЧД бөгөөд нийт 221 талбарын 20.72 га газарт ногоон багууламжтай ба нийт ногоон байгууламжийн 4% -ийг тус тус эзэлнэ. Түүнчлэн ногоон байгууламжийг аль хороололд байршилтай эсэхээр нь харвал нийт ногоон байгууламжийн 84% нь байшин хороололд, 16% нь гэр хороололд байна.

Ашигласан материал

1. Чимид.Б, Магсаржав.Ө Хотын цэцэрлэгжүүлэлтийн ажлын онол практикийн асуудал. УБ.2004.
2. Чимид.Б, Энхсайхан.Д. Банзрагч.Ц. “Хөгжил дэвшлийн 90 жил”/Ойн салбарын/ УБ.2014.
3. Хотын цэцэрлэгжүүлэлтийн ажлын онол практикийн асуудал бага хурлын хураангуй. УБ. 2004 он..
4. Чимид.Б. “Ногоон байгууламж нэмэгдүүлэх замаар Улаанбаатар хотын экологийн нөхцөлийг сайжруулах нь” УБ.2008
5. Чимид.Б. “Орчноо цэцэрлэгжүүлье” УБ. 2004
6. Чимид.Б. “Хот тохижилтын ажилд тавигдах стандартын шаардлага. УБ.2009
7. Чимид.Б. “Хотын ногоон байгууламж бага ландшафт дендрологийн үндэс. УБ.2011.
8. “Хотын ногоон байгууламж” УБ.2011. Улаанбаатар дээд сургууль.
9. “Цэцэрлэгжүүлэлтийн холбогдолтой стандартын эмхтгэл”УБ.2011./СХЗГ/
10. Батчулуун.Ц, Цэнгэл.Б, Гэрэлбаатар.С.” Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламж” УБ.2016

HST-25

LOCAL CITIZEN'S OPPORTUNITY TO DEVELOP "SAND TOURISM" IN ELSEN TASARKHAI AREA

/Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй айл өрхүүдийн жишээн дээр/

*С.Мөнхнасан^а (М.А.), Т.Оюунчимэг^б (Ph.D), Ц.Должинсүрэн^в
^аМУИС, АЖГХС, ^бХААИС, Агроэкологи ^вМУИС, АЖГХС
Холбоо барих зохиогч: s.munkhnasan@mnun.edu.mn.*

Хураангуй:

At a time when Mongolia is heavily affected by desertification and is the focus of global attention, the use of sand, especially manganese sand, for tourism may be the most effective way to combat desertification. Environmental protection is one of the most pressing issues in the "Elsen tasarkhai" region, and tourism (especially creative tourism) is seen as a source of revenue to mitigate this.

Local people support tourism development, but lack of experience and organization is a disadvantage. The residents of "Elsen Tasarkhai" need professional training, counseling, and cooperation with the community and the protection administration to conduct tourism activities.

In order to develop community-based tourism in the vicinity of "Elsen Tasarkhai", it is necessary to develop "Sand sports, arts and culture tourism" regionally based on regional specifics. According to a survey of local households, it is important to support the use of sand for tourism, create local brand souvenirs, establish herder communities and start working in 2021.

Түлхүүр үг:

Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал, Элсний спорт аялал жуулчлал, Гайхар буюу Үзмэр, Жуулчны зорин очих газар, Байгалийн Цогцолборт Газар, Sand Art буюу элсний урлаг, сувинер.

Удиртгал

Хүн төрөлхтөний тогтвортой хөгжлийн нэгэн гарцыг утаагүй үйлдвэрлэл хэмээн нэрлэгдэх аялал жуулчлалын салбар хэмээн үзэж байгаа энэ цаг үед Монгол улс аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэлийн нэг болгон хөгжүүлэхээр “Алсын хараа-2050” бодлогын баримт бичигт тусгасан байдаг.

Ийм учраас жуулчны зорин очих газрыг хөгжүүлэх, аялал жуулчлалын шинэ нөөц, төрөл хэлбэрүүдийг судлан тодорхойлж аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоход хувь нэмэр оруулах зорилгоор элс хэмээх байгалийн нөөцийг аялал жуулчлал, байгаль орчныг хамгаалах, ашиглах талаар нутгийн иргэдийн нөөц бололцоо, хүсэл сонирхлыг судлах шаардлагатай болсон. Элс бол зөвхөн барилгын материал, шил толиний түүхий эд төдийхөн биш эдийн засгийн өргөн цар хүрээтэй төдийгүй аялал жуулчлалын чухал нөөц юм.

- Монгол орон нь цөлжилтөд ихээр өртөн дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа өнөө цагт элс, тэр дундаа манхантай элсийг аялал жуулчлалд ашигласнаар цөлжилтийн эсрэг хийх хамгийн үр дүнтэй арга байж болох юм.
- Элсэн тасархай хэмээх энэхүү бүс нутагт байгаль орчныг хамгаалах асуудал нь тулгамдсан асуудлуудын нэг бөгөөд үүнийг саармагжуулах орлогын нэг үүсвэр нь аялал жуулчлал /ялангуяа бүтээлч аялал жуулчлал/ хэмээн үзэж байна.
- Аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлж буй нутгийн иргэдэд тулгамдаж буй асуудлуудыг судалж түүнийг хэрхэн шийдвэрлэх арга замыг судлах шаардлагатай.

Дээрх үндэслэлүүдийг дэвшүүлэн Элсэн тасархай орчимд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй иргэд, айл өрхүүдийг дэмжих, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох хэрэгцээ

шаардлага байгаа хэмээн үзэж энэхүү өгүүлэлийг гүйцэтгэлээ.

Судалгааны арга зүй:

Энэхүү судалгааг “Анкет судалгааны арга”, “SWOT анализын арга”, “Эх зохиол судлах арга”, “Санамсаргүй түүврийн арга”, “SPSS шинжилгээний арга” зэргийг ашиглан боловсруулав.

Судлагдсан байдал:

2000 онд Монгол Солонгосын эрдэмтэд хамтран Хөгнөхаан ууланд тоймчилсон судалгааг явуулж байсан. 2010 оноос ШУА-ийн Геоэкологийн хүрээлэн Байгалийн Цогцолборт Газрын хамгаалалттай бүс дэх Элсэн тасархайд “Цөлжилтийг сааруулах туршилт судалгааны төв”-ийг байгуулан, хамгаалалтын захиргаатай хамтарч аялал жуулчлалын нөөц боломжийг судалсан.

2018-2022 оны “Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газрын Менежментийн төлөвлөгөө”-нд рекреацийн нөхцөлийн үнэлгээ, аялал жуулчлалын нөлөөлөл, өрсөлдөх чадварын үнэлгээг тус тус тодорхойлсон байна. Гэвч эдгээр судалгаанд нутгийн иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад ямар бэрхшээл тулгарч байгаа талаар нарийвчлан судлаагүй байна.

Судалгааны зорилго, зорилт:

Энэхүү судалгааны ажлаар Хөгнө Тарны Байгалийн Цогцолборт Газрын Элсэн тасархай орчимд аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж буй өрх айлуудад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлж түүнийг даван туулахад элсний аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжийг дэвшүүлэх зорилго дэвшүүлээ.

Уг зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүллээ. Үүнд:

- Элсэн тасархай орчмын бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлж буй өнөөгийн байдлыг судлах
- Элсэн тасархайн нутгийн иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох
- Элсэн тасархай орчимд нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж арга замыг тодорхойлох

“Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал”

“Байгалийн Цогцолборт Газар” гэдэг нь байгалийн үзэсгэлэнт төрх байдалтай, удам газар нутгийг хамарсан нэг ба түүнээс олон тооны экосистемийг хамгаалах зорилго бүхий шинжлэх ухаан, боловсрол, танин мэдэхүйн, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хэлнэ. (Т.Оюунчимэг, 2016, хууд. 119)

Аялал жуулчлал нь олон салбарын уулзварт тал бүрийн сүлжээ, холбоосын тусламжтайгаар оршдог тул хүний, нийгмийн, улс төрийн, экологийн, хүнсний, эрх зүйн, соёлын, мэдээллийн зэрэг олон талын нөлөөлөлд автаж байдаг. (М.Билэгсайхан, 2014, хууд. 17)

Олон нийтэд түшиглэсэн аялал жуулчлал нь аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлэх зорилгод хүрэхийн тулд аялал жуулчлалын гол элемент болох олон нийтийн оролцоог багтаасан альтернатив аялал жуулчлалын нэг төрөл юм (Sharpley, 2008)

Аялал жуулчлалын үйл ажиллагаа, хөгжилд орон нутгийн иргэдийн оролцоо, дэмжлэгийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас орж буй орлогыг шударга хувиарлан орон нутгийн иргэдэд хүргэх зорилготой аялал жуулчлалыг “Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал” гэдэг.

- ❖ Ихэнхдээ тэдний зорилго бол аялал жуулчлалаар дамжуулан амьдралын түвшинг дээшлүүлэх, хүрээлэн буй орчныг хамгаалах явдал юм. (<https://www.sumak-travel.org/>, 2021)
- ❖ “Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал” нь Азид тухайн орон нутгийн онцлог, соёл, зан заншил зэргээс хамааран өөр хоорондоо ялгаатай хөгжиж байна. Тухайлбал, Тайландад “Орон нутагт тулгуурласан байгалийн Аялал”, Камбож, Индонез болон Монголд “Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал” г.м

- ❖ Аялал жуулчлалыг хөгжүүлэх, төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих ажилд олон нийт оролцох ёстой бөгөөд аялал жуулчлалын үйл ажиллагаанаас нутгийн иргэд мөн адил их ашиг хүртэх ёстой. (Sutresna Ida Bagus, 2019)

“ХӨГНӨ ТАРНЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗАР”-ЫН ЭЛСЭН ТАСАРХАЙ ОРЧИМД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ХӨГЖИЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Нутгийн иргэд:

Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газрын бэлчээрийн нөөц газар нь 69720 га бөгөөд жил бүр даацаас хэтэрсэн мал өвөлжиж, хаваржиж байна. Бэлчээрийн даац 2014-2017 онуудад 1,2-2,3 дахин хэтэрсэн мал өвөлжиж байжээ.

Хүснэгт 1.

Хөгнө-Тарнын БЦГ-ын аялал жуулчлал, хязгаарлалтын бүсэд байршиж буй айл өрх, малын судалгаа /2017 оны жилийн эцсийн байдлаар /


Засаг Захиргаа	Өрхийн тоо	Хүн ам	Өвөлжөө, хаваржаа			Малын тоо төрөл				Бүгд
			Зөвшөөр - өгдсөн	Зөвшөөрөг-дөөгүй		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	
Рашаант	74	57	33	37	116	1404	909	11206	7534	21169
Гурванбулаг	177	549	52	32	49	3916	3102	30345	22003	59415
Бүрд	36	122	23	12	71	1331	787	11520	7314	21023
Д Ү Н	189	928	108	81	236	6651	4798	53071	36851	101607

Түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалж, өвлүүлэн үлдээх, аялагч жуулчдын үзэж сонирхох, тэдний анхаарлыг татахуйц хэмжээнд үнэ цэнтэй бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор хамгаалах үнэт зүйлсийн нэг болгон сонгосон. Өнөөгийн байдлаар түүх соёлын дурсгалт газрууд нь жуулчдын сонирхлыг татахуйц хэмжээнд хамгаалагдаж чадаагүй. Түүх соёлын дурсгалт газрыг аж ахуйн нэгж, байгууллага, нутгийн иргэдэд 100 хувь гэрээгээр хариуцуулах замаар хариуцан хамгаалах эзэнтэй болгох ажлыг хэрэгжүүлж эхлээд байна.

Аялал жуулчлал:

Хөгнө-Тарнын БЦГ-ын Элсэн тасархайн бүс нутаг орчимд одоогоор аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхэлж гадаад, дотоодын аялагч жуулчид хүлээн авч үйлчилдэг 10 гаруй жуулчны бааз улирлын чанартай үйл ажиллагаа явуулж, 20 гаруй өрх гэр жуулчлалыг хөгжүүлж байна. (Хөгнө_Тарнын_БЦГ-ын_Хамгаалалтын_Захиргаа, 2018, р. 56)

Зураг 1. Хөгнө-Тарнын БЦГ-т ирсэн гадаад дотоодын жуулчдын тоо




Эх сурвалж: (Хөгнө_Тарнын_БЦГ-ын_Хамгаалалтын_Захиргаа, 2018)

Хамгаалалтын захиргаанаас малчдын амьдрал ахуйтай танилцах, түүх дурсгалт газраар явган болон морь, тэмээн аяллуудыг тодорхой маршрутуудыг гарган, танилцуулж, морин аяллыг Хөгнө Хаан уулын

орчмоос Өвөрхангай аймгийн Хархорин сум хүртэл аялуулах маршрутыг боловсруулсан байна.

Зураг 2. Жуулчны баазууд ба малчдын өвөлжөө
Хүний нөлөөлөл



Эх сурвалж: “Хөгнө Тарнын Байгалийн Цогцолборт Газрын менежментийн төлөвлөгөө. 2018 он

Маршрутууд: (Хөгнө Тарнын БЦГ-ын Хамгаалалтын Захиргаа, 2018)

1. *Явган болон морин аялал:* Монголд ирж буй жуулчдын дийлэнх нь хүний үйл ажиллагаанд өртөөгүй унаган байгальд идэвхтэй хэлбэрээр явган, морьтой аялахыг эрхэмлэдэг. Тус Байгалийн Цогцолборт Газрын хувьд нүүдэлчин малчид суурьшин амьдарч буй хэсгээр энэ төрлийн аяллуудыг зохион байгуулах боломжтой.
2. *Эко аялал:* Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газрын нутаг дэвсгэр дээр байгалийн хэд хэдэн бүслүүр орших тул экологи-газарзүйн янз бүрийн тархалттай олон зүйл хөхтөн амьтдын орших таатай нутаг болохоос гадна ургамалжилт нь ерөнхий шинжээрээ Монголын жинхэнэ хээр, Сибирийн тайгын бүс хоёрын завсрын бүсэд хамаардаг тул маш өвөрмөц онцлогтой. Иймээс энэ бүс нутагт байгалийн аяллыг зохион байгуулах бүрэн боломжтой.
3. *Шашны аялал:* Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газарт өндөр гэгээн Занабазарын үндэс суурь нь тавьсан домог түүхт Хөгшин, Залуу хийдийг түшиглэн дотоодын аялагчдын шашин мөргөлийн гол газар болохоос гадна гадаадын жуулчдын сонирхлыг ч гэсэн татаж байдаг.
4. *Түүх соёлын аялал:* Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газарт түүх соёлын олон дурсгалууд байдаг бөгөөд түүх, соёлын үнэт зүйлсийг олон нийтэд таниулах өргөн боломжтой юм.
5. *Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал:* Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газар нь байгаль, газарзүйн тогтцын хувьд уламжлалт мал аж ахуй архлэн хөтлөх нэн тохиромжтой өлгий нутаг бөгөөд нутгийн иргэдийн амжиргааг нүүдлийн соёл иргэншлийн илэрхийлэл болгон нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Учир нь тус нутгийн иргэдийн хувьд аялал жуулчлал хэмээх ойлголттой харьцангуй эрт холбогдсон, жуулчидтай харьцаж сурсан туршлагатай.

Хөгнө-Тарнын Байгалийн Цогцолборт Газарт аялал жуулчлал хөгжиж буй өнөөгийн байдалд хийсэн анализ:

Хүснэгт 2. SWOT анализ

<p>ДАВУУ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> • Хангай говийн хослол, байгалийн 3 бүслүүрийг нэг дороос харах боломжтой • Соёлын болон түүхийн дурсгалт газар олонтой • Байршлын хувьд УБ хоттой харьцангуй ойр • Дэд бүтэц сайтай • Босоо, хэвтээ тэнхлэгийн дагуух аялал жуулчлалын үндсэн замналуудын уулзвар • Ажиллагсад болон орон нутгийн иргэд аялал жуулчлалын харилцаанд оролцоод удаж байгаа 	<p>СУЛ ТАЛ</p> <ul style="list-style-type: none"> • Жуулчдад зориулсан сурталчилгаа дутагдалтай • Аялал жуулчлалын баазууд нэг доор хэт төвлөрсөн • Баазуудын үйлчилгээний чанар сул • Аялал жуулчлалын идэвхтэй үйл ажиллагаа явагддаггүй • Маркетингийн идэвхжүүлэлт тааруу • Гадаадын жуулчид болон дотоодын аялагчдын талаарх мэдээллийн нэгдсэн сан байхгүй • Орон нутгийн аялал жуулчлалын нэгдсэн бодлого байхгүй
<p>БОЛОМЖ</p> <ul style="list-style-type: none"> ▪ Соёлын, байгалийн, адал явдалт, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой ▪ Бусад ТХГН–уудтай хамтран ажиллах замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэх ▪ Азийн жуулчдыг соёлын болон шашны аялалд татан оролцуулах ▪ АЖ–ын үйлчилгээний чанарыг сайжруулсанаар жуулчдыг нэмэгдүүлэх 	<p>АЮУЛ</p> <ul style="list-style-type: none"> ▪ Түүх, соёлын дурсгал байгалийн нөлөөлөл болон аялагчдын нөлөөллөөс эвдэрч гэмтэх ▪ Бусад аялал жуулчлалын гол газруудад жуулчдаа алдах ▪ Орчны бохирдол ▪ Дотоодын жуулчдын зохион байгуулалтгүй аяллаас үүдэлтэй сөрөг нөлөөллүүд

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БУЙ НУТГИЙН ИРГЭДИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА

Судалгааны зорилго, үйл явц

- Судалгааны арга аргачлалаа боловсруулж:
- Элсэн тасархай орчмын малчин өрхүүдээс түүврийн аргаар авсан судалгааны үр дүнгээ гаргах, дүгнэлт хийх;
- Малчин өрх айлуудаас санамсаргүй тохиолдлоор, түүврийн аргаар 24 ($n=24$) хүнээс /өрх айлыг төлөөлж/ асуулгын хуудсаар санал авч хариуг нь SPSS программд шивж, боловсруулалт хийсэн болно. Судалгаанд ашиглагддаг тогтсон, нийтлэг загвар ба аргуудыг хослуулан гүйцэтгэв.

Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн:

- Судалгааг дескриптив загвараар боловсруулахад 2020 оны 07 дугаар сараас 2020 оны 08 дугаар сарын хооронд “Өрх айлуудаас авах анкет судалгаа” сэдэвт судалгааны асуумжийг ашиглав.

“Өрх айлуудаас авах анкет судалгаа” сэдэвт судалгааны асуумж:

Өрх айлуудаас авах анкет судалгааны асуумж нь малчин өрхүүдээс нэг гишүүнээр нь бөглүүлсэн болно. Асуумжийн бүтэц:

1. Ерөнхий хэсэг
2. Элсэн тасархайн талаарх иргэдийн ойлголт
3. Элсэн тарамцагийн ашиглалтын тухай
4. Элсэн тасархай орчимд үзүүлж буй сөрөг нөлөөллийн тухай
5. Нэмэлт асуулт
6. Тэмдэглэл

Судалгаанд оролцогчдын байр суурийг тодорхойлох, тулгарч буй асуудлуудыг илэрүүлэх зорилгоор нээлттэй 6 асуулга, олон хариулттай хувилбарт асуулт 11, нийт 17 асуулга бүхий судалгаа болно.

Судалгааны үр дүн, дүгнэлт

Хүснэгт 3. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн насны байдал

Сумын төвөөс * Frequencies SPSS 23.0 программ

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	1-3	1	4.2	4.2	4.2
	15-18	2	8.3	8.3	12.5

	19-25	20	83.3	83.3	95.8
	26-80	1	4.2	4.2	100.0
	Total	24	100.0	100.0	

Хүснэгт 4. Аялал жуулчлал эрхэлж буй өрх айлуудын байршил


		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Хөгнө хан	17	70.8	70.8	70.8
	Сансар	4	16.7	16.7	87.5
	бичээгүй	3	12.5	12.5	100.0
	Total	24	100.0	100.0	

Хүснэгт 5. Аялал жуулчлалаас гадна эрхэлж буй ажил

Ажил эрхлэлт * Frequencies SPSS 23.0 программ

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Мал аж ахуй	11	45.8	45.8	45.8
	Газар тариалан	1	4.2	4.2	50.0
	Жижиг бизнес эрхлэлт	4	16.7	16.7	66.7
	Хөдөлмөр эрхлэдэггүй	5	20.8	20.8	87.5
	бөглөөгүй	3	12.5	12.5	100.0
	Total	24	100.0	100.0	

Зураг 4. Судалгаанд хамрагдсан өрх айлуудын хөдөлмөр эрхлэлт



Хүснэгт 6. Элсэн тарамцагийн талаарх иргэдийн ойлголт:

Элсний тухай ойлголт	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Байгалийн үржил шимгүй хэсэг	4	16.7	16.7	16.7
Байгалийн өвөрмөц газар	19	79.2	79.2	95.8
Хариулаагүй	1	4.2	4.2	100.0
Нийт	24	100.0	100.0	

Хүснэгт 7. Элсийг хэрхэн үнэлдэг талаарх иргэдийн ойлголт

Элс үнэ цэнэтэй юу?	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Үнэ цэнэтэй	15	62.5	62.5	62.5
Мэдэхгүй	9	37.5	37.5	100.0
Total	24	100.0	100.0	

Зураг 5. Нутгийн иргэдийн “Элсэн тарамцаг”-ийн ашиглалтын тухай:



Хүснэгт 8. Элсийг нутгийн иргэд хэрхэн ашиглаж буй талаарх судалгаа

Үйл ажиллагааны чиглэл	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Элс орчмын гадаргын ус, баянбүрдээр	4	16.7	16.7	16.7
Элс орчмын ховор амьтан, ургамлаар	3	12.5	12.5	29.2
Аялал жуулчлал	11	45.8	45.8	75.0
Бусад	3	12.5	12.5	87.5
Бөглөөгүй	3	12.5	12.5	100.0
Total	24	100.0	100.0	

Элсэн тасархай орчимд аялал жуулчлал хөгжихөд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг шийдэх боломж, арга зам

№	Саналууд	Оролцогчдын бичсэн давхардал
1	Аялал жуулчлал хөгжих, боломжийг бий болгох шаардлагатай	1
2	Байгаль орчны ажилчид илүү анхаарч ажиллах шаардлагатай	2
3	Жуулчдад хог хаях эсэхийг байгаль орчны газраас анхаарах	1
4	Засаг, захиргаа болон ард иргэдтэйгээ нийлж анхаарах цаг болсон	1
5	Худаг, эко бие засах газар, хогийн сав эрүүл ахуй талаасаа дутмаг, бие засах газрыг байнга ажиллуулах	4
6	Танилцуулга, мэдээллийн самбар дутмаг	1
7	Элсний нүүдэл ихсэж байна	1
8	Айл өрхийн тоо жилээс жилд өсөж байна. Малаас малын хөлийн татвар авах	1

Элсийг аж ахуйдаа хэрхэн ямар байдлаар ашиглаж ирсэн уламжлалын талаар тайлбарлана уу?

№	Саналууд	Давхардсан саналын тоо
1	Малаа элсний ургамал идүүлж тарга гэвээргэ авхуулах	2
2	Барилга байгууламж барих, барилгын засварын ажилд	3
3	Төмс ногоо, мод тарихад тохиромжтой	1
4	Элсийг эмчилгээ, эрүүл мэндэд ашиглах сонирхолтой, бөөр нуруунд бүлээн элсийг ашиглаж ирсэн	4
5	Зүлэг тарихад ашигладаг	1

Элсэн тасархай орчимд “Нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал” хөгжүүлэх боломж “Аялал жуулчлалын судалгаа, Инновацын төв” ТББ-ийн үйл ажиллагаа

- ❑ Бүс нутгийн аялал жуулчлалын хөгжлийн онцлог, нөөц, голлох хүчин зүйлсийг судлах
- ❑ Орон нутгийн иргэд аялал жуулчлалд оролцох хүсэл сонирхол байгаа эсэхийг тодруулах
- ❑ Орон нутгийн иргэдийн соёл, уламжлал, ахуй амьдралын онцлог, давуу талыг судлаж аялал жуулчлалын нөөцийн судалгаа хийх
- ❑ Нутгийн иргэдийг аялал жуулчлалд сургах
- ❑ Нутгийн иргэдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулж нөхөрлөл, хоршоолол үүсгэх
- ❑ Иргэдийн нөхөрлөлийн гадаад, дотоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх, сүлжээнд холбох

Нутгийн иргэдийн хийх үйл ажиллагаа:

- Иргэд аялал жуулчлал эрхлэх хүсэл сонирхолоороо нэгдэж нөхөрлөл үүсгэн байгуулах
- Нөхөрлөл бүр өөрсдийн онцлогтой ямар бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох талаар нөөцдөө тулгуурлан төлөвлөлт хийх
- Уламжлалт ахуй соёл, амьдралын хэв маягаа даяаршлын өөрчлөлтөнд оруулахгүй хадгалан авч үлдэх
- Байгаль орчны үзэсгэлэнт, унаган төрх байдлыг хадгалан байгаль хамгаалалд хувь нэмрээ оруулах
- Аялал жуулчлалын үйлчилгээний соёлд суралцаж гадаадын жуулчидтай харилцах ур чадвар эзэмших
- Нөхөрлөлүүдийн үйлчилгээний эрүүл ахуй, аюулгүй байдлыг дээд зэргээр хангах


Элсэн тасархай орчимд нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлал хөгжүүлэх боломж:

Элсэн тасархай орчмын аялал жуулчлалын маркетингийг сайжруулах:		
№	Хийх зарим арга зам	Хэрэгжүүлэх боломж
1	Элсний спорт аялал жуулчлалыг хөгжүүлэх, элсэн тасархайн бүс нутгийн имидж болгох	Төв замын урд хэсэгт спорт цогцолбор байгуулах
2	Элсийг ашиглан энэ бүс нутгийн брэнд сувинер, бэлэг дурсгалын зүйл бий болгож малчдын нөхөрлөлөөр дамжуулан үзэсгэлэн худалдаа явуулах	
3	Богино хугацаа, зайд морь, тэмээ унуулах үйлчилгээ	

Зураг 6. Элсэн тасархайн Аялал жуулчлалын бүс



Зураг 7. Элсэн тасархайн аялал жуулчлалыг бүсчлэх нь



Дүгнэлт

Энэхүү судалгааг хийснээр дараах дүгнэлтийг хийж байна.

- Элсэн тасархай орчмын бүс нутаг нь аялал жуулчлалын гол чиглэл дагуу орших тул дайран өнгөрөх дотоод гадаадын жуулчид их боловч цаашид энд хоноглох шалтгааныг бий болгох, зорин очих бүтээгдэхүүнтэй болгох шаардлага хэдийн үүсжээ.
- Нутгийн иргэд аялал жуулчлал хөгжүүлэхийг дэмжиж байгаа ч туршлага, зохион байгуулалтгүй байгаа нь сул тал болж байна.

- Элсэн тасархайн нутгийн иргэд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахад мэргэжлийн сургалт, зөвлөгөө, иргэд хоорондын болон хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах шаардлагатай байна.
- Элсэн тасархай орчимд нутгийн иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэхдээ бүс нутгийн онцлогт тулгуурлан “Элсний спорт, урлаг соёлын аялал жуулчлал”-ыг бүсчлэн хөгжүүлэх нь зүйтэй.
- Нутгийн өрх айлуудаас авсан судалгаанаас үзэхэд элсийг аялал жуулчлалд ашиглахыг дэмжиж нутгийн брэнд сувинер бий болгох, малчдын нөхөрлөлүүдийг үүсгэн байгуулж төлөвлөгөөтэй ажиллах зэрэг үйл ажиллагааг 2021 онд хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй.

Ном зүй:

<https://www.sumak-travel.org/>. (2021). Retrieved from <https://www.sumak-travel.org/community-based-tourism-a-tool-for-sustainable-development/>

Sharpley, T. a. (2008).

Sutresna Ida Bagus, W. S. (2019). COMMUNITY BASED TOURISM AS SUSTAINABLE TOURISM SUPPORT. *Russian Journal of Agricultural and Socio-Economic Sciences* 94(10):70-78, 76.

М.Билэгсайхан. (2014). *Аялал жуулчлалын онол, практик, технологийн асуудал*. Улаанбаатар: МУИС хэвлэх үйлдвэр.

Т.Оюунчимэг. (2016). *Байгалийн нөөцийн ашиглалтын эрх зүй*. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Хөгнө_Тарнын_БЦГ-ын_Хамгаалалтын_Захиргаа. (2018). *ХӨГНӨ ТАРНЫН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ*. Булган, Рашаант сум.

Зохиогчийн танилцуулга:

- А. С.Мөнхнасан, Монгол улс, МУИС, АЖГХС-ийн захирал, 91110256, s.munkhnasan@mnun.edu.mn, М.А
- Б. Т.Оюунчимэг, Монгол улс, ХААИС, Агрэкологийн сургуулийн профессор, 99031969, oyun8513@gmail.com, Ph.D
- В. Ц.Должинсүрэн, Монгол улс, МУИС, АЖГХС-ийн АЖМ-4 ангийн оюутан, 99903675, doljinsurentsogetgerel@gmail.com.

ХАВСРАЛТ

Өрх айд,уудаас авах анкет судалгаа	
Орхний байршил	Судалгаа өгсөн хүний
* Сумын төвөөс: <u>Дам</u>	А Мал аж ахуй Б Газар тариалан
* Байгын нэр: <u>Т.Оюунчимэг</u>	В Уул уурхай Г Жижиг бизнес эрхлэлт
* Элсэн тасархай орчимд эхэн жил амьдарч байгаа	Д Хөдөлмөр эрхлэлтгүй
	Е
Элсэн тармагийн талварх үрснийн ойлголт	
1. Элсэн тармагийн талвар таны ойлголт	А Байгалийн үрэлд шимгүй хэсэг Б Байгалийн өвөрмөц газар В Мал аж ахуйд ашиггүй газар Г Мэдэхгүй Д Хариулаагүй Е Бусад
2. Элс үнэ цэнэтэй юу?	А Үнэ цэнэтэй /Тийм бол жагсаа/ Б Үнэ цэнэтэй Г Мэдэхгүй Г Бусад
Элсэн тармагийн ашиглалтын тухай	
3. Танайх жилийн эхэнд хугацаанд элс орчмын бүс нутгийг ашигладаг вэ?	А 3-н Б 3-н, намар В 4-н улирал Г Ашигладаггүй
4. Элсний ашиг шимийг яаж хүртэж байна вэ?	А Элс орчмын гадаргин ус, баянбүрэлээр Б Элс орчмын бүс нутгийн хоёр амтат, ургамалар В Халдан Г Аялал жуулчлалаар Д Бусад
5. Элсийг байгальд сөрөг нөлөөгүй байдалар аялал жуулчлалд ашиглах талвар таны санал болов.	А Элсийг аялал жуулчлалд ашиглах нь зөв Хэрэв зөв гэж үзэж байвал танд ямар санал байна вэ? Б Элсийг аялал жуулчлалд ашиглах нь буруу
6. Элсийг энэ бүс нутгийн брэнд болгон олох нийтэд таниулах талвар таны санал	А Элс бол манай нутгийн онцлог тул сурталчлах нь зөв Б Элс бол цогцолтийн сөрөг нөлөөтэй тул элсийг сурталчлах нь буруу
7. Элсээр гар урлалын зүйл, бэлэг дурсгалын зүйл хийх талвар сурах сонирхолтой эсэх	А Элсээр бүтээгдэхүүн хийх талвар сурах сонирхолтой Б Элсээр бүтээл хийх сонирхолгүй, хэрэггүй
Элсэн тасархай орчимд үзүүлж буй сөрөг нөлөөгийн тухай	
8. Таны бодлоор Элсэн тасархайн элсэн манханд сөрөг нөлөө үзүүлж буй хүчин зүйлс юу вэ? (Олон сонголттой)	А Уур амьсгал өөрчлөлт (хуурайшил, дулаарал, тэн) Б Элсийн нүүрэл (салхины нөөцлөлөөр) В Манхны тоо ихсэж, элс орчмын баянбүрэлд бэлчээрийн даац хэтрэх Г Халдан ашиглалт Г Аялал, амрагчдын хог хаягдал, сөрөг Д Зам, замын ашиглалт Е Мэдэхгүй З Элсний сөрөг нөлөө үзүүлдэг зүйл байхгүй Д Бусад
9. Таны бодлоор танай нутгийн элсний газар сүүлийн 10 жилд хэрхэн өөрчлөгдсөн орсон бэ?	А Талбай багассан Б Тасбай ихссэн В Өөрчлөгдсөгүй Г Мэдэхгүй Д Элсэн манханы ондөр нэмэгдсэн Е Манханы ондөр намссан Д Бусад
10. Элс орчмын ургамал, амьтны төрөг зүйлийн өөрчлөлтийн талварх ашиглалт	А Ургамалын бүрхсэн ховорлож багасч байгаа Б Элс орчмын амьтдын тоо толгой буурч байгаа В Ургамал, амьтдын тоо толгой, хэмжээ нэмэгдэж байгаа
Нэгэлт асуулт	
11. Элсэн тасархай, элсний талварх домог мэдлэг эсэх	А Үгүй Б Тийм бол тэмдэглэж авч болох эсэх
Тэмдэглэл:	
12. Элсэн тасархай орчимд аялал жуулчлал хөгжихөд тулгамдаж буй асуудал, тэдгээрийг хэрхэн шийдэх талвар өөрийн саналаа өгнө үү?	<u>Хуудал, хөгжим, утас</u>
13. Элсийг аж ахуйдаа хэрхэн, ямар байдалар ашиглаж ирсэн уламжлалын талвар тайлбарлана уу?	<u>Тиймийн хэрхэн олох чөлөө</u>
14. Хэрэв та наашад Аялал жуулчлалын чиглэлээр сургалт авах, судалгааны багтай хамтран ажиллах хүсэлтэй бол холбоо барих утасаа үлдэнэ үү? Утас 1: <u>99634492</u> Утас 2: <u>99634492</u>	Баарцалдаг.

GSES-21

Scientific base for increasing volume and ecological and economic assessment of scots pine plantation (*Pinus sylvestris* L.) In mongolia

G.Batsaikhan¹, B.Shurentsetseg²

¹ Division of Forest Resources and Forest Protection, Institute of Geography and Geoecology, Mongolian Academy of Sciences, Ulaanbaatar, Mongolia;

² Department of Ecology, School of Agroecology, Mongolian University of Life Sciences, Ulaanbaatar, Mongolia;
batsaikhang@mas.ac.mn,
shuree_0711@mul.s.edu.mn

ABSTRACT: The survey was conducted in Scots pine plantation (N50°11'27.2", E 106°26'30.8") of Tuijin Nars National park in Selenge province. The aim of the research is to identify the scientific base for increasing volume and ecology-economic value of Scots pine plantation (*Pinus sylvestris* L.) In Mongolia. Sample plots establishment, model trees felling, measurement and development of primary research data and raw materials was conducted methodology by N.P.Anuchin (1982), A.V.Pobedinsky (1962), Z.Tsogt (1993), and J.Tsogtbaatar (1994), according to the methodology of N.G. Geogievsky (1953) experimental research on maintenance thinning cut of scots pine plantation was carried out in selected area. According to the survey, in 2003, 1 sample plot was established in the planted stands without thinning, and 3 sample plots were established in the planted stands of different intensities, and a total of 980 trees were measured. Ecological and economic assessment of planted pine forest was carried out by ecological and economic assessment of one cubic meter of forest ecology and economic evaluation methodology. Ecological and economic benefits are calculated in two ways: direct and indirect, with direct benefits representing timber productivity and indirect benefits representing ecological and biological productivity (Ganzorig et al., 2019). The experimental research was carried out in uncut control stand of 15-year-old planted pine trees planted in 2003 in the spring of 2016, and in sites felled suppressed trees by low (14.4%), medium (30.2%) and the highest (46.6%) intensity thinning, and in site with pruning all the branches only the lower part of the crown up to 1.3 m in stem height. Each treatment was carried out within a 5-hectare parcel, in which, a 25.0 x 20.0 m (500 m²) rectangular-shaped sample plot was established randomly in the center.

